



ЖИЛИЙН ТАЙЛАН

2013

# 1

## Агуулга

- |    |  |       |
|----|--|-------|
| 1  | Ерөнхийлөгчийн илгээлт                             | >> 4  |
| 2  | Гүйцэтгэх захирлын илгээлт                         | >> 6  |
| 3  | Санхүүгийн үзүүлэлтүүд                             | >> 8  |
| 4  | Худалдаа, хөгжлийн банк 2013 онд                   | >> 11 |
| >> | Онцлох үйл явдлууд                                 |       |
| >> | Нийгмийн хариуцлага                                |       |
| >> | Шагнал, өргөмжлөл                                  |       |
| 5  | Худалдаа, хөгжлийн банкны бүтэц                    | >> 15 |
| 6  | Компанийн засаглал                                 | >> 16 |
| 7  | Төлөөлөн удирдах зөвлөл / Гүйцэтгэх Удирдлагын баг | >> 18 |

---

# 2

---

## Агуулга

8	Байгууллагын бизнесийн үйл ажиллагаа	>> 19
9	Иргэдийн бизнесийн үйл ажиллагаа	>> 22
10	Гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа	>> 25
11	ТиДиБи Капитал ХХК	>> 27
12	Хөрөнгө зохицуулалтын удирдлага	>> 29
13	Эрсдэлийн удирдлага	>> 31
14	Мэдээллийн технологи	>> 34
15	Хүний нөөцийн удирдлага	>> 36
16	Ностро данстай банкууд	>> 38
17	Аудитын тайлан	>> 39

## Ерөнхийлөгчийн мэндчилгээ

Эрхэм хүндэт харилцагч,  
хамтран ажиллагч түншүүд,  
ноёд хатагтай нараа,



A handwritten signature in black ink that reads "Randolph A. Koppa". The signature is fluid and cursive.

**Рандолф Коппа**

Ерөнхийлөгч

“

Дэлхийн нийтээр, түүний дотор БНХАУ - ын эдийн засгийн өсөлтийн хурдац саарч байгаа сүүлийн жилүүдэд, Монгол улсын эдийн засаг өсч байгаа энэ цаг үед Худалдаа, хөгжлийн банк 2013 оны өөрийн үйл ажиллагааны ололт амжилт, санхүүгийн тайлангаа Та бүхэнд толилуулж байгаадаа туйлын таатай байна.

”



ХХБ нь Монголын банк санхүүгийн салбарын тэргүүлэгч банк бөгөөд улс эх орныхоо эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс олон улсын хэмжээний томоохон санхүүжилтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, 2013 онд Нидерландын Хөгжлийн Банк (FMO) болон олон улсын ING банктай 82 сая ам.долларын “Хамтын санхүүжилтийн зээл” – ийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн нь ХХБ - ны олон улс дахь нэр хүндийг бататгаснаас гадна харилцагчдынхаа зээлийн хэрэгцээг санхүүжүүлэх, тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийг санхүүжилтээр дэмжсэн үйл явдал болсон юм.

Түүнчлэн, ХХБ - ны 2013 оны санхүүгийн жилд хийж бүтээсэн ажил, амжилт бүхнийг бататган, олон улсын нэр хүнд бүхий “Euromoney” сэтгүүлээс 2013 оны “Монгол улсын шилдэг банк”, Их Британи улсын “Global banking & finance review” байгууллагаас “2013 оны Монгол улсын арилжааны шилдэг банк”, “Global Trade Review” байгууллагаас “Монгол улсын Худалдааны санхүүжилтийн шилдэг банк” - аар 3 дахь жилдээ тус тус өргөмжилсөн нь манай банкны нэр хүндийг олон улсын түвшинд өргөсөн явдал байв.

Мөн 2013 оны томоохон онцлох үйл явдал нь ХХБ - ны охин компани болох “Ти Ди Би Капитал” ХХК болон Япон улсын “Эм Жи Лизинг” Корпораци хамтран, олон улсын санхүүгийн стандартад нийцсэн Монголын хамгийн том санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэгч “Ти Ди Би Лизинг” ХХК - ийг үүсгэн байгууллаа.

ХХБ нь Монгол улсад анх удаа 700 сая юанийн оффшор бондыг Сингапурын хөрөнгийн бирж дээр 2014 оны 1-р сарын 14-нд амжилттай арилжаалсан бөгөөд энэ нь ХХБ-ны хувьд олон улсын зах зээлд 5 дахь удаагаа бонд гаргаж буй тохиолдол юм. 2007 онд анхны бондоо амжилттай арилжаалсны дараа 2010, 2012 онуудад мөн бонд гаргаж, Монгол улсаас доллар болон юанийн бонд гаргасан цорын ганц байгууллага юм.

Бидний амжилт, ололтын түүхэн цаг үед хамт байж үнэнчээр дэмжиж ирсэн нийт харилцагч, хадгаламж эзэмшигчид, гадаад, дотоодын түншүүддээ халуун талархал илэрхийлье.

Монголын арилжааны ууган банк болох Худалдаа, хөгжлийн банк өөрийн 24 – н жилийн арвин их туршлагаараа Таны ирээдүйн санхүүгийн найдвартай түнш байсаар байх болно. Харилцагч Та бүхний бизнесийн ашиг орлого өөдөө, амьдрал тань улам цэцэглэн хөгжихийг хүсэн ерөөе.



**Рандолф Коппа**

Ерөнхийлөгч

## Гүйцэтгэх захирлын илгээлт

Хүндэт харилцагч, бизнесийн  
түнш, хувь нийлүүлэгчид,  
хамтран ажиллагчид аа!



**Балбарын Мэдрээ**  
Гүйцэтгэх захирал



“ 2013 он Худалдаа, хөгжлийн банкны хувьд онцлох үйл явдал, ололт амжилтаар арвин жил боллоо. Тайлант онд банк маань нийт активын болон зээлийн багцынхаа хэмжээгээр Монгол улсын банкны салбарт тэргүүлэгч болон тэлж, хамгийн өндөр ашигтай ажилласан банк болж чадсан нь ажилтан бүрийн шаргуу хөдөлмөр, харилцагч, хамтран ажиллагчдын маань таатай хамтын ажиллагааны үр дүн юм.

”

2013 оныг Худалдаа, хөгжлийн банк “Бүтээмж дээшлүүлэх жил” болгон дотоод нөөц бололцоогоо дайчилж, зарим холбогдох өөрчлөлт, шинэчлэлтүүдийг хийж ажилласнаар, банкны үзүүлж байгаа бүх үйлчилгээний бүтээмж болон салбар, ТТ, газар, хэлтсийн хоорондын уялдаа холбооны бүтээмж, мөн гараар хийгддэг ажиллагаа ихтэй ажлуудыг автоматжуулах гурван чиглэлээр ажиллан, бүтээмжээ сайжрууллаа. ХХБ нь бүтээмж, нэг ажилтан, нэгж актив, хөрөнгө оруулалтын өгөөжийг өндөр байлгах талаар зөвхөн өнгөрсөн онд төдийгүй байнга хянаж, хэмжиж, мэдрэмжтэй, шуурхай, менежментээр хангаж ажиллаж байгаа маань жил бүрийн санхүүгийн үзүүлэлтэд тусгалаа олж байдаг билээ. 2005 оноос хойш орон сууцны зээлийг санхүүгийн хүндрэлтэй цаг үедэд ч тасралтгүй олгосон манай банкны хувьд 2013 оноос Монгол улсын Засгийн газар, Монголбанкнаас хамтран хэрэгжүүлж буй “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд “Орон сууцны жилийн 8% - ийн хүүтэй зээл” - ийг тэргүүлэн дэмжиж, нээлтийн ёслолын үйл ажиллагааг зохион байгуулан, харилцагчиддаа энэхүү зээлийг олгож эхэлсэн юм. Түүнчлэн, бид ХХБ - нд орон сууцны зээлтэй хуучин харилцагчдаа 8 хувийн зээл рүү шуурхай шилжүүлсэн нь харилцагчдын талархлыг хүлээсэн үйл явдал болсон юм.

2013 онд Ти Ди Би Онлайн нэршлээр Интернэт банкны үйлчилгээгээ зах зээлд шинэчилж сайжруулсан хувилбараар нэвтрүүлэн, технологийн хувьд харилцагчдын эрэлтэд тулгуурласан томоохон өөрчлөлтүүдийг хийсэн юм. Үргэлж нээлттэй банк уриатай Ти Ди Би онлайн үйлгээний цар хүрээ, хэрэглэгчийн тоо өссөөр, харилцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран банкны үйлчилгээ авах хүсэл сонирхол өндөр болсон нь сайшаалтай. Түүнчлэн, Мост Мони үйлчилгээг харилцагчийн өдөр тутмын хэрэгцээнд улам ойртуулан, үүрэн телефоны оператор харгалзахгүй болгосноос гадна тасралтгүй шинэчлэлтийг хийснээрээ онцлууштай жил болж өнгөрлөө.

Арилжааны банкуудын хувьд эрсдэлээ тооцох, барьцаа хөрөнгөө үнэлэх тогтсон стандартын дагуу ажиллахад зарим жижиг, дунд бизнес эрхлэгчид барьцаа хөрөнгийн үнэлгээ нь доогуур байх, хүссэн зээлийн хэмжээгээр нь банк олгох боломжгүй байх хүндрэлтэй асуудлууд хаа хаанаа тулгардаг. Энэ асуудлыг Зээлийн батлан даалтын сантай хамтран шийдвэрлэж, тус сантай хамтран ажиллаж эхэллээ.

Энэ нь жижиг, дунд бизнес эрхлэгчиддээ үр өгөөжтэй байж, тэднийг өсөж томрох, корпорацийн хэмжээнд хүрэхэд нь томоохон дэмжлэг болох болно.

Нийгмийн хариуцлагаа гүнээр ухамсарладаг тэргүүлэх банкны хувьд нийгмийн сайн сайхан, гэрэлт ирээдүйн төлөө мөнгөн хөрөнгө шаардлагатай нийгмийн бүх давхаргад хандив дэмжлэг, ивээн тэтгэлэгийг харамгүй зориуллаа.

Тухайлбал, нийслэл Улаанбаатар хотод Худалдаа, хөгжлийн банк томоохон бүтээн байгуулалт хийхээр 15 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг эхлүүлээд байна. Бид эхний ээлжинд 200 автобусны буудлыг чанарын өндөр түвшинд, олон улсын стандартаар барьж байгуулан, нийслэл хотдоо хүлээлгэн өгөх болно.

24 жил бидний харилцан итгэлцлийн бат бөх гүүр болсон нийт харилцагч иргэд, дотоод гадаадын байгууллага, хамтран ажиллагч бизнесийн түншүүддээ улиран одсон он удаан жилүүдэд байнга хамт байж, бидэнд үнэнч байсанд талархлаа илэрхийлье.

2014 онд ХХБ өсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээгээ улам чанаржуулах, цар хүрээгээ тэлэх талаар цаг хугацаатай өрсөлдөн ажиллах их үйлсийн жил болгох зорилтыг тавин ажиллаж байна.

Та бүхэн эрүүл энх байж, зөв бодол, чиг шударгаар амжилтын өөд тэмүүлж, цог золбоотой байхын ерөөлийг өргөн дэвшүүлэхийн ялдамд ХХБ - ны удирдлагын баг, нийт захирлууд, ажилтнууддаа шаргуу хөдөлмөрсөнд нь талархал илэрхийлье.

Та бүхнийг гүнээ хүндэтгэсэн,



**Балбарын Мэдрээ**

Гүйцэтгэх захирал

## Санхүүгийн үзүүлэлтүүд

Тэрбум төгрөг

Хөрөнгө	2013	2012	2011
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	1,090.2	444.8	475.0
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	885.1	456.8	344.3
Хараат компани дахь хөрөнгө оруулалт	10.4	2.4	2.3
Зээл ба урьдчилгаа (цэвэр)	2,530.6	1,533.3	1,123.3
Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас	0.0	0.0	37.0
Хоёрдогч өглөгөөрх хөрөнгө оруулалт	7.0	7.0	7.0
Үндсэн хөрөнгө (цэвэр)	153.3	131.6	79.1
Биет бус хөрөнгө (цэвэр)	4.3	0.6	0.4
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	33.4		
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (цэвэр)	6.1	0.2	0.6
Бусад хөрөнгө	403.7	123.9	51.8
<b>Хөрөнгийн дүн</b>	<b>5,124.1</b>	<b>2,700.5</b>	<b>2,120.7</b>
<b>Өр төлбөр</b>			
Харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	2,139.7	1,402.3	1,277.3
Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	172.1	36.5	35.1
Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас	372.7	1.5	171.5
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	1,157.1	233.0	174.4
Татварын өглөг	7.6	2.5	1.5
Бонд	460.6	600.5	207.1
Бусад өр төлбөр	379.2	128.8	72.8
Хоёрдогч өглөг	66.0	55.5	41.7
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>4,755.0</b>	<b>2,460.6</b>	<b>1,981.3</b>
Хувьцаат капитал	33.2	33.2	8.0
Дахин үнэлгээний нэмэгдэл	32.7	44.4	22.4
Хуримтлагдсан ашиг	301.6	162.3	109.0
Нийт өөрийн хөрөнгийн дүн	367.5	239.9	139.4
Цөөнхийн хувь оролцоо	1.6		
<b>Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>5,124.1</b>	<b>2,700.5</b>	<b>2,120.7</b>



## Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Тэрбум төгрөг

Хөрөнгө	2013	2012	2011
Хүүний орлого	321.4	213.3	143.5
Хүүний зардал	(200.7)	(137.4)	(95.4)
<b>Цэвэр хүүний орлого</b>	<b>120.7</b>	<b>75.9</b>	<b>48.1</b>
Шимтгэл хураамжийн цэвэр орлого	21.5	16.4	12.1
Үйл ажиллагааны бусад орлого (цэвэр)	68.7	14.3	14.2
<b>Цэвэр хүүгийн бус орлого</b>	<b>90.2</b>	<b>30.7</b>	<b>26.3</b>
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>211.0</b>	<b>106.6</b>	<b>74.5</b>
Үйл ажиллагааны зардал	(44.5)	(32.9)	(20.1)
Хараат компаний ашгаас ноогдох хувь	0.2	(2.3)	0.1
Эрсдэлийн сангийн зардал	(8.3)	6.6	(3.1)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>158.4</b>	<b>77.9</b>	<b>51.4</b>
Орлогын татварын зардал	(19.2)	(14.8)	(9.3)
<b>Тайлант жилийн цэвэр ашиг</b>	<b>139.3</b>	<b>63.1</b>	<b>42.1</b>


Харьцаа үзүүлэлтүүд	2013	2012	2011
<b>Ашигт ажиллагаа</b>			
Зардлын орлогод эзлэх хувь	21.1%	30.8%	27.0%
Цэвэр хүүгийн зөрүү	4.4%	4.4%	3.5%
Өөрийн хөрөнгийн өгөөж	37.9%	26.3%	30.2%
Активын өгөөж	2.7%	2.3%	2.0%
<b>Өсөлтийн харьцаанууд</b>			
Активын өсөлт	89.7%	27.3%	58.4%
Зээлийн өсөлт	65.0%	36.5%	141.9%
Харилцах, хадгаламжийн өсөлт	52.6%	9.8%	38.8%
Өөрийн хөрөнгийн өсөлт	53.2%	72.1%	57.9%
<b>Активын чанар</b>			
Зээл / Харилцах, хадгаламж	118.3%	109.3%	87.9%
Зээлийн активт эзлэх хувь	49.4%	56.8%	53.0%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	42.0%	37.0%	42.0%
<b>Өөрийн хөрөнгийн харьцаа</b>			
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	11.6%	10.0%	8.2%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	15.1%	15.1%	12.7%

2013 оны эцэст нийт зээлийн дүн 2,530.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 65.0 хувиар буюу 997.3 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн дүн 5,124.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 2,423.6 тэрбум төгрөгөөр буюу 89.7 хувиар өссөн байна. Нийт өр төлбөр, өөрийн хөрөнгөд харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 41.8 хувь, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж 3.4 хувь, буцаан худалдан авах гэрээгээр борлуулсан үнэт цаас 7.3 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 22.6 хувь, бонд 9 хувь, бусад өр төлбөр 8.7 хувь болон өөрийн хөрөнгө 7.2 хувийг тус тус эзэлж байна.

2013 оны жилийн эцэст тайлант жилийн цэвэр ашиг 139.3 тэрбум төгрөгт хүрч, 2012 оны жилийн эцэстэй харьцуулахад 76.2 тэрбум төгрөг буюу 120.8 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ. Зээл олголт огцом өссөнөөс үүдэн хүүгийн орлого өмнөх онтой харьцуулахад 50.7 хувиар буюу 108.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн цэвэр хүүгийн бус орлого 90.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 59.5 тэрбум төгрөг буюу 193.8 хувиар өсчээ.


**Нийт хөрөнгө (актив)**

GAGR - 59%




**Зээл ба урьдчилгаа (цэвэр)**

GAGR - 58%




**Харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгө**

GAGR - 39%




**Нийт өөрийн хөрөнгө**

GAGR - 53%




**Хүүний орлого**

GAGR - 43%



**Тайлант жилийн цэвэр ашиг**

GAGR - 75%



## Худалдаа, хөгжлийн банк 2013 онд

### ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2013 он нь Худалдаа, хөгжлийн банкны хувьд Монголын банк, санхүү, эдийн засгийн салбарт томоохон хувь нэмрээ оруулсан, бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжсэн, иргэддээ санхүүгийн ойр үйлчилгээг хүргэхийг зорьсон зорилтууд, төлөвлөсөн ажлуудаа давуулан гүйцэтгэсэн их ажил, амжилтын жил байлаа.



- > Монголын санхүүжилт шаардлагатай байгаа бизнес эрхлэгчид, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулах үүднээс Нидерландын Хөгжлийн банк (FMO), олон улсын ING банкны 82 сая ам.долларын “Хамтын санхүүжилтийн зээл”-ийн гэрээг 2013 оны 9 дүгээр сард байгуулж, санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүллээ.



- > Байгаль орчин, нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлого, заавар журмыг Монголд анх удаа бий болгож, “Тогтвортой санхүүжилтийн форум”-ыг анх удаа 2013 оны 5 дугаар сард зохион байгуулж, байгаль орчин, нийгэмд ээлтэй, тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг бизнес эрхлэгч байгууллагуудад олгож эхлээд байна.



- > ХХБ нь Гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээний зах зээлийн 50 гаруй хувийг дангаараа үзүүлж чадаж байгаагийн хувьд МҮХАҮТ - тай хамтран “Гадаад худалдааны санхүүжилт” зөвлөгөөнийг зохион байгуулсан нь харилцагч байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаанд бодитой үр дүн үзүүлсэн үйл ажиллагаа болсон юм.



- > ХХБ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгамддаг барьцаа хөрөнгийн дутагдлын асуудлыг шийдвэрлэх үүднээс Зээлийн батлан даалтын сантай хамтын ажиллагаагаа эхлүүлсэн нь Зээлийн батлан даалтын сантай үр дүнтэй хамтран ажиллаж, жижиг, дунд бизнес эрхлэгчиддээ үр өгөөжтэй байж, тэднийг өсөж томрох, корпорацийн хэмжээнд хүрэхэд нь томоохон дэмжлэг болох болно.



- > Японы Эм Жи Лизинг Корпорациитай Худалдаа, хөгжлийн банк болон Ти Ди Би капитал компаниуд хамтран, олон улсын санхүүгийн стандартад нийцсэн Монголын хамгийн том санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэгч Ти Ди Би Лизинг ХХК - ийг 2013 оны 6 дугаар сард үүсгэн байгууллаа.



- > Мэдээллийн технологийн Софтлайн компаниитай хамтран, дэлхийд тэргүүлэгч "Microsoft" корпорациитай "Хамтын ажиллагааны гэрээ"-г 2013 оны 10 дугаар сард амжилттай байгуулсан бөгөөд энэ нь ХХБ-ны программ хангамжийн чанар, найдвартай байдал зэргийг цогцоор нь олон улсын түвшинд баталгаажуулж, мэдээллийн технологийн үйл ажиллагааны найдвартай байдал, техник технологид өндөр ач холбогдол өгдөг болохыг баталлаа.



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



- > **Бид нийслэлийнхээ хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулан ажилладаг.**

Сайхан хотдоо сэтгэл тэнэгэр амьдрах чин хүсэлтэй нийслэлчүүддээ зориулан Худалдаа, хөгжлийн банк Улаанбаатар хотынхоо хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад 15 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр, 200 автобусны буудлыг бүрэн камерьтай, WiFi орчинтой, хогийн сав, тухлаг сандал, автобусны чиглэлүүд, урсдаг лед самбар, бүрэн гэрэлтүүлэг зэргээр цогцоор нь төлөвлөн, ажлаа эхлүүлээ.



- > **Бид нийгмийн аль ч хэсэгт багтах Монгол улсын ирээдүй болсон бяцхан иргэддээ хүрч итгэлийн гараа сунгадаг.**

Худалдаа, хөгжлийн банк Макс групптэй хамтран Хүсэл мөрөөдөлд хүч нэмэх Хүүхдийн хадгаламжийг Асрамжийн газрын 20 хүүхдэд гардууллаа. ХХБ-ны зүгээс хүүхэд бүрт номын цуглуулга, хадгаламжийн дэвтрээ үнэгүй гардуулснаас гадна 150 хүүхдийг Өргөө кинотеатрт кино үзэх эрх, 50 бяцхан хүүхдэд Тоглоомын төвд тоглох эрхийн бичгийг бэлэглэсэн нь хүүхдүүдийн баяр дээр баяр нэмсэн үйл явдал болсон юм.



- > **Уламжлал ёсоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг 9 дэх жилдээ баярлууллаа.**

Хүүхэд бүрийн хүсэн хүлээдэг шинэ жилийн баяраар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурч хүмүүждэг 29 - р сургуулийн шинэ жилийн баярт оролцон, 360 орчим хүүхдэд баярын бэлгээ түгээлээ. Жирийн хүүхдүүдтэй мөр зэрэгцэн нэгэн анги танхимд сурч боловсрох боломжгүй, байнгын бусдын туслалцаа дэмжлэгээр амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ХХБ 9 дэх жилдээ шинэ жилийн бэлэг барьж, гацуур мод бэлэглэн баярлууллаа.



- > **“Дуулиан - 2020” - ийг 7 жилийн турш ивээн тэтгэж, 2013 онд алтан цомыг хүртлээ.**

Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор долоо дахь жилдээ зохион байгуулж буй “Дуулиан - 2020” тэмцээний Ивээн тэтгэгчдийн тоглолтын Аваргын алтан цомыг Худалдаа, хөгжлийн банкны баг хүртлээ. 2006 оноос хойш 7-н жилийн турш тасралтгүй ивээн тэтгэгчээр хамтран ажиллаж, ирээдүйн хүчирхэг хөл бөмбөгчдийг төрүүлэх зорилгыг дэмждэг ХХБ-ны спортлог залуусын баг Ивээн тэтгэгчдийн тэмцээнд ийнхүү тэргүүлэн, аваргын алтан цомын эзэд боллоо.

## ШАГНАЛ ӨРГӨМЖЛӨЛ



> **“Хөгжиж буй орнуудын шилдэг банк”**

Худалдаа, хөгжлийн банкны 2013 оны санхүүгийн жилд хийж бүтээсэн ажил, амжилт бүхнийг бататган “Finance asia” сэтгүүлээс “Хөгжиж буй орнуудын шилдэг банк шагнал гардлаа.



> **“2013 оны Монгол улсын шилдэг банк”**

Дэлхийн алдарт “Euromoney” сэтгүүл нь жил бүр дэлхий даяар тухайн улсын санхүүгийн шилдэгүүдийг шалгаруулдаг бөгөөд 2013 онд Монгол улсын банкны салбарын шилдэгээр ХХБ-ийг шалгаруулан, “2013 оны Монгол улсын шилдэг банк”-аар өргөмжлөлөө.



> **“Монгол улсын худалдааны санхүүжилтийн шилдэг банк”**


Дэлхийн худалдааны санхүүжилтийн “Global trade review” (GTR) сэтгүүл Монгол улсад худалдааны санхүүжилтийн үйлчилгээгээр мэргэшсэн, өндөр түвшинд, хамгийн найдвартай үйлчилгээг үзүүлдэг банкнийг санал асуулгаар тодруулсан ба уг асуулгад ХХБанк илт давуу 1-рт жагсаж, “Худалдааны санхүүжилтийн шилдэг банк”-аар 3 дахь удаагаа шагнагдсан юм.



> **“2013 оны Монгол улсын арилжааны шилдэг банк”**

Их Британийн “Global banking & finance review” олон улсын байгууллагаас дэлхийн шилдэг банк санхүүгийн байгууллагуудын дунд зохион байгуулдаг шалгаруулалтаас ХХБанк 2013 оны “Монгол улсын арилжааны шилдэг банк” шагналыг олголоо.

# Худалдаа, хөгжлийн банкны бүтэц



## Компанийн засаглал

Худалдаа, хөгжлийн банк нь олон улсын туршлагаар шалгарсан компанийн засаглалын бүхий л хэм хэмжээг дэмжин ажилладаг бөгөөд дээд түвшний, сайн байгууллагын засаглал нь бидний үйл ажиллагааны гол чиглүүлэгч болдог.

Бид компанийн засаглалын бүтэцдээ Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Удирдлагын багийн гишүүд, хувь нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа, нягт харилцааг нарийн тодорхойлж, байгууллагынхаа эрхэм зорилго, зорилтдоо хүрэхийн тулд хувь хүн бүр ёс зүйн ямар хэм хэмжээг үйл ажиллагаандаа баримтлахыг нарийвчлан заасан байдаг.

### Төлөөлөн удирдах зөвлөл

ХХБ-ны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шудрага байдлыг чухалчилан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямарч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

### Удирдлагын баг

ХХБ-ны Удирдлагын баг нь банк санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог төдийгүй банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

### Ажилтнууд


ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэднийг шудрагаар урамшуулж, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчиддаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

### Бид

ХХБ нь хууль, ёс зүйн хариуцлагын хүрээнд нийцсэн ажиллах орчинг бүрдүүлэхийг үргэлж эрмэлзсээр ирсэн бөгөөд харилцагч, бизнесийн түншүүд болон нийгэмдээ банкны шилдэг үйлчилгээг үзүүлэн, хувь нийлүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ аливаа амжилт нь шудрага байх ёстой гэдэгт итгэдэг.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## ТУЗ-ийн дарга

Должин ЭРДЭНЭБИЛЭГ

## Гишүүд

Зуунай ШАГДАРСҮРЭН  
 Рандолф КОППА  
 Тамир ЦОЛМОН  
 Чулуунбаатар ЭНХБОЛД

## Банкны нарийн бичгийн дарга

Дашзэвэг ДАВААЖАВ

## УДИРДЛАГЫН БАГ

## Ерөнхийлөгч

Рандолф КОППА

## Гүйцэтгэх захирал

Балбар МЭДРЭЭ

## Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч

Онон ОРХОН

## Ерөнхий аудитор

Паламдорж ГАНТУУЛ

## Гүйцэтгэх захирлын орлогч

Дамбийжав ХҮРЭЛБААТАР

## Гүйцэтгэх захирлын орлогч

Дэмчигжав ОТГОНБИЛЭГ

## Гүйцэтгэх захирлын орлогч

Санжаасүрэн ОРГОДОЛ

## Гүйцэтгэх захирлын орлогч

Лхагвасүрэн СОРОНЗОНБОЛД

## УДИРДЛАГЫН БАГ



**Ноён О.ОРХОН**

Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч



**Хатагтай П.ГАНТУУЛ**

Ерөнхий аудитор



**Ноён Д.ХҮРЭЛБААТАР**

Гүйцэтгэх захирлын орлогч



**Хатагтай Д.ОТГОНБИЛЭГ**

Гүйцэтгэх захирлын орлогч



**Ноён С.ОРГОДОЛ**

Гүйцэтгэх захирлын орлогч



**Ноён Л.СОРОНЗОНБОЛД**

Гүйцэтгэх захирлын орлогч





## БАЙГУУЛЛАГЫН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# 3

Байгууллагын бизнест тэргүүлэгч ХХБ нь Монгол улсын хамгийн том байгууллагын банк бөгөөд бүхий л салбарт бизнес эрхэлж буй олон улсын болон дотоодын 400 гаруй томоохон байгууллагууд, корпорациудтай хамтран ажилладаг.

## Байгууллагын бизнесийн үйл ажиллагаа

### Зээлийн багц хоёр их наяд руу хүрлээ

Байгууллагын бизнест тэргүүлэгч ХХБ-ны томоохон байгууллагууд, бүтээн байгуулагч компани, корпорациудад олгосон зээлийн багц түүхэндээ анх удаа хоёр их наяд төгрөгт хүрлээ.


Зөвхөн томоохон компани, корпорациудад зээл олгоод зогсохгүй, барилгын салбарын харилцагч байгууллагуудынхаа борлуулалтыг давхар дэмжин, “Гурван талт” гэрээгээр банкны бүх салбар, тооцооны төвүүдээр дамжуулан, орон сууц худалдан авагч иргэдэд орон сууцны зээл болон 8.0 хувийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийг олгож, хамтран ажиллаж байна.

Түүнчлэн, байгаль орчинд ээлтэй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан, нийгэмдээ ач тустай, ирээдүйд үр өгөөжөө өгөх бизнес эсэхийг нь харгалзан зээл олгодог болсон нь нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн соёл, ухамсрыг Монгол орондоо нэвтрүүлэхэд чиглэсэн томоохон алхам болж байгаа юм. Улмаар тус банкнаас санаачлан, Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи болон FMO, IFC зэрэг олон улсын томоохон банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсны үндсэн дээр 2013 онд Монголын бүх банкууд Тогтвортой санхүүжилтын санаачлагад нэгдэн орж, гарын үсэг зурсан нь өнөөгийн ашгийг олохдоо ирээдүй хойч үеийнхэндээ хохирол учруулахааргүй байхад нийтээрээ анхаарах шинэ эрин үеийг нээж өгсөн юм.


Мөн Монгол Улсын Засгийн Газар, Монголбанкны хамтран хэрэгжүүлж буй эдийн засгийн гол салбарын үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд зээлийг үндэсний компаниудад олгож, уг бодлогыг дэмжин хэрэгжүүлж байна.

Голлох уул уурхайн бүтээгдэхүүний үнэ олон улсад буурч, дэлхийн эдийн засгийн үзүүлэлтүүд буурсан нь манай улсын эдийн засгийн гол экспортын нэрийн бараа бүтээгдэхүүн төдийгүй, дотоодын үйлдвэрлэл удаашрахад хүргэсэн жил байсан хэдий ч оны эцэст ХХБ - ны байгууллагын зээлийн багц 78.9 хувиар өсч, нийт багцад эзлэх чанаргүй зээлийн үзүүлэлт 34.8 хувиар буурсан үнэмлэхүй амжилттай жилийг ардаа үдлээ.

Зээлийн чанар, ангиллаар



Нийт нээгдсэн аккредитив, баталгааны дүн





## Худалдааны санхүүжилтийн үйлчилгээний 50 хувийг дангаараа гүйцэтгэлээ

Өнгөрсөн 2013 онд ХХБ Монгол улсын нийт гадаад төлбөр тооцооны 50 хувь, худалдааны санхүүжилтийн үйлчилгээний мөн 50 хувийг дангаараа эзэллээ.

Энэ салбарт тэргүүлэгчийн хувьд иргэдэд худалдааны санхүүжилтийн арга хэрэгслүүдийг хэрхэн өөрийн бизнестээ үр өгөөжтэй ашиглах, санхүүгийн хямд эх үүсвэрийн боломжит гарцыг нээх талаар сургалт, зөвлөгөөнүүдийг тогтмол зохион байгуулсаар ирлээ. Энэхүү уламжлалт ажлын хүрээнд 2013 оны 5 болон 11 дүгээр саруудад Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) - тай хамтран 400 гаруй харилцагчдад худалдааны санхүүжилтийн чиглэлээр цогц мэдээлэл хүргэх зорилготой “Худалдааны санхүүжилтийн зөвлөгөөн” - ийг 2 удаа амжилттай зохион байгуулсан юм.

## Хамтарсан төслийн зээлүүд амжилттай үргэлжилж байна

ХХБ жижиг, дунд бизнес эрхлэгч байгууллага, ААН болон иргэдэд үйл ажиллагаагаа өргөтгөх, цар хүрээгээ тэлэхэд нь боломж олгож, тэдний санхүүгийн хэрэгцээнд нийцсэн бизнесийн зээл, төслийн зээл, худалдааны санхүүжилт болон Засгийн газраас хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээлийн төсөл, дэд хөтөлбөрүүдийн дагуу хэрэгжиж байгаа зээлийн үйлчилгээг санал болгож, хамтран ажилласаар ирсэн билээ.

**Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллагын Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл.** 2006 оноос манай улсад хэрэгжиж байгаа бөгөөд энэ хугацаанд тус банкаар 2006 - 2011 онд хэрэгжсэн I шатанд 18 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, 2011 оноос хэрэгжсэн II шатанд 42 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид төслийн санхүүжилт олгосон ба төслийн III шат 2014 онд олгогдож эхлэхээр төлөвлөгдөж байгаа.

**Дэлхийн банкны Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээлийн төсөл.** ЖДҮ - ийг дэмжих зорилгоор 2004 оноос Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн уг зээлийн төслийг тус банк өдийг хүртэл амжилттай хэрэгжүүлж байна. Зээлийн төслийн II шатыг 2006 - 2011 онд Төслийн зөвлөх нэгжтэй хамтран амжилттай хэрэгжүүлж, нийт 20 дэд төсөлд санхүүжилтийг олгосон бөгөөд бүх төслүүд амжилттай хэрэгжиж байна.

**Азийн хөгжлийн банкны Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл.** 2011 онд төсөл хэрэгжүүлэгч санхүүгийн байгууллагаар шалгарч, Азийн Хөгжлийн Банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, хөдөө аж ахуйн түүхийг эд боловсруулагч дотоодын үйлдвэрүүдэд санхүүжилт олгосон.

**Германы KFW банкны экспорт, импортыг дэмжих зээлийн төсөл.** 1996 оноос ХХБ хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү зээлийн төсөл нь экспортын чиглэлийн үйлдвэрүүдийн техник, технологийн шинэчлэл, импортыг орлох чиглэлийн бараа, үйлчилгээний чанарын дэвшил, хөрөнгө оруулалтын оновчтой шийдэл болж чадсан.

**Хөдөлмөрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн төсөл.** 2009 онд энэхүү зээлийн төсөлд хэрэгжүүлэгч санхүүгийн байгууллагаар ХХБ шалгарч хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд одоог хүртэл амжилттай хамтран ажиллаж байна. 2009 онд 12 дэд төсөл, 2010 онд 18 дэд төсөл, 2011 онд 29 дэд төсөл, 2013 онд Хөгжлийн банкны санхүүжилтээр 6 дэд төсөлд тус тус санхүүжилт олгосон.





# 4

## ИРГЭДИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХХБ нь иргэдийн зах зээл рүү түлхүү үйл ажиллагаагаа хандуулан, иргэдэд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ өргөжүүлэхэд улам бүр анхааран, бусдаас хамгийн уян хатан нөхцөлтэй, харилцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна. 2013 онд иргэдээс татан төвлөрүүлсэн хөрөнгө 2140 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд дотоодын банкны салбарын нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн зах зээлийн 22.5%-ийг эзлэж байна.

## Иргэдийн бизнесийн үйл ажиллагаа

Худалдаа, хөгжлийн банк иргэдэд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, өгөөжийг сайжруулах, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхээр зорин ажилладаг бөгөөд тайлант онд иргэдийн зах зээлд үзүүлсэн амжилт ололтоосоо танилцуулж байна.

### “Junior customer” - уудаа хүндэтгэн, хүлээн авав

Бид хүүхэд багачуудад зориулсан олон төрлийн арга хэмжээг ивээн тэтгэж ажилладаг бөгөөд Төрийн ордонд зохион байгуулагдсан “Хүүхдийн сэтгэлд хүрэх хамгийн дөт зам” лекцийн ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсон. Тус лекцэд хүүхдийнхээ ирээдүйн сайн сайханд зориулан, удаан хугацаанд Тогтмол шилжүүлгийн үйлчилгээг ашиглаж, хуримтлал үүсгэж буй харилцагчдаа урамшуулан урьж оролцууллаа.

Түүнчлэн, Хүүхдийн баярыг тохиолдуулан хүүхдийн хадгаламжийн урамшуулалт бэлэгтэй аяныг зохион байгуулж, аяны хүрээнд 18 нас хүрсэн хүүхдийн хадгаламж эзэмшигчдийг банкны “Junior customer” - аар хүндэтгэн, дурсгалын сертификат гардуулж, CUP карт, банкны гарын бэлгээр давхар урамшуулсан юм. Энэхүү арга хэмжээг жил бүр уламжлал болгон явуулахаар болсон.

### “Ти Ди Би Онлайн” - аар дэлхийн хаанаас ч данс нээж, зээл авдаг болов

Интернэт банкны шинэ хувилбар болох Ти Ди Би Онлайн үйлчилгээг цоо шинэ боломжуудаар баяжуулан, зах зээлд шинээр нэвтрүүлж, харилцагч банкинд ирэлгүйгээр уг үйлчилгээг ашиглан хадгаламжийн данс нээх, хадгаламж барьцаалсан зээл болон цалингийн зээл авах үйлчилгээг нэвтрүүллээ.



### “Орон сууцны жилийн 8% - ийн хүүтэй зээл” - ийн үйл ажиллагааг дэмжин эхлүүллээ

Монгол улсын Засгийн газар, Монголбанкнаас хамтран хэрэгжүүлж буй “Орон сууцны жилийн 8% - ийн хүүтэй зээл” - ийг амжилттай нэвтрүүлэн, харилцагчдынхаа орон сууцны зээлд хамрагдах хэрэгцээг хангахын зэрэгцээ орон сууцны зээл авсан болон шаардлага хангасан зээлдэгчдийн зээлийг шимтгэлгүйгээр, энэхүү бага хүүтэй зээлд автоматаар шилжүүлсэн нь харилцагчдад сайшаагдсан явдал болсон.



### Мөнгөн гуйвуулга

Олон улсын шуурхай мөнгөн гуйвуулгын MoneyGram үйлчилгээний гол агент банкны хувьд Монгол улсад MoneyGram үйлчилгээг хүргэдэг арилжааны банкуудын анхдугаар зөвлөгөөнийг 7-р сард амжилттай зохион байгуулсан бөгөөд цаашид энэхүү үйл ажиллагааг тогтмол уламжлал болгон зохион байгуулж байхаар боллоо.



## Гадаад шилжүүлгийн үйлчилгээ

ХХБ нь Монгол улсад 2 шатлалт банкны системийн үндэс суурь тавигдаж эхлэсэн үеэс хойш буюу 1990 оноос хойш 24 дэх жилдээ гадаад төлбөр тооцооны үйлчилгээг мэргэжлийн түвшинд харилцагч нартаа хүргэж байна.

Энэ хугацаанд гадаад төлбөр тооцооны үйлчилгээний цар хүрээг улам өргөжүүлж, 2013 оны байдлаар олон улсад нэр хүнд бүхий 39 банкинд дахь 43 ностро данс болон гадаадын 8 банк, санхүүгийн байгууллагын манайд нээсэн 16 лоро дансаар дамжуулан дэлхийн 100 гаруй оронд харилцагчийн гадаад шилжүүлгийг хүргэж байна.

Банк, санхүүгийн байгууллагууд төдийгүй үндэстэн дамнасан том корпорациуд санхүүгийн мэдээ, мэдээллээ дэлхий даяар нууцлалын өндөр түвшинд, богино хугацаанд солилцох боломж бүхий SWIFT сүлжээнд Монгол улсаас 1996 онд анх удаа холбогдсоноос хойш тус сүлжээгээр дамжуулан, харилцагчид олон улсад хийх гадаад төлбөр тооцооны бүхий л төрлийн мэдээллийг дэлхийн 100 гаруй орны 150 гаруй банк, санхүүгийн байгууллагуудтай шууд солилцох боломжтой болоод байна.



2013 онд гадаад шилжүүлэг гүйцэтгэх системээ сайжруулах томоохон ажлыг хэрэгжүүлсний дээр гадаад шилжүүлгийн үйлчилгээг интернэт банкаар авах боломжийг өргөжүүлэн TDB online программыг нэвтрүүлж, улмаар цахим банкны үйлчилгээг харилцагч нартаа улам ойртуулах үүднээс Most money системээр дамжуулан гадаад шилжүүлэг хийх боломжийг бий болголоо. Визийн зориулалт бүхий мөнгөн хадгаламжийн үйлчилгээг нэвтрүүллээ.

БНСУ - ын ЭСЯ - нд виз мэдүүлэхэд тодорхой хэмжээний мөнгийг банкинд байршуулах шаардлагатай байдаг бөгөөд ХХБ - наас тус ЭСЯ - тай хамтран Визийн зориулалт бүхий мөнгөн хадгаламжийн үйлчилгээг нэвтрүүлж, хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Ингэснээр ХХБ - ны VIP харилцагч болон хадгаламжийн данс эзэмшигчдэд давуу байдлыг бий болгож барьцаа хөрөнгө байршуулах болон тодорхойлолт гаргахад түргэн шуурхай болж байгаа юм.

## Салбар, тооцооны төвүүдийн хөгжил



Банкны үйл ажиллагааны цар хүрээг тэлэх, үйлчилгээний хүртээмжийг улам бүр өсгөн нэмэгдүүлэх зорилгоор 2013 онд нийт 2 тооцооны төв, 3-н өргөтгөлийг нээн үйл ажиллагааг тогтворжуулан ажиллаж байна.

Түүнчлэн, банкны цогц үйлчилгээг харилцагчдад илүү ойртуулан хүргэх, улмаар харилцагчдын сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэх зорилгоор уртасгасан цагаар үйлчилгээ үзүүлдэг салбар, тооцооны төвүүдээ 69 хувиар нэмэгдүүлэн ажиллалаа.

2014 оны санхүүгийн жилд шинээр 7 салбар, тооцооны төвийг нээн, харилцагч нартаа улам ойртон, банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хурдан шуурхай хүргэн, борлуулалтыг нэмэгдүүлж ажиллахаар зорин ажиллаж байна.







## ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

# 5

ХХБ нь олон улсын хөрөнгийн зах зээл дэх Монгол улсын нүүр царай бөгөөд дэлхий даяар 150 гаруй олон улсын томоохон банкууд болон санхүүгийн байгууллагуудтай түншлэн ажиллаж Монгол улсын гадаад төлбөр тооцооны 50 гаруй хувийг бие даан гүйцэтгэдэг.

## Гадаад харилцаа, олон улсын банкны үйл ажиллагаа

Тайлант онд Худалдаа, хөгжлийн банк гадаадын нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, гадаад зах зээлээс хямд ертөгтэй эх үүсвэр татах, харилцагчдын гадаад улс орноос хийж буй импортыг санхүүжүүлэх боломжуудыг нэмэгдүүлэх, гадаад төлбөр тооцооны оновчтой, өргөн сүлжээг бий болгохоор зорин ажиллалаа.

Монгол улсын эдийн засгийн онцлогтой уялдуулан, уул уурхай, барилгын салбарын тоног төхөөрөмжийн худалдан авалтыг дэмжих зорилгоор санхүүгийн лизингийн үйлчилгээг олон улсын стандартын дагуу Монгол улсад нэвтрүүлэхээр зорин, Япон улсын нэр хүндтэй “Сумитомо мицүи” санхүүгийн группын охин компани Эм Жи Лизинг Корпораци, Ти Ди Би Капитал компанитай хамтран, санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэгч Ти Ди Би Лизинг ХХК - ийг байгууллаа.

Стратегийн томоохон харилцагчдад үзүүлж буй үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, тэдгээртэй хийж буй хамтын ажиллагааг өндөр түвшинд хүргэх зорилгоор байгууллагын харилцааны менежментийн шинэ бүтцийг бий болгон, “Нэг цонхны үйлчилгээ” - г нэвтрүүлээ.

### Олон улсын санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр 155 хувиар өслөө

Монголын банкны салбарын түүхэнд анх удаа олон улсын хамтын санхүүжилтийн зээлийн төслийг Нидерландын Хөгжлийн банк (FMO), Олон улсад нэр хүнд бүхий ING банкны оролцоотойгоор амжилттай зохион байгуулж, 82 сая ам.долларын хамтын санхүүжилтийг дотоодын бизнес эрхлэгчид, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийн хэрэгцээг хангахад зориуллаа.

Тайлант онд олон улсын санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хэмжээ өмнөх жилийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад 155 хувиар өссөн нь гадаад зах зээлд ХХБ - нд итгэх итгэл өндөр байгааг харуулж байгаа юм.



### Төслийн зээл олголтыг нэмэгдүүлээ

Жижиг, дунд үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийг дэмжих, үйл ажиллагааг нь өргөжүүлэх зорилготойгоор ХБНГУ-ын KfW банкны Хувийн хэвшлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын төслийн зээл, МУ-ын Сангийн яам, ЯОУХАБ-наас хэрэгжүүлж буй ЖДҮ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн төсөл болон Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих зээлийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлэн, 6.1 тэрбум төгрөгийн зээлийг батлан, харилцагчдын төслүүдийг санхүүжүүлээд байна.




### Байгууллагын харилцааны чиглэлээр идэвхтэй ажиллалаа

Тайлант онд 156 байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, банкны цогц бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэлээ. Энэ нь харилцагч байгууллагын ажилтнуудад банкны бүтээгдэхүүн үйлчилгээг таниулах, өдөр тутмын идэвхтэй хэрэглээ болгох, хувийн санхүүгийн менежментийн чиглэлээр мэдлэг өгөх зорилгоор жилийн туршид өдөрлөг, сургалтуудыг зохион байгууллаа.

### Худалдааны санхүүжилтийн зээлийн шугам 23.3 хувиар өслөө

Худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын ашиглалтын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.3% - иар өссөн байна.







## ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК

6

Ти Ди Би Капитал ХХК нь үйлчлүүлэгчдийнхээ бизнесийн өсөлт болон санхүүгийн зах зээлд оролцох идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор корпорацийн санхүүжилт, үнэт цаасны зуучлал, мэргэжлийн мэдээлэл судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг олон улсын жишигт нийцсэн хөрөнгө оруулалтын банкны цогц үйлчилгээг хүргэдэг.

## Ти Ди Би Капитал ХХК

Ти Ди Би Капитал ХХК нь үйлчлүүлэгчдийнхээ бизнесийн өсөлт болон санхүүгийн зах зээлд оролцох идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор корпорацийн санхүүжилт, үнэт цаасны зуучлал, мэргэжлийн мэдээлэл судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг олон улсын жишигт нийцсэн хөрөнгө оруулалтын банкны цогц үйлчилгээг харилцагчиддаа хүргэдэг.

Мөн нэн хурдацтай өсөж буй эдийн засаг дахь санхүүгийн түрээсийн үйлчилгээний эрэлт, хэрэгцээг хангах болон олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг харилцагчиддаа хүргэх зорилгоор санхүүгийн түрээсийн “Ти Ди Би Лизинг” ХХК-ийг 2013 оны 6-р сард Японы нэр хүнд бүхий “Sumitomo Mitsui Finance and Leasing” компани болон “Marubeni” корпорацийн хамтарсан хөрөнгө оруулалттай “MG Leasing” корпораци болон Худалдаа, хөгжлийн банктай хамтран үүсгэн байгуулаад байна.

### Корпорацийн санхүүжилт

Олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банк, сангуудтай хамтран ажилласан туршлага дээрээ үндэслэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлж, үндэсний компаниудын хувьцаа, бонд гаргах, зээлийн санхүүжилт татах зэрэг ажлыг зохион байгуулж байна. Мөн зайлшгүй шаардлагатай IPO гаргах бэлтгэл үеийн санхүүжилт, уул уурхайн хайгуулын ажлын болон экспортын урьдчилгаанд зориулагдсан хөрөнгийн эх үүсвэрийг татан, дотоодын стратегийн томоохон төслүүдийг санхүүжүүлэхийг зорьж байна.

### Үнэт цаасны зуучлал

Монгол улсын эдийн засгийн хурдацтай өсөлт болон уул уурхайн хөгжил нь олон улсын хөрөнгө оруулагчдын Монгол улсын хөрөнгийн зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлж байна. Бид энэхүү боломжийг хөрөнгө оруулагчдад нээхийн зэрэгцээ Монголын хөрөнгийн биржийн арилжаанд дотоодын хөрөнгө оруулагчид болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдлэгийг сайжруулах зорилгоор үнэт цаасны зуучлалын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хүргэдэг.

2013 онд харилцагчдынхаа эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн харилцагчиддаа алсын зайнаас хувьцааны арилжаанд оролцох боломжийг олгож, хувьцааны интернэт захиалгын үйлчилгээг үнэ төлбөргүй нэвтрүүлснээр Монголын хөрөнгийн зах зээлд анхдагч болж биржийн арилжаанд оролцох сонирхлыг нэмэгдүүлж байна. Мөн өөрсдийн үйл ажиллагааг өргөжүүлэн Эрдэнэт, Дархан хотуудад салбар нээлээ.

### Судалгаа шинжилгээ

Бид хөрөнгө оруулагчид болон харилцагчиддаа эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал, ирээдүйн чиг хандлагын талаар мэргэжлийн түвшинд бэлтгэсэн судалгаа, шинжилгээг бэлтгэн цаг алдалгүй хүргэдэг. Монголын хөрөнгийн бирж болон олон улсын хөрөнгийн биржүүдэд бүртгэгдсэн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй компаниудын судалгааг харилцагчиддаа хүргэж байна.

### Хөрөнгийн удирдлага

Байгууллага болон өндөр орлого бүхий иргэдэд санхүүгийн зорилтот түвшин, амжилтанд хүрэхэд нь хувьцаа, тогтмол орлого бүхий үнэт цаас, хөрвөх чадвар бүхий үнэт цаасны чиглэлээр хөрөнгийн удирдлагын үйлчилгээ үзүүлэхээр зорин ажиллаж байна.







## ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА

# 7

ХХБ нь дотоодын мөнгөний зах зээлд тэргүүлэгч бөгөөд уг зах зээлийн 23.7%-ийг эзлэж байна. Мөн Монгол улсын валют арилжаа болон биет алтны зах зээлийг 33.0% болон 51.0%-тайгаар тус тус тэргүүлсээр байна.



# Хөрөнгө зохицуулалтын удирдлага

## Мөнгөний зах зээл

Өнгөрсөн онд ХХБ мөнгөн урсгалын төлөвлөлтөө сайжруулж, бүтээмж дээшлүүлэх зорилтын хүрээнд хүүгийн зардлыг бууруулж, Монголбанкны үнэт цаас болон Засгийн газрын бондын арилжаанд идэвхтэй оролцох замаар хүүгийн орлогыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг Засгийн газрын бондын арилжаанд зуучлах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж, зах зээлд эзлэх байр сууриараа тэргүүлсэн жил болж өнгөрлөө.

Олон улсын зах зээлээс хөрвөх чадвар өндөр, эрсдэл бага активуудыг худалдан авах замаар банкны активын үр ашгийг нэмэгдүүлж, шинээр олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай холбоо тогтоож, бондын хоёрдогч зах зээл дээр идэвхтэй оролцох болсон нь онцлох амжилт болсон.


**ЗГҮЦ - ны зах зээлд эзлэх хувь**



## Биет алтны зах зээл

ХХБ дотоодын биет алтны зах зээл дээр голлох байр суурийг эзэлсээр ирсэн бөгөөд өнгөрсөн онд харилцагчиддаа шинэ бүтээгдэхүүн санал болгох, зах зээлийн талаарх шинэлэг мэдээллээр хангах, алтны тооцоо хийх үйл ажиллагааг хялбарчлах, алт хүлээн авах цагийг уртасган ажиллалаа. Ингэснээр алт олборлогч томоохон аж ахуйн нэгжүүдтэй харилцаагаа өргөжүүлж, өмнөх жилүүдээс даруй 2 дахин их алт худалдан авсан байна.


## Биет алт худалдан авалт



## Валютын зах зээл

Эдийн засгийн тухайн нөхцөл байдлаас шалтгаалсан төгрөгийн ханшийн огцом хэлбэлзэл валютын зах зээлд ихээхэн хүндрэл учруулж байсан ч тус банк оновчтой бодлого авч хэрэгжүүлсний үр дүнд ханшийн эрсдэлийг бууруулж, харилцагчдынхаа валют арилжааны хэрэгцээг тогтвортой ханган ажиллалаа. Валют арилжааны эргэлтийг 2.3 дахин нэмэгдүүлсний дээр Монголбанкны үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн гол хэрэгжүүлэгчээр сонгогдож, нефть импортлогч компаниудын форвард, своп арилжааг түргэн шуурхай гүйцэтгэж байсан нь дотоодын валютын зах зээлийн гол оролцогч болохыг хангалттай харуулсан юм. Мөн онлайн банк үйлчилгээг ашиглан, валютын арилжааны ханш тохиролцох бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд анхлан санал болголоо.

## Валютын зах зээлд эзлэх хувь



## Актив, пассивын удирдлага

Актив пассивыг зохистой удирдсанаар ХХБ - ны нийт активын хэмжээ 89.7 хувиар өсч, 5.1 их наяд төгрөгт хүрсэн ба Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаасны хэмжээ 1.9 дахин өсч, нийт активын 15.1 хувьд хүрсэн байна. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 87.5 хувиар өсч, 4.37 их наяд төгрөгт хүрсэн бол төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 37.2 хувиас 42.4 хувь болж сайжирлаа.



## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

# 8

ХХБ - ны хувьд макро эдийн засаг болон бусад хүчин зүйлээс учирч болох эрсдэлийн түвшинг оновчтой тооцож, зөв удирдлага хэрэгжүүлэн хянаж ажилласны дүнд үйл ажиллагааны тогтвортой байдлыг бүрэн хангаж, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэн, чанаргүй зээлийн хувь хамгийн бага түвшинд буюу 1.07 хувьд хүрч буурсан жил боллоо.

## Эрсдэлийн удирдлага

2013 онд эдийн засгийн өсөлт 2 оронтой тоонд хүрч, өндөр өсөлт үзүүлсэн боловч нөгөө талдаа гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, төлбөрийн тэнцлийн алдагдал өссөнөөр төгрөгийн ханш суларсан нь банкны системд томоохон эрсдэл учруулсан он байлаа.

Харин ХХБ - ны хувьд макро эдийн засаг болон бусад хүчин зүйлээс учирч болох эрсдэлийн түвшинг оновчтой тооцож, зөв удирдлага хэрэгжүүлэн хянаж ажилласны дүнд үйл ажиллагааны тогтвортой байдлыг бүрэн хангаж, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэн, чанаргүй зээлийн хувь хамгийн бага түвшинд буюу 1,07 хувьд хүрч буурсан жил боллоо.

### Зээлийн эрсдэл

Олон улсын эрсдэлийн удирдлагын чиглэлээр зөвлөмж гаргадаг Базелийн хорооноос гаргасан Базел II, Базел III - ыг нэвтрүүлэхээр зээлийн багцын эрсдэлийг удирдах зааврыг боловсруулан, том, жижиг - дунд болон жижиг зээлдэгчийн рейтинг тооцооллын арга аргачлалыг олон улсын стандартаар сайжрууллаа. Цаашид дотоод рейтингэд суурилсан зээлийн багцын эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэн ажиллахыг зорьж байна.


Мөн банкны зээлийн багцад төвлөрөл өндөртэй эдийн засгийн салбаруудад олгосон зээлийн багцын чанарт илүү анхаарч, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, бууруулах зорилготой голлох эдийн засгийн салбаруудын судалгаа болон макро эдийн засгийн судалгааг тогтмол хийж гүйцэтгэж байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн ипотекийн жилийн 8 ( $\pm 1$ ) хувийн хүүтэй зээлийн олголт нэмэгдсэнтэй холбогдуулан, ХХБ зах зээлд үүссэн орон сууцны үнийн хөөсрөлтийг тогтоон барих, улмаар зээлийн эрсдэлийг хязгаарлах бодлогын хүрээнд тайлант онд УБ, Дархан, Эрдэнэт хотуудын хэмжээнд нийт 204 орон сууцны хороолол, хотхонд жишиг үнэ тогтоож, орон сууцны зах зээлийн мэдээллийн бааз үүсгэн, үнэлгээний арга аргачлалыг илүү сайжруулж, загварчиллаа.

Нидерландын Хөгжлийн Банктай хамтран олон улсад ашиглагдаж байгаа Байгаль Орчин, нийгмийн хариуцлагын бодлого, түүнийг хэрэгжүүлэх заавар, үнэлгээний арга аргачлалыг дотооддоо амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд олон улсын аудитын Прайс Уотерхаус Куперс (PWC) байгууллагаас тус бодлогын хэрэгжилтэд “сайн” гэсэн үнэлгээ өглөө.

“Байгаль Орчин, Нийгмийн Хариуцлага” - тай холбоотой үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг үнэлэх арга аргачлал, эрсдэл ба хяналтын тогтолцоог бүрдүүлж, банкнаас олгож буй бүх бизнесийн зээлд байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийн үнэлгээг хийж ажиллалаа.

### ХХБ - ны зээлийн эрсдэлийг бууруулах үе шат



## Зах зээлийн эрсдэл

Банкны гол эрсдэлүүдийг үнэлэх арга аргачлал, загварыг судлан сайжруулах, нэвтрүүлэх, улмаар хүлээж болзошгүй эрсдэлд дүгнэлт гаргах, макро эдийн засаг, гадаад эдийн засаг, банк санхүүгийн салбарын судалгааг өргөн хүрээнд хийсэн нь хөрвөх чадварын эрсдэл, хүүгийн эрсдэл, арилжааны эрсдэл, харилцагч тал, улс орны эрсдэлийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, үнэлгээний арга аргачлалыг үе тутам хөгжүүлэх үндэс суурийг бий болголоо.

## Ханшийн эрсдэл

Ханшийн хэлбэлзлээс үүсч болзошгүй алдагдлыг бууруулахын тулд ХХБ - ны нээлттэй байлгах позицийн хэмжээнд лимит тогтоон, өдөр бүр хамгийн их алдаж болох алдагдлын хэмжээг тооцож, улмаар хяналт тогтоон ажиллаж байна. Ханшийн эрсдэлийг “Conditional Value – at – Risk” аргачлалын төрөл GARCH болон EWMA аргачлалаар давхар тооцдог бөгөөд 2013 онд VaR тооцооллын хэтрэлт зөвхөн 2 удаа гарсан нь Монголбанкны “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих” журмын дагуу “НОГООН” бүсэд харьяалагдаж байна.

## Харилцагч тал, улс орны эрсдэл

Олон улсын практик, зөвлөмжүүдэд тулгуурлан, “Харилцагч тал, улс орны эрсдэлийн лимитийн бодлого”, эрсдэлийн үнэлгээний арга аргачлалыг шинээр нэвтрүүллээ. Энэ нь олон улсын зах зээл дээр санхүүгийн үйл ажиллагаа явуулахад тухайн улсын болон харилцагч талын эрсдэлтэй холбоотойгоор банкинд учирч болох алдагдлыг хязгаарлах болон хянах, удирдахад тустай юм.

Дотоодын арилжааны банкуудын эрсдэлийн түвшинг үнэлэх зорилгоор Moody’s - ийн үнэлгээний аргачлалын дагуу рейтингийн загварыг боловсруулсан ба үүний үр дүнд банкуудыг эрсдэлийнх нь түвшингээр бодитой эрэмбэлэх боломжтой болсон ба рейтингд суурилсан арилжааны лимит болон бусад хэлцлийн лимитүүдийг тогтоон ажиллаж байна.

## Үйл ажиллагааны эрсдэл

Бүтээгдэхүүн, үйл ажиллагааг эрсдэлд өртөмтгий байдлаар эрэмбэлж, эрсдэл тогтоолтыг хийн, олон улсын Базелийн зарчмын дагуу эрсдэлийн уршигт байдал, эрсдэл гарах магадлал, хяналтын үр дүнтэй байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эрсдэлийн түвшинг тодорхойлж, эрсдэлийг бууруулах зөвлөмжийг боловсруулан,

холбогдох газар, нэгжид хүргүүлэх замаар үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Мөн эрсдэл тогтоолтын үйл ажиллагаанд эргэн хяналт хийх аргачлалыг нэвтрүүлсэн нь эрсдэлийг бууруулах чиглэлээр өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга замыг нэмэгдүүлж байгаа юм.

2013 онд Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бодлого, “Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах журам” - ыг шинэчлэн баталж, мэдээллийн технологийн эрсдэлийн талаарх ойлголтыг шинээр тодорхойлж гарган, бүтээгдэхүүн үйлчилгээ бүрт мэдээллийн технологийн эрсдэлийг тооцон ажиллалаа.

## Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл

ХХБ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол улсын хууль, дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагуудын зөвлөмж, стандартад нийцсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны бодлого, журмыг боловсруулан гаргаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Харилцагчид данс нээх, үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай харилцаа тогтоох, хамтран ажиллахдаа мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, шаардлагыг баримтлан ажиллаж, харилцагчаа таньж ажиллах зарчмыг мөрдөх, гүйлгээний мэдээллийг олон улсын зохицуулагч байгууллагуудын жагсаалтуудтай тулгаж шалгах, төлбөр шилжүүлэгт бодит цагийн горимын дагуу дэлгэцийн хяналтыг хийж ажиллаж байна.

ХХБ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, ижил төрлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Прайс уотерхаус Куперс (PWC) олон улсын зөвлөх байгууллагатай хамтран комплаенсийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчныг улам сайжруулж, Монгол улсад анх удаа мөнгө угаалттай тэмцэх олон улсын жишигт нийцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн банк болж чадлаа.





# 9

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

ХХБ 2013 онд банк санхүүгийн салбарт мэдээллийн технологийн хурд хүч, шинэ, дэвшилтэт бүтээгдэхүүн үйлчилгээг бизнес, үйл ажиллагаандаа ашигладаг тэргүүлэх байр сууриа бататгаж, энэ чиглэлээр томоохон ажил, төслүүдийг хийж гүйцэтгэлээ.



## Мэдээллийн технологи

Худалдаа, хөгжлийн банк 2013 онд банк санхүүгийн салбарт мэдээллийн технологийн хурд хүч, шинэ, дэвшилтэт бүтээгдэхүүн үйлчилгээг бизнес, үйл ажиллагаандаа ашигладаг тэргүүлэх байр сууриа бататгаж, энэ чиглэлээр томоохон ажил, төслүүдийг хийж гүйцэтгэлээ.

### Зээлийн үйл ажиллагаа хурдаслаа

Банкны суурь системд барьцаа хөрөнгийн нэмэлт модулийг нэвтрүүлснээр банкны ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж дээшилж, зээлийн үйл ажиллагаа хурдсаж, харилцагчид олгох зээлийн судалгааны хугацаа улам буурсан байна.

Түүнчлэн, дотоод үйл ажиллагаа, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор зээлийн болон бусад харилцагчтай байгуулж байгаа гэрээнүүдийг автоматжуулах ажлууд хийгдлээ.

### Хүний нөөцийн цогц программыг нэвтрүүлэв

Хүний нөөцийн цогц программ хангамжийг дотооддоо боловсруулж нэвтрүүлсэн нь банкны хүний нөөцийн бодлого, боловсон хүчний судалгаанд өндөр ач холбогдолтой болсон юм.

### Брокер дилерийн компаниуд онлайн үйлчилгээ авах боломжтой болов

ХХБ - ны харилцагч брокер, дилерийн компаниудад зориулсан Клиринг банкны программ хангамжид тухайн компанийн данс болон харилцагч нарынхаа дансны мэдээлэл, гүйлгээг бодит цагийн горимоор лавлах, өөрсдийн систем рүү шууд дамжуулах боломжийг бий болгосон. Энэ нь үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллага, хувь хүмүүст онлайн үйлчилгээ үзүүлэх өргөн боломжийг нээж өгсөн юм.

### ЮнионПэй чип карт, JCB карт хүлээн авах дэд бүтцийг бий болгов

ЮнионПэй чип карт хүлээн авах дэд бүтцийг бүрдүүлэх, холбогдох хөгжүүлэлт тестийг хийснээр уг төрлийн картыг Монгол улсдаа хамгийн анх хүлээн авч эхэлсэн. Мөн JCB брэндийн карт хүлээн авах орчныг бүрдүүлэх ажлыг Монголбанктай хамтран хэрэгжүүлснээр Монголын бусад банкуудын JCB картыг хүлээн авах үндсэн гарц нь ХХБ болсон байна.





# 10

## ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

2013 он ХХБ-ны хувьд үйл ажиллагааг эрчимжүүлэх, цар хүрээгээ тэлэх зорилтын жил байсан тул хүний нөөцийн удирдлагыг энэхүү зорилтын хүрээнд амжилттай зохион байгуулсны зэрэгцээ “зөв бөгөөд хэрэгтэй хүн” гэсэн уламжлалт бодлогыг хөгжүүлэн ажиллалаа.

## Хүний нөөцийн удирдлага

Банкны үнэт зүйлийг бүрдүүлэгч, бүтээгч ажилтнуудаа идэвхжүүлэх, хөгжүүлэх, өндөр бүтээмжтэй ажиллуулах нөхцлийг бий болгон, менежментийн шилдэг аргуудыг хэрэглэн, хүний хөгжил, идэвх, амжилтанд суурилан чадварлаг, бүтээмж өндөртэй багийг бүрэлдүүлэн, түүний амжилттай ажиллагааг хангах замаар Худалдаа, хөгжлийн банкны эрхэм зорилго, хэтийн болон ойрын зорилтыг хэрэгжүүлэхэд 2013 онд хүний нөөцийн цогц үйл ажиллагаа чиглэгдлээ.

Үүнд:

- > Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох
  - Сонголт хийх талбар болон сувгуудыг өргөн ашиглах
  - Сонгон шалгаруулалт - зан төлөвт суурилсан ярилцлага
  - Сонгон шалгаруулалтад багийн үнэлгээг хэрэгжүүлэх
  - Сонгон шалгаруулалтын үр дүнг тодорхой цаг хугацааны хүрээнд тооцох
- > Хүний нөөцийн төлөвлөлтийг 2013 оны зорилго, зорилттой уялдуулах
  - Дасан зохицох хөтөлбөр
  - Албан тушаалын өсөлт, хөрвөх чадварын төлөвлөлт
  - Сургалт хөгжлийн төлөвлөлт
  - Нөхөн хангалтын төлөвлөлт
- > Хүний нөөцөө хөгжүүлэх
 

Ажилтнуудын сургалт, хөгжлийг банкны эрхэм зорилго, үр өгөөжийг дээшлүүлэх, зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

  - Сургалтын хэрэгцээг бодитойгоор тодорхойлох, 2013 оны зорилтыг хэрэгжүүлэхэд сургалтыг чиглүүлэх

- Сургалтын цар хүрээг нэмэгдүүлж, ажилтан бүрт хүргэх, тогтмолжуулах
  - Сургалтын зохион байгуулалт, арга хэлбэрийг боловсронгуй болгох, сургалт, хөгжлийг уламжлалт арга болон технологийн дэвшилтэт аргыг хослуулах
  - Сургагч багш нарыг чанаржуулах
  - Дунд шатны удирдах ажилтныг хөгжүүлэх
  - Ажилтны идэвхи, санаачлагад суурилсан хүний хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
  - Дээрх чиглэлээр үр дүнгээ өгөхүйц хөтөлбөрүүд хэрэгжүүлэх
- > Ажилтнуудыг идэвхжүүлэх, тогтворжуулах
    - Зорилтыг ойлгуулах, хэрэгжүүлэх арга замыг хамтран боловсруулах
    - Ажлын үр дүнтэй уялдсан цалин урамшуулал, хангамжийн шударга систем
    - Материаллаг бус идэвхжүүлэлтийн аргыг хэрэглэх
    - Байгууллагын соёлын түвшинг өндөржүүлэх
    - Ажилтнуудын нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх боломжийн хүрээг тэлэх
    - Багийн болон хувь хүний амжилтын уялдааг ажилтанд мэдрүүлэх, оролцоог нэмэгдүүлэх
  - > Хүний нөөцийн үйл ажиллагаанд орчин үеийн арга барил, цахим технологийг өргөн ашиглах, бүтээмжийг нэмэгдүүлэх
    - Хүний нөөцийн болон цалингийн программыг шинэчлэх
    - Мэдээллийн шинэ шинэ булангуудыг бий болгож, дотоод веб хуудсанд байрлуулах
    - Цахим сүлжээ ашиглан дотоод мэдээллийн хурдыг нэмэгдүүлэх

### Үзүүлэлтүүд

### 2013 оны жилийн эцсийн үзүүлэлтийг 2012 оны мөн үеийнхтэй харьцуулсан дүн

Ажилтнуудын тоо	11.6%
Мөнгөн бус шагналд хамрагдсан ажилтны тоо	15.7%
Сургалтад хамрагдсан ажилтны тоо	8.8%
Нэг ажилтны бүтээмжийн өсөлт	48.0%

## Ностро данстай банкууд

NO	BANK NAME	LOCATION	SWIFT	CURRENCY	ACCOUNT NO	
1	AGRICULTURAL BANK OF CHINA	HUHHOT, CHINA	ABOCCNB050	USD	05710114040000937	
2	STANDARD CHARTERED BANK	NEW YORK, USA	SCBLUS33		3582023404001	
3	CITIBANK N.A.,	NEW YORK, USA	CITIUS33		36202093	
4	HSBC BANK USA N.A	NEW YORK, USA	MRMDUS33		000304298	
5	ZAO UNICREDIT BANK	MOSCOW, RUSSIA	IMBKRUUM		001201442 USD 400202	
6	KOREA EXCHANGE BANK	SEOUL, KOREA	KOEXKRSE		963-THR-287-01-1	
7	CHINA CONSTRUCTION BANK	HUHHOT, CHINA	PCBCCNBJNME		15014150509220100065	
8	INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ERLIANHAOTE, CHINA	ICBKCNBJNMA		0610040629200091076	
9	OJSC SBERBANK, BAIKALSKY OFFICE	IRKUTSK, RUSSIA	SABRRU66		3011840718000000007	
10	BAO SHANG BANK	BAO TOU, CHINA	BTCBCNBXXX		0016388968000060	
11	OCBC BANK	SINGAPORE	OCBCSGSG	503-071441-301		
12	JSC RUSSIAN AGRICULTURAL BANK	MOSCOW, RUSSIA	RUAGRUMM	3011840900000000008		
13	JSC VTB BANK	MOSCOW, RUSSIA	VTBRRUMM	3011840855500000000		
14	HANA BANK	SEOUL, KOREA	HNBKRXSEXXX	06091000114631		
15	COMMERZBANK AG	FRANKFURT AM MAIN, GERMANY	COBADEFF	400878500800 USD		
16	COMMERZBANK AG	FRANKFURT AM MAIN, GERMANY	COBADEFF	400878500801 EUR		
17	ING BELGIUM NV/SA	BRUSSELS, BELGIUM	BBRUBEBB010	301-0104154-57-EUR		
18	CREDIT SUISSE	ZURICH, SWITZERLAND	CRESCHZZ80A	CHF	0835-0993850-73-000	
19	BANK OF TOKYO-MITSUBISHI UFJ LTD	TOKYO, JAPAN	BOTKJPJT	JPY	653-0439924	
20	MIZUHO CORPORATE BANK LTD	TOKYO, JAPAN	MHCBJPJT		5793010	
21	SUMITOMO MITSUI BANKING CORPORATION	TOKYO, JAPAN	SM-CJPJTXXX		5070	
22	HSBC BANK PLC	LONDON, UNITED KINGDOM	MIDLGB22	GBP	00334567	
23	KOREA EXCHANGE BANK	SEOUL, KOREA	KOEXKRSE	KRW	0963 FRW 001000043	
24	AGRICULTURAL BANK OF CHINA, NEIMENGGU BRANCH	HUHHOT, CHINA	ABOCCNB050	CNY	05710101040021997	
25	CHINA CONSTRUCTION BANK, ERLIANHAOTE SUB BRANCH	HUHHOT, CHINA	PCBCCNBJNME		15001658408052501192	
26	BAO SHANG BANK	BAOTOU, CHINA	BTCBCNBXXX		0016388968000010	
27	PUDONG DEVELOPMENT BANK OF SHANGHAI	SHANGHAI, CHINA	SPDB CNSH XXX		99010154100000100	
28	BANK OF CHINA (HONG KONG) LIMITED	HONG KONG, CHINA	BKCHKHKKH		012-875-60117544	
29	INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ERLIANHAOTE, CHINA	ICBKCNBJNMA		0610040629200090972	
30	BANK OF CHINA, ERLIAN BRANCH	ERLIANHAOTE, CHINA	BKCHCNBJ89N		152418818188	
31	HSBC BANK AUSTRALIA LTD	SYDNEY, AUSTRALIA	HKBAAU2S		011-795630-041	
32	AUSTRALIA AND NEW ZEALAND BANKING GROUP LIMITED	MELBOURNE, AUSTRALIA	ANZBAU3MXXX		AUD	921064AUD00001
33	CANADIAN IMPERIAL BANK OF COMMERCE	TORONTO, CANADA	CIBCCATT		CAD	1820613
34	ZAO UNICREDIT BANK	MOSCOW, RUSSIA	IMBKRUUM	RUB	001201442 RUR 400202	
35	OJSC SBERBANK, BAIKALSKY OFFICE	IRKUTSK, RUSSIA	SABRRU66		3011810918000000002	
36	JSC VTB Bank	MOSCOW, RUSSIA	VTBRRUMM		301181045550000203	
37	JSC RUSSIAN AGRICULTURAL BANK	MOSCOW, RUSSIA	RUAGRUMM		3011810800000000015	
38	HONGKONG AND SHANGHAI BANKING CORPORATION LTD	AUCKLAND, NEW ZEALAND	HSBCNZ2A	NZD	040-013294-261	
39	BANK OF TOKYO-MITSUBISHI UFJ LTD	HONG KONG	BOTKHKHKKH		250-012796-001	
40	OCBC BANK	SINGAPORE	OCBCSGSG	SGD	517-123360-001	
41	NORDEA BANK AB	STOCKHOLM, SWEDEN	NDEASESS	SEK	39527705290 080502	



---

# ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

---

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар  
болгосон жилийн Нэгтгэсэн санхүүгийн тайлан

---

(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

Улаанбаатар хот  
2014 он



# 11

## Агуулга

- 1 Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын мэдэгдэл
- 2 Хараат бус аудиторын дүгнэлт
- 3 Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан
- 4 Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан
- 5 Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан
- 6 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 7 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

## Худалдаа Хөгжлийн Банк ХХК Группын мэдээлэл

### Албан ёсны хаяг

Монгол Улс, Улаабаатар хот, Бага тойруу -12,  
Жуулчины гудамж 7

### Төлөөлөн Удирдах Зөвлөл

Д. Эрдэнэбилэг (Дарга)  
Р. Коппа  
З. Шагдарсүрэн  
Т. Цолмон  
Ч. Энхболд

### Нарийн бичгийн дарга

Д. Даваажав

### Хараат бус аудитор

Кэй Пи Эм Жи Аудит ХХК, Монгол Улс,  
Улаанбаатар хот

## Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын мэдэгдэл

Худалдаа, хөгжлийн банк ХХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Эрдэнэбилэг, Ерөнхийлөгч Р.Коппа, Гүйцэтгэх захирал Б.Мэдрээ болон Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал Д.Янжмаа бид энд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь банк болон түүний охин компаниудын 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг батламжилж байна.



ТУЗ-ийн дарга

**Д. Эрдэнэбилэг**



Ерөнхийлөгч

**Р. Коппа**



Гүйцэтгэх захирал

**Б. Мэдрээ**



Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал

**Д. Янжмаа**



## Хараат бус аудиторын дүгнэлт

Худалдаа Хөгжлийн Банк ХХК - ийн  
Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Бид Худалдаа хөгжлийн банк ХХК (“Банк”) болон түүний охин компаниуд (хамтдаа “Групп”)-ийн 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилүүдийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлого, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон тайлбар тодруулгаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаархи банкны удирдлагын хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх), түүнд нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь банкны удирдлагын үүрэг, хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг хэрэгжүүлэх нь энэхүү хариуцлагад хамаарна.

### Аудиторын хариуцлага

Хийсэн аудитын ажилдаа үндэслэн нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт гаргах нь бидний хариуцлага билээ. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Энэхүү стандарт нь биднээс нэгтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн талаархи зохистой нотолгоог олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг шаарддаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын талаархи аудитын нотолгоог олж авахын тулд горимуудыг гүйцэтгэх нь мөн аудитын ажилд багтдаг. Горимын сонголт нь аудиторын мэргэжлийн үнэлэлт дүгнэлтээс хамаарах бөгөөд үүнд залилан буюу алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайланг материаллагаар буруу илэрхийлэх эрсдэлийн үнэлгээ хамаарна. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах биш, харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс банкны нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Мөн банкны удирдлагын хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, хийсэн тооцооллын үндэслэл болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг аудитын явцад үнэлдэг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группын 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

### Бусад

Энэхүү тайлан нь зөвхөн Банкны гишүүдэд, нэгдмэл этгээд болохын хувьд зориулагдсан бөгөөд аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд банкны гишүүдээс бусад хүмүүсийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
2014 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүй болохыг анхаарна уу.

	Тод	2013 Мян.төг	2012 Мян.төг
<b>Хөрөнгө</b>			
Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө	5	1,090,245,012	444,813,254
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	6	885,112,661	456,801,610
Хараат болон хамтарсан компани дахь хөрөнгө оруулалт	7	10,416,001	2,385,599
Зээл ба урьдчилгаа, цэвэр	8	2,530,557,178	1,533,271,823
Хоёрдогч зээл	9	7,000,000	7,000,000
Үндсэн хөрөнгө, цэвэр	10	153,297,326	131,590,999
Биет бус хөрөнгө, цэвэр	11	4,270,615	601,831
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	12	33,388,245	-
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө, цэвэр	13	6,057,155	157,148
Бусад хөрөнгө	14	403,730,785	123,856,952
<b>Хөрөнгийн дүн</b>		<b>5,124,074,978</b>	<b>2,700,479,216</b>
<b>Өр төлбөр ба өөрийн хөрөнгө</b>			
<b>Өр төлбөр</b>			
Херилцагчдын харилцах, хадгаламж	15	2,139,692,149	1,402,326,763
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	16	172,109,699	36,518,483
Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас	17	372,650,503	1,495,638
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	18	1,157,090,928	232,964,084
Татварын өглөг		7,646,234	2,481,600
Гаргасан өрийн бичиг	19	460,563,148	600,525,865
Хоёрдогч өглөг	20	66,036,156	55,528,846
Бусад өр төлбөр	21	379,224,697	128,761,887
<b>Өр төлбөрийн дүн</b>		<b>4,755,013,514</b>	<b>2,460,603,166</b>
<b>Өөрийн хөрөнгө</b>			
Хувьцаат капитал	22	16,525,280	16,525,280
Нэмж төлөгдсөн капитал		19,272,456	19,272,456
Халаасны хувьцаа	23	(2,620,626)	(2,620,626)
Дахин үнэлгээний нөөц	10	18,555,196	18,555,196
Борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн хэрэгжээгүй олз	6	14,153,606	25,807,646
Хуримтлагдсан ашиг		301,599,783	162,336,098
<b>Банкны хувьцаа эзэмшигчдэд ноогдох нийт өөрийн хөрөнгийн дүн</b>		<b>367,485,695</b>	<b>239,876,050</b>
<b>Цеенхийн хувь оролцоо</b>	4	<b>1,575,769</b>	<b>-</b>
<b>Өөрийн хөрөнгийн дүн</b>		<b>369,061,464</b>	<b>239,876,050</b>
<b>Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>		<b>5,124,074,978</b>	<b>2,700,479,216</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

	Тод	2013 Мян.төг	2012 Мян.төг
Хүүний орлого	25	321,438,593	213,335,115
Хүүний зардал	26	(200,692,181)	(137,432,198)
<b>Хүүний цэвэр орлого</b>		<b>120,746,412</b>	<b>75,902,917</b>
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	27	21,525,806	16,399,523
Үйл ажиллагааны бусад орлого, цэвэр	28	68,684,766	14,303,110
<b>Хүүний бус цэвэр орлого</b>		<b>90,210,572</b>	<b>30,702,633</b>
<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>210,956,984</b>	<b>106,605,550</b>
Үйл ажиллагааны зардал	29	(44,477,351)	(32,875,568)
Хараат компанийн ашгаас ноогдох хувь	7	204,056	(2,340,356)
Үнэ цэнийн бууралтын (алдагдал) ба нөхөлт	30	(8,255,683)	6,554,436
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>158,428,006</b>	<b>77,944,062</b>
Орлогын татварын зардал	32	(19,164,321)	(14,817,338)
<b>Тайлант жилийн цэвэр ашиг</b>		<b>139,263,685</b>	<b>63,126,724</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
<b>Ашиг, алдагдлаар дахин ангилагдахгүй зүйлс</b>			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн цэвэр өөрчлөлт	10	-	(146,870)
<b>Ашиг, алдагдлаар дахин ангилж болох зүйлс</b>			
Борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн хэрэгжээгүй цэвэр өөрчлөлт	6	(11,654,040)	22,071,596
<b>Бусад дэлгэрэнгүй ашиг (алдагдал)</b>		<b>(11,654,040)</b>	<b>21,924,726</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>127,609,645</b>	<b>85,051,450</b>
<b>Ашгийн хамаарал:</b>			
Банкны хувьцаа эзэмшигчид		139,263,685	63,126,724
Цөөнхийн хувь оролцоо		-	-
<b>Тайлант жилийн цэвэр ашиг</b>		<b>139,263,685</b>	<b>63,126,724</b>
<b>Нийт дэлгэрэнгүй орлогын хамаарал:</b>			
Банкны хувьцаа эзэмшигчид		127,609,645	85,051,450
Цөөнхийн хувь оролцоо		-	-
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>127,609,645</b>	<b>85,051,450</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



Банкны хувьцаа эзэмшигчдэд ноогдох											
Борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан											
Тод	Хувьцаат капитал Мян.төг	Нэмж төлөгдсөн капитал Мян.төг	Халаасны хувьцаа Мян.төг	Дахин үнэлгээний нөөц Мян.төг	Хэрэгжээгүй олз Мян.төг	Хуримтлагдсан н ашиг Мян.төг	Дүн Мян.төг	Цөөнхийн хувь оролцоо Мян.төг	Нийт өмч Мян.төг	Мян.төг	
										Мян.төг	Мян.төг
<b>2013 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл</b>	16,525,280	19,272,456	(2,620,626)	18,555,196	25,807,646	162,336,098	239,876,050	-	-	239,876,050	
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>											
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	139,263,685	139,263,685	-	-	139,263,685	
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>											
Борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн хэрэгжээгүй олз	-	-	-	-	(11,654,040)	-	(11,654,040)	-	-	(11,654,040)	
<b>Цөөнхийн хувь оролцоотой охин компанийн худалдан авалт</b>											
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	139,263,685	127,609,645	1,575,769	1,575,769	129,185,414	
<b>2013 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	16,525,280	19,272,456	(2,620,626)	18,555,196	14,153,606	301,599,783	367,485,695	1,575,769	1,575,769	369,061,464	

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Банкны хувьцаа эзэмшигчдэд ноогдох											
Борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан											
Тод	Хувьцаат капитал Мян.төг	Нэмж төлөгдсөн капитал Мян.төг	Халаасны хувьцаа Мян.төг	Дахин үнэлгээний нөөц Мян.төг	Хэрэгжээгүй олз Мян.төг	Хуримтлагдсан ашиг Мян.төг	Дүн	Нийт өмч	Борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан		
									Мян.төг	Мян.төг	Мян.төг
<b>2012 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл</b>											
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>											
	6,610,113	7,392,191	(6,001,872)	18,702,066	3,736,050	108,976,296	139,414,844	139,414,844			
Тайлант жилийн ашиг											
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>											
	-	-	-	-	-	63,126,724	63,126,724	63,126,724			
6	-	-	-	-	22,071,596	-	22,071,596	22,071,596			
10	-	-	-	(146,870)	-	148,245	1,375	1,375			
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>											
<b>Банкны эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээ</b>											
<b>Дахин хуваарилалт</b>											
22	9,915,167	-	-	-	-	(9,915,167)	-	-			
23	9,915,167	11,880,265	3,381,246	-	-	-	15,261,511	15,261,511			
	16,525,280	19,272,456	(2,620,626)	18,555,196	25,807,646	162,336,098	239,876,050	239,876,050			
<b>2012 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>											

Хавсаргасан тодруулаа нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

	Тод	2013 Мян.төг	2012 Мян.төг
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:</b>			
<b>Цэвэр ашиг</b>		139,263,685	63,126,724
Тохируулга:			
Элэгдэл ба хорогдуулалт	10, 11, 29	4,168,064	2,763,673
Хараат компанийн ашиг (алдагдал)-аас ноогдох хувь	7	(204,056)	2,340,356
Үнэт цаас борлуулсаны олз		(27,696,971)	-
Хүүний цэвэр орлого	25, 26	(120,746,412)	(75,902,917)
Орлогын татварын зардал	32	19,164,321	14,817,338
Үндсэн хөрөнгө борлуулсаны гарз		720	4,841
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	29	18,772	28,716
Үнэ цэнийн бууралтын (олз) гарз	30	8,255,683	(6,554,436)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний олз	12	(7,171,395)	-
Үйл ажиллагааны бусад орлого		-	(542,915)
<b>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг:</b>		15,052,411	81,380
Зээл ба урьдчилгааны өсөлт	8	(1,011,604,706)	(405,634,813)
Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаасны бууралт		-	36,966,114
Бусад хөрөнгийн өсөлт (*)	14	(255,666,692)	(60,851,432)
Харилцагчийн харилцах, хадгаламжийн өсөлт	15	737,365,386	125,030,801
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжийн өсөлт	16	135,591,216	1,454,928
Бусад өр төлбөрийн өсөлт (*)	21	240,554,846	41,979,569
Заавал байлгах нөөцийн өсөлт	5, 34	(438,486,750)	(82,471,171)
Бусад санхүүгийн байгууллагаас авах авлагын бууралт	34	-	3,613,520
Хүлээн авсан хүү		298,189,264	202,169,315
Төлсөн хүү		(187,720,638)	(121,796,735)
Төлсөн орлогын татвар		(14,001,498)	(13,836,926)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		(480,727,161)	(273,295,450)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:</b>			
Худалдан авсан хөрөнгө оруулалтын үнэт цаас	6	(709,471,336)	(295,944,740)
Худалдсан хөрөнгө оруулалтын үнэт цаас	6	297,198,079	207,955,765
Худалдан авсан үндсэн хөрөнгө	10	(49,148,114)	(55,343,822)
Худалдан авсан биет бус хөрөнгө	11	(964,803)	(490,317)
Борлуулсан өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	13	157,148	669,505
Худалдсан үндсэн хөрөнгө	10	33,709	422,469
Хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө	7	(7,784,766)	(2,450,000)
Охин компанийн худалдан авалт	4	(4,791,214)	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		(474,771,297)	(145,181,140)

(\*) Хуримтлагдсан хүүгийн авлага, хуримтлагдсан хүүгийн өглөгийн өөрчлөлтөөс бусад актив, бусад пассивын хэлбэлзэлийг илэрхийлнэ.

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

	Тод	2013 Мян.төг	2012 Мян.төг
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:</b>			
Санхүүгийн байгууллагаас авсан зээлийн өсөлт	18	969,513,213	59,726,601
Санхүүгийн байгууллагаас авсан зээлийн бууралт	18	(45,386,369)	(1,143,033)
Буцаан худалдан авах гэрээгээр борлуулсан үнэт цаасны өсөлт (бууралт)	17	371,154,865	(169,988,831)
Гаргасан өрийн бичгийн өсөлт	19	-	411,645,575
Гаргасан өрийн бичгийн бууралт	19	(143,293,377)	(19,828,992)
Хоёрдогч өглөгийн өсөлт	20	10,455,134	13,794,728
Худалдсан халаасны хувьцаа	23	-	15,261,511
		<u>1,162,443,466</u>	<u>309,467,559</u>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)</b>		206,945,008	(109,009,031)
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<u>194,277,433</u>	<u>303,286,464</u>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	34	<u>401,222,441</u>	<u>194,277,433</u>

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



## 1 Үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Худалдаа Хөгжлийн Банк ХХК (цаашид “Банк” гэх) нь хяналтын эрх бүхий толгой компани болон түүний нэгтгэлд орох охин компаниуд (хамтад нь “Групп” гэх) –ыг дараах байдлаар нэгтгэсэн:

### **Хяналтын эрх бүхий толгой компани**

Банк нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд юм. Банк нь Монгол Улсын Банкны тухайн хуулийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн No.3/149 тоот тушаалаар банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд Монголбанкнаас 2002 оны 2 дугаар сарын 27-ны өдөр No.8 тоот тусгай зөвшөөрлийг шинэчилж олгосон.

Дээрх шийдвэр, банкны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон банкны дүрмийн дагуу банк нь мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо, гадаад валют худалдан авах, худалдах болон банкны бусад үйл ажиллагааг өөрийн 22 салбар, 25 тооцооны төвөөр дамжуулан эрхэлж байна.

### **Нэгтгэлд орох охин компаниуд**

#### **(i) *Ти Ди Би Капитал ХХК***

Банк нь өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалттай Ти Ди Би Капитал ХХК-ийг 2008 оны 8 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан. Ти Ди Би Капитал ХХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд Компанийн тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд брокер диллер, андеррайтер болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа эрхэлдэг.

#### **(ii) *Ти Ди Би Медиа ХХК***

Ти Ди Би Медиа ХХК нь 2011 онд байгуулагдсан. Банк нь 2011 оноос хойш Улаанбаатар хотод Bloomberg TV Mongolia телевизийн үйл ажиллагаа явуулах тусгай эрхийг Монголын Харилцаа холбооны зохицуулах хорооноос авсан хэвлэл мэдээллийн компани болох Ти Ди Би Медиа ХХК-иар дамжуулан олон улсын санхүүгийн мэдээ, мэдээллийг цацах зорилгоор Bloomberg L.P.-тэй хамтран ажиллаж байна. Групп нь 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Ти Ди Би Медиа ХХК-д нэмэлт хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Ти Ди Би Медиа ХХК-ийн ойролцоогоор 84.4 хувийг эзэмшиж байна.

Группын шууд хамаарах толгой компани нь Luxembourg хотод үүсгэн байгуулагдсан Globull Investment and Development SCA (“Globull”) компани бөгөөд тус группын 65.83 хувийг эзэмшдэг ба Globull Investment and Development (“Globull”) компанийн толгой компани нь АНУ-ийн US Global Investment компани юм. US Global Investment компани нь Сентрал Азиа Майнинг ХХК болон ноён Должингийн Эрдэнэбилэг (одоогийн группын ТУЗ-ийн дарга) эзэмшлийн консорциум бөгөөд группын 7.32 хувийг шууд эзэмшдэг. 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар US Global-ийн шууд болон шууд бусаар Globull-аар дамжуулан Группд эзэмшиж буй хувь нь ойролцоогоор 73.14 байна. Goldman Sachs 157,862 ширхэг буюу 4.78 хувийн хувьцаа эзэмшдэг бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар группын эргэлтэнд байгаа нийт энгийн хувьцааны ойролцоогоор 18.27 хувь нь иргэн, хувь хүмүүсийн эзэмшилд байна.

## 2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

### Санхүүгийн тайлан бэлтгэх үндсэн зарчим

Хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн Монголбанкнаас батлан гаргасан заавар, журмын дагуу бэлтгэгдсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцэхгүй, МонголБанкны журмаар зохицуулсан дараах зүйлс байгаа бөгөөд холбогдох тодруулгуудад дэлгэрэнгүй тайлбарласан болно. Үүнд:

- Зээлийн болзошгүй эрсдлийн сан, авлага, аккредитив, ашиглаагүй зээлийн үүрэг болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн хасагдуулга
- Хойшлогдсон татварын нягтлан бодох бүртгэл

Группын удидлагаас нэгтгэсэн санхүүгийн тайланг 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдөр батлан гаргасан.

### Үнэлгээ

Дараахаас бусад зүйлсийн хувьд нэгтгэсэн санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн:

- Бодит үнэ цэнээр хэмжигдэх дерватив санхүүгийн хэрэгслүүд
- Бодит үнэ цэнээр хэмжигдэх арилжаалах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Худалдан авсны дараа бодит үнэ цэнээр бүртгэх болсон үндсэн хөрөнгө
- Бодит үнэ цэнээр хэмжигдэх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

### Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргасан валют

Группын үйл ажиллагааны валют нь Монгол Улсын үндэсний валют төгрөг юм. Хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайланг нэгжийн оронг мянгачилсан төгрөгөөр бэлтгэсэн.

### Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын зүйлсийн дүнд нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг өөрчлөлт хийгдсэн тухайн жилд болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнд нөлөөлөхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх Группын шүүмжлэлтэй үнэлэмж болон тооцоололын тодорхойгүй байдлын нэг хэсэг нь зээлийн эрсдлийн сан болон санхүүгийн хэрэгсэлүүдийн үнэлгээ юм.

## 2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь (үргэлжлэл)

### Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөчлөлт

#### (i) **НББОУС 1, ‘Санхүүгийн тайлангийн толилуулга’**

Групп нь 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн НББОУС 1 ‘Санхүүгийн тайлангийн толилуулга’ –д хийсэн өөрчлөлтийг мөрдөж эхэлсэн. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр бусад дэлгэрэнгүй орлогыг дараагийн тайлант үед ашиг, алдагдлаар дахин ангилагдах боломжтой эсэхэд суурилж (дахин ангиллын тохируулга) илэрхийлэхийг шаарддаг. Харьцуулсан мэдээллийг ижил сууриар дахин толилуулсан.

#### (ii) **СТОУС 10, ‘Нэгтгэсэн санхүүгийн тайлан’**

Энэ СТОУС-ын зорилго нь аливаа аж ахуйн нэгж нь нэг болон түүнээс дээш аж ахуйн нэгжид хяналт тавьдаг бол нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх ба толилуулах зарчмыг тогтоох явдал юм.

Охин компани гэж өөр нэг компанийн хяналтанд байдаг аж ахуй нэгжийг хэлнэ. Хөрөнгө оруулагч нь хараат компаний үйл ажиллагаанаас өгөөж хүртэх боломжтой бөгөөд тухайн үйл ажиллагааны өгөөжид нөлөөлөх эрх мэдэлтэй бол хараат компанийг хянадаг гэж үзнэ.

#### (iii) **СТОУС 11, ‘Хамтын хэлэлцээр’**

Групп нь 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн СТОУС 11 ‘Хамтын хэлэлцээр’ стандартыг мөрдөж эхэлсэн. Уг СТОУС-аар хамтын хэлэлцээрийг хамтын үйл ажиллагаа болон хамтарсан үйлдвэр гэж хоёр ангилдаг. Хамтын үйл ажиллагаа гэдэг нь хэлэлцээр (өөрөөр хэлбэл хамтран үйл ажиллагаа явуулагч)-т оролцогч хамтын хяналттай талууд нь уг хэлэлцээртэй холбоотой хөрөнгийг ашиглах, өр төлбөрийг хариуцах үүрэг бүхий хамтын хэлэлцээр юм. Хамтарсан үйлдвэр гэдэг нь хэлэлцээрийн цэвэр хөрөнгийг ашиглах эрхтэй, тухайн хэлэлцээрт хамтын хяналттай тал (өөрөөр хэлбэл хамтарсан үйлдвэрт оролцогч) бүхий хамтын хэлэлцээр юм. Уг СТОУС-аар хамтын үйл ажиллагаа явуулагчийг тухайн хэлэлцээр дэх хувь оролцоотой холбогдуулан тодорхой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардалд ашиглаж болох СТОУС-ын дагуу хөрөнгө ба өр төлбөр (мөн холбогдох орлого, зардлаа хүлээн зөвшөөрөхийг)-ийг хүлээн зөвшөөрч хэмжихийг шаардсан болно. Уг СТОУС-аар хамтарсан үйлдвэрт оролцогч аж ахуйн нэгж нь хөрөнгө оруулалтаа хүлээн зөвшөөрч, оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар тооцоолон хүлээн зөвшөөрөхийг шаардсан.

#### (iv) **СТОУС 12, ‘Бусад Аж Ахуйн Нэгж дэх Хувь Оролцооны Тодруулга’**

Групп нь 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн СТОУС 12 ‘Бусад Аж Ахуйн Нэгж дэх Хувь Оролцооны Тодруулга’ стандартыг мөрдөж эхэлсэн. Уг СТОУС нь аж ахуй нэгжийн охин компани дах хувь оролцоо, хамтын хэлэлцээр, хараат болон нэгтгэгдээгүй тусгай зорилготой аж ахуй нэгжийн талаарх бүх шаардалагатай тодруулгыг хамтад нь нэг стандарт болгосон. Групп нь одоогоор охин компани болон хамтын хэлэлцээрийн хувь оролцоо, хараат болон нэгтгэгдээгүй тусгай зорилготой аж ахуйн нэгжүүдийн шаардлагатай тодруулгыг харьцуулан судалж байна. Уг СТОУС нь эдгээр хувь оролцооны шинж чанар, эрсдэл болон санхүүгийн нөлөөллийн талаарх мэдээллийн тодруулгыг шаардсан.

#### (v) **СТОУС 13, ‘Бодит үнэ цэнийн хэмжилт’**

Групп нь 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн СТОУС 13 ‘Бодит үнэ цэнийн хэмжилт’ стандартыг мөрдөж эхэлсэн. Уг СТОУС нь бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийг хэмжих тулгуур үзэл баримтлалыг бие даасан нэг СТОУС-аар тогтоож, бодит үнэ цэнийн хэмжилтийг хэрхэн тодруулах шаардлагыг заасан байна.

### **3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд**

Групп нь тайлант жилд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хэрэгжиж эхэлсэн бодлогоос бусад доор хураангуйлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг энд үзүүлсэн бүх тайлант жилүүдэд тогтвортойгоор хэрэглэсэн болно.

#### **Нэгтгэлийн суурь**

##### **(i) Охин компани**

Охин компаниуд гэж группын хяналтан дор байдаг аж ахуйн нэгжүүдийг хэлнэ. Групп нь хараат компаний үйл ажиллагаанаас өгөөж хүртэх болон тухайн үйл ажиллагааны өгөөжид нөлөөлөх эрх мэдэлтэй үед хараат компанийг хянадаг гэж үзнэ. Охин компаниудын санхүүгийн тайлангууд нь группын охин компаниуд дахь хяналт эхэлснээс дуусгавар болох өдөр хүртэл нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулагдсан байна.

##### **(ii) Нэгтгэлийн үр дүнд хаагдах группын доторх ажил гүйлгээ**

Группын доторх ажил гүйлгээ, дансны үлдэгдэл, болон түүнээс үүссэн хүлээн зөвшөөрөөгүй аливаа орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх явцад цэвэрлэж тайлагнадаг. Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхүйц аливаа үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг бүхий группын доторх алдагдлыг тус тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

##### **(iii) Цөөнхийн хувь оролцоо**

Охин компани дахь цөөнхийн хувь оролцоог түүний толгой компанийн эзэмшлийн хувь оролцооноос тусад нь авч үзнэ. Цэвэр ашиг, алдагдал ба дэлгэрэнгүй орлогын бусад хэсгийн бүрэлдэхүүн бүр нь толгой компанийн эзэмшигчид болон тухайн цөөнхийн хувь оролцоонд хамааралтай байдаг. Үүнд цөөнхийн хувь оролцоог тэгээс бага болтол бууруулсан нөхцөлд мөн адил хамаарна.

#### **Бизнесийн нэгдэл**

##### **(i) Бизнесийн нэгдэл**

Хамтын хяналтанд байдаг аж ахуйн нэгж болон бизнесийн шинж агуулаагүй нэгдлээс бусад бизнесийн нэгдлийг худалдан авалтын аргаар бүртгэлд тусгана.

Тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

Худалдан авалтын өдрөөрх нэгдэгч компанийн цөөнхийн хувь оролцоог тухайн нэгдэгч компанийн цэвэр хөрөнгөнд хувь тэнцүүлэн хэмждэг.

Бизнесийн нэгдэлд шилжүүлсэн үнийг бодит үнэ цэнээр хэмжих ба энэ нь нэгтгэгчээс шилжүүлсэн хөрөнгийн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ, нэгтгэгчээс нэгдэгч талын өмнөх эзэмшигчдэд олгох өр төлбөр болон нэгтгэгчийн гаргасан өмчийн хувь оролцооны нийлбэр байдаг.



### **3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

#### **Бизнесийн нэгдэл (үргэлжлэл)**

##### **(ii) Гүүдвил**

Групп нь худалдан авалтын өдрөөрх гүүдвилийг хэмжихдээ:

- шилжүүлсэн үнийн бодит үнэ цэнэ; нэмэх нь
- нэгдэгч талын цөөнхийн хувь оролцооны хүлээн зөвшөөрсөн дүн; нэмэх нь
- үе шаттайгаар байгуулсан бизнесийн нэгдлийн хувьд, нэгдэгч талд өмнө эзэмшиж байсан хөрөнгийн хувь оролцооны бодит үнэ цэнэ; хасах нь
- худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө болон өр төлбөрийн хүлээн зөвшөөрөгдсөн цэвэр дүн (ихэнхдээ бодит үнэ цэнэ).

Сөрөг гүүдвилийн үед, тохиролцоот худалдан авалтаас үүссэн олзыг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Групп нь хяналтын эрхгүй хувь оролцоог нэмэлтээр худалдан авах үед групп нь өөрийн хөрөнгийн ажил гүйлгээ гэж үзэх тул гүүдвилээр хүлээн зөвшөөрөхгүй.

#### **Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт болон хамтарсан компани**

Хараат компани гэдэг нь Групп тухайн компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогод хяналт тавихгүйгээр мэдэгдэхүйц хэмжээний нөлөө үзүүлдэг компанийг хэлнэ. Групп өөр компанийн санал өгөх эрхийн 20-50 хувийг эзэмшиж байвал мэдэгдэхүйц хэмжээний нөлөөлөлтэй байна гэж үзнэ.

Хамтарсан үйлдвэр гэдэг нь талууд хамтын үйл ажиллагааны цэвэр хөрөнгийг эзэмших эрхтэй буй хамтын хяналт бүхий хамтын зохицуулалтыг хэлнэ. Хамтын хяналт гэж холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэрийг хамтран хяналт тавьж буй бүх талуудын зөвшөөрөлтэйгээр гаргах үед үүсэх гэрээгээр зөвшөөрөгдсөн хамтарсан хяналттай зохицуулалтыг хэлнэ.

Хараат компани дахь хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь бүртгэх ба худалдан авалтын өдрийн дараа Группын ашиг, алдагдал болон охин компанийн өмчийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрснөөр анхны хөрөнгө оруулалтын дансны үнэ нэмэгдэх эсвэл буурч болно. Группын доторх ажил гүйлгээ, дансны үлдэгдэл, болон түүнээс үүссэн хүлээн зөвшөөрөөгүй аливаа орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх явцад устгаж бүртгэнэ. Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхүйц аливаа үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг бүхий группын доторх алдагдлыг тус тайланд алдагдлаар тайлагнана.

Хэрэв группын гишүүн компани нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулагдсан ижил нөхцөл байдал бүхий ажил гүйлгээ болон үйл явдлуудыг тухайн нэгтгэсэн тайланд толилуулагдсанаас өөр нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримтлан тайлагнадаг бол өмчийн аргын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх явцад өөрийн санхүүгийн тайланд зохих залруулгыг хийнэ.

Хэрэв Группын алдагдлаас санхүүжигчид ногдох хэсэг нь түүний өмчийн хувь оролцооноос хэтэрсэн бол тухайн хувь оролцооны дансны үнийг тэг хүртэл бууруулах ба санхүүжигчийн өмнөөс төлбөр төлөх үүрэг хүлээсэн хэмжээнээс давсан цаашид үүсэх аливаа алдагдлыг хүлээн зөвшөөрөхөө зогсооно.

### 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төгрөг валютаар давхар бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөг руу хөрвүүлэн илэрхийлнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар үйл ажиллагааны валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютын ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар тайлагнадаг.

Харин, борлуулах боломжтой өмчийн хөрөнгө оруулалтын хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү (үнэ цэнийн бууралтаас бусад тохиолдол гадаад валютын ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч ашиг, алдагдал руу дахин ангилна)-г бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

#### Санхүүгийн хэрэгслүүд

##### (i) *Ангилал*

Арилжаалах зориулалтын санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь Группын богино хугацааны дотор худалдах зорилгоор худалдан авч, эзэмшиж байгаа өрийн бичиг, өмчийн үнэт цаас, болон бусад үнэт цааснуудаас бүрддэг. Эдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн үр дүнгээр тусгадаг.

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн үр дүнгээр бүртгэх дерватууд нь бодит хамгаалалтын хэрэгсэл гэж нэрлээгүй дерватив гэрээнээс бүрдэнэ. Цэвэр авлага (эерэг бодит үнэ цэнэ) позицитай арилжааны дерватууд, худалдан авсан опционуудыг арилжааны хөрөнгөөр бүртгэдэг. Харин цэвэр өглөг (сөрөг бодит үнэ цэнэ)-ийн позицитай арилжааны дерватууд болон гаргасан/худалдсан опционуудыг арилжааны өр төлбөрөөр бүртгэдэг.

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг ийнхүү ангилахдаа 1) энэхүү ангилал нь нягтлан бодох бүртгэлийн бодит байдалтай үл нийцэх байдлыг бууруулдаг, цаашлаад арилгадаг, 2) холбогдох санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь ямар нэгэн бүлэг санхүүгийн хөрөнгийн, санхүүгийн өрийн эсвэл хоёулангийн бүлэгт багтдаг ба бичиж баримтжуулсан эрсдлийн менежментийн эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу тэдгээрийн үр өгөөжийг бодит үнэ цэнэ дээр нь тулгуурлан үнэлж, удирддаг, 3) иж бүрдэл байх буюу иж бүрдлээс нь салгахгүй байх шалгуурт нийцээгүй дерватив эсэхийг харгалзан үзнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэдэг санхүүгийн өр төлбөрүүдийг бодит үнэ цэнээр тайланд тусгах ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тайлант жилийн үр дүнгээр тусгана.

Богино хугацаанд арилжааны зорилгоор бус харилцагчдад олгосон мөнгийг зээл ба урьдчилгаа гэж үздэг. Зээл ба урьдчилгаа нь харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаанаас бүрдэх ба буцаан цуглуулах боломжтой дүнгээр буюу эрсдлийн санг хассан дүнгээр тайлагнадаг. Эрсдлийн санг Сангийн Яам ба Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Активыг ангилах, активын эрсдлийн санг байгуулах зарцуулах журам”-ын дагуу тооцдог.

Гэрээний хугацаа дуустал эзэмших актив нь тогтмол буюу тодорхой төлбөр бүхий гэрээний тодорхой хугацаатай, Групп нь хугацааг дуустал эзэмших, эзэмшиж чадах ба анхнаасаа арилжааны болон арилжаалах боломжтой гэж тогтоон заагаагүй дерватив бус санхүүгийн хөрөнгө юм. Ийм санхүүгийн хөрөнгөд Группын эзэмшиж буй хөрөнгө оруулалтын үнэт цааснууд багтана.

Арилжаалах боломжтой хөрөнгө гэж арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа болон гэрээний хугацааг дуустал эзэмших активаас бусад санхүүгийн хөрөнгийг хэлнэ.

### **3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

#### **Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)**

##### **(ii) *Анхдагч хүлээн зөвшөөрөлт***

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэх ба бодит үнэ цэнийг нь тухайн жилийн үйл ажиллагааны ашиг алдагдлаар бүртгэхгүй хөрөнгө ба өр төлбөрийн хувьд бодит үнэ цэнэ дээр тэдгээрийг худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой гарсан зардлыг нэмж бүртгэнэ.

##### **(iii) *Дараах үеийн хүлээн зөвшөөрөлт***

Бүх арилжааны санхүүгийн хөрөнгө, өр, бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг тайлант жилийн ашиг алдагдлаар тусгадаг дерватив, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд, арилжаалах боломжтой санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анх бүртгэлд тусгаснаас хойш бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэнэ. Харин идэвхитэй зах зээл дээр зарлагдсан үнэ ханшгүй ба бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй санхүүгийн хөрөнгө, өрийг өртөг ба ажил гүйлгээний өртөг зардлын нийлбэрээс үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайланд тусгана. Арилжааны хэрэгслүүд болон арилжаалах боломжтой хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх ашиг алдагдлыг орлогын тайлан болон эзэмшигчийн өмчийн хэсэгт тус тус тусгана.

Арилжааны бус санхүүгийн өр, зээл болон авлагууд, гэрээний хугацаа дуусах хүртэл эзэмших хөрөнгүүдийг хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэдэг. Хорогдуулсан өртөгийг бодит хүүгийн аргаар тооцон хорогдуулна. Урамшуулал ба хөнгөлөлт, ажил гүйлгээний өртгийг тухайн хэрэгслийн дансны үнэд оруулах ба бодит хүүгийн хувь хэмжээнд үндэслэн хорогдуулдаг.

#### **Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг бүртгэлээс хасах**

##### **(i) *Санхүүгийн хөрөнгө***

Групп тухайн санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл тухайн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг эзэмших гэрээний эрхээ бусдад шилжүүлсэн, эсвэл уг мөнгөн гүйлгээг нэг ба түүнээс дээш этгээдэд тодорхой шалгуур хангасан тохиолдолд төлөх үүрэг хүлээх болсон, эсвэл хөрөнгийг эзэмшихтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг бусдад бодитойгоор шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасна.

Группын хувьд өмнө нь бүртгэлдээ тусгасан байсан санхүүгийн хөрөнгийг бусдад шилжүүлэх боловч тэдгээр санхүүгийн хөрөнгийн бараг бүх өгөөж болон эрсдэлийг хадгалсан хэвээр үлдэх хэлцэл хийх тохиолдол байдаг. Харин санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой өгөөж болон эрсдлийг шилжүүлээгүй ч бас өөртөө хадгалж үлдээхгүйгээр тохирсон хэлцлийн хувьд тухайн хөрөнгийг хяналт тавьж чадахгүй тухайлбал тухайн шилжүүлсэн хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдаж чадахгүй болсон бол шилжүүлсэн хөрөнгийг бүртгэлээс хасдаг. Харин хөрөнгөнд хяналт тавих эрхийг хадгалж үлдсэн бол Групп уг хөрөнгийг өөрийн оролцооны хэр хэмжээгээр өөрөөр хэлбэл шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөнд хэдий хэмжээгээр өртсөн хэвээр байгаа хувь хэмжээгээр нь бүртгэлдээ хэвээр үлдэнэ.

Дээрх бүртгэлээс хасах шалгуурыг заавал тухайн хөрөнгийн хувьд бүхэлд нь эсвэл бүлэг ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгийн хувьд хэрэглэнэ гэхээсээ илүү хэрвээ тохиромжтой бол хөрөнгийн зарим хэсгийг хэсэгчлэн шилжүүлэх үед ч баримтална. Хөрөнгийн хэсгийг шилжүүлэхэд тэрхүү хэсэг нь тусгайлан тогтоосон мөнгөн урсгал, тухайн хөрөнгийн тодорхой хувь хэсэг эсвэл тусгайлан тогтоосон мөнгөн урсгалын тодорхой хувь хэсэг байх ёстой.

### 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг бүртгэлээс хасах (үргэлжлэл)

##### (ii) *Санхүүгийн өр төлбөр*

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд бүртгэлээс хасна. Хэрэв одоогийн санхүүгийн өрийг хуучин зээлдүүлэгчээсээ өөр санхүүгийн өрийн хэрэгслээр солих тохиолдолд шинэ санхүүгийн өрийг хуучнаас нь өөр нөхцлөөр эсвэл одоогийн нөхцлийг нэлээд өөрчилсөн бол хуучин өрийг бүртгэлээс хасч шинэ өрийг бүртгэлд тусгах ба хоёр өрийн бүртгэлийн үнийн зөрүүг иж бүрэн орлогын тайланд тусгана.

##### Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс нь касс дахь бэлэн мөнгө болон анхны гэрээний хугацаа нь гурван сараас богино бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд бага өртдөг ба богино хугацааны үүргүүдийг төлж барагдуулахад ашигладаг, хязгаарлагдаагүй, банк болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэж байна.

##### Үндсэн хөрөнгө

##### (i) *Хүлээн зөвшөөрөлт, дараах үеийн үнэлгээ*

Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдаж авсан үнэ, импортын татвар, нөхөн олгохгүй худалдан авалтын бусад татварууд болон хөрөнгийг байршуулах газар болон зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой гарах зардлаас бүрддэг. Анх бүртгэлд тусгаснаас хойш бодит үнэ цэнийг нь найдвартай тодорхойлох боломжтой хөрөнгүүдийг дахин үнэлгээний дүнгээр буюу дахин үнэлгээ хийсэн өдрийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг ашиглалтанд оруулснаас хойш гарсан зардлуудыг тухайлбал засвар үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан жилийн үр дүнгийн тайланд тусгадаг. Харин тухайн зардал гарснаар хөрөнгийг анх авах үеийн тооцоолсон бүтээмж нэмэгдэж, хөрөнгөөс олох эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлсэн гэдэг нь тодорхой батлагдаж байвал гарсан зардлыг хөрөнгийн өртөг дээр нэмж капиталжуулна.

Групп нь дахин үнэлгээнд хамрагдсан үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг зөрүүтэй болгохгүйн тулд үндсэн хөрөнгөө дахин үнэлдэг. Дахин үнэлгээний нэмэгдлийг дахин үнэлгээний нөөц дансанд тусгана. Харин дахин үнэлгээний бууралтыг тухайн хөрөнгийн хувьд үүссэн өмнөх жилийн нэмэгдлийн дүнг тэг болтол дахин үнэлгээний нөөц дансыг бууруулна. Бусад бүх тохиолдолд дансны үнийн бууралтыг иж бүрэн орлогын тайланд тусгана.

##### (ii) *Элэгдэл*

Үндсэн хөрөнгийг шулуун шугамын аргаар тэдгээрийн тооцоолсон ашиглагдах жилээр элэгдүүлж иж бүрэн санхүүгийн тайланд тусгадаг ба тооцоолсон ашиглагдах жилүүд дараах байдалтай байна:

- |   |         |
|---|---------|
| ● Барилга                                       | 40 жил  |
| ● Конторын тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл | 10 жил  |
| ● Компьютер                                     | 3-5 жил |

Элэгдэл тооцох арга, ашиглалтын жил болон үлдэх өртгийг тайлант жил бүр хянаж үздэг бөгөөд шаардлагатай үед залруулдаг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.



### 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### **Дуусаагүй барилга**

Дуусаагүй барилга гэж шинээр барьж эхэлсэн боловч ашиглалтанд ороогүй байгаа барилгын өртөг юм. Барилгын барьж буй хугацаанд дуусаагүй барилгад элэгдэл тооцоогүй болно.

#### **Биет бус хөрөнгө**

##### **(i) Худалдан авсан биет бус хөрөнгө**

Группын худалдан авсан биет бус хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон бусад үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнасан.

##### **(ii) Хорогдуулалт**

Ашиглагдах хугацаа тодорхой биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар тэдгээрийн тооцоолсон ашиглагдах жилээр хорогдуулж иж бүрэн орлогын тайланд тусгадаг. Тооцоолсон ашиглагдах жил дараах байдалтай байна:

- Программ хангамж, лиценз 3 жил

Хорогдуулалтын хугацаа болон хорогдуулалтын аргыг санхүүгийн жил бүр хянаж үздэг бөгөөд шаардлагатай үед залруулдаг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.

#### **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

Түрээсийн орлого болон капиталын үнийн өсөлтөөс ашиг хүртэх зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж үзнэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Ажил гүйлгээтэй холбоотой гарсан зардал нь анхны өртөгт багтана. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг дараа үед бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь эзэмшигчийн өөрийн ашиглах үндсэн хөрөнгө рүү эсвэл бараа материал руу шилжихэд бодит үнэ цэнээр тооцогдох өртөг нь тухайн хөрөнгийн ашиглалтын өөрчлөлт гарсан өдрөөрх бодит үнэ цэнэ байна.

Хэрвээ эзэмшигчийн өөрийн ашиглаж буй үндсэн хөрөнгө нь бодит үнэ цэнээр бүртгэгдэх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө рүү шилжих тохиолдолд групп тухайн хөрөнгийг ашиглалтын өөрчлөлт гарсан өдрөөрх бодит үнэ цэнээр дахин үнэлгээ хийж хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө рүү ангилна.

### 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### Үнэ цэнийн бууралт

Группын активын дансдад үнэ цэнийн бууралт үүссэн шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд тайлант хугацааны эцэст активын дансдын бүртгэлийн дүнг үнэлж, хянадаг. Хэрвээ үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл тухайн активын нөхөн төлөгдөх үнэ цэнийг тооцоолдог.

#### (i) **Зээл ба урьдчилгаа**

Зээл ба урьдчилгааг зээлийн болзошгүй алдагдлын санг хассан дүнгээр тайлагнадаг. Болзошгүй алдагдлын санг зээл ба урьдчилгааны үлдэгдэлд хийдэг байнгын хяналт шалгалтын үр дүнд үнэ цэнэ буурсан буюу муудсан гэж тогтоосон зээл ба урьдчилгааны дансны үнийг Сангийн Яам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Активыг ангилах, активын эрсдлийн санг байгуулах зарцуулах журам”-ын дагуу тодорхойлсон эргэн төлөгдөх дүн хүртэл нь бууруулан байгуулдаг. Болзошгүй алдагдлын санг нэмэгдүүлэх бичилтийг иж бүрэн орлогын тайланд тусгадаг. Зээл төлөгдөхгүй нь тодорхой болж, бүх шүүх, эрх зүйн арга хэмжээнүүдийг гүйцэтгэж, эцсийн алдагдлын хэмжээг ТОГТООСОН тохиолдолд зээлийг данснаас хасна.

Монголбанкны Эрсдлийн сан байгуулах журмын дагуу Групп нь активын хугацааны ба чанарын үзүүлэлтүүд дээр үндэслэн хүчин зүйлсийг тооцон ангилж, эрсдлийн санг байгуулдаг. Энэхүү аргачлалын дагуу зээлийг ангилах ба хэвийн зээлд 0%, хугацаа хэтэрсэн зээлд 5%, хэвийн бус зээлд 25%, эргэлзээтэй зээлд 50%, муу зээлд 100%-иар тус тус эрсдлийн санг байгуулдаг.

Зээлийг чанарын үзүүлэлтүүдээр ангилахад зээлийн баримтын бүрдүүлэлт, зээлдэгчийн санхүүгийн үзүүлэлтүүд, барьцаа хөрөнгийн үнэлгээ болон зээлийн эргэн төлөлтийн хуваарийг өөрчилсөн эсэх зэргийг харгалзан үздэг.

Хэрвээ хожим нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг бууруулах үйл явдал гарвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаах байдлаар иж бүрэн орлогын тайланд тусгана.

#### (ii) **Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө**

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрсөн ба үнэ цэнийн бууралтыг нотлох баримт байгаа тохиолдолд бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан алдагдлыг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөөгүй байсан ч өөрийн хөрөнгөөс ашиг, алдагдал руу дахин ангилалын залруулгаар ангилна. Ашиг, алдагдал дээр бүртгэгдсэн борлуулах боломжтой гэж ангилагдсан өмчийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар дамжуулан буцаахгүй. Хэрэв дараа тайлант хугацаанд борлуулах боломжтой гэж ангилагдсан өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өсөх бөгөөд уг өсөлт нь үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөний дараах үед гарсан тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах ба буцаалтын дүнг ашиг, алдагдалд бүртгэнэ.

### **3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

#### **Үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

##### ***(iii) Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө***

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг дансны үнэ ба хөрөнгийн анхны үр ашигт хүүний хувиар бууруулсан ирээдүйд тооцогдох мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр тооцох бөгөөд ашиг, алдагдал руу хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралттай хөрөнгийн хүү нь хөнгөлөлтийн буцаалтаар дамжуулан хүлээн зөвшөөрөгдсөөр байна. Дараа үед үнэ цэнийн бууралтын гарзын хэмжээ буурах үед үнэ цэнийн бууралтын гарзын бууралтыг ашиг, алдагдлаар буцаана.

##### ***(iv) Санхүүгийн хэрэгслүүдээс бусад актив***

Групп тухайн хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант хугацааны эцэст үнэлж тодорхойлдог. Хэрэв үнэ цэнийн бууралтын шинэ тэмдэг илэрвэл эсвэл тухайн хөрөнгийн хувьд жил бүр үнэ цэнийн бууралтыг үнэлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн хөрөнгийн ирээдүйд нөхөн төлөгдөх дүнг тооцоолдог. Нөхөн төлөгдөх дүн нь тухайн хөрөнгийн буюу мөнгө үүсгэгч нэгжийн бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүн ба ашиглагдах үеийн үнэ цэнийн аль ихээр тодорхойлогдоно. Ашиглагдах үеийн үнэ цэнийг тодорхойлохдоо тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын дүнг татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтласан өнөөгийн үнэ цэнээр тогтооно. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн хөрөнгөтэй холбоотой үүсэх эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Бусад хөрөнгүүдээс хамааралгүйгээр бие даасан мөнгөн урсгалыг бий болгодоггүй хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн харъяалагдах мөнгө үүсгэгч нэгжийн хувьд нөхөн төлөгдөх дүнг тодорхойлно. Мөнгө үүсгэгч нэгж буюу хөрөнгийн дансны үнэ нь нөхөн төлөгдөх дүнгээс их байвал үнэ цэнийн бууралтын алдагдал үүсгэнэ. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг иж бүрэн орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Нөхөн төлөгдөх дүнг тооцоход ашигласан үнэлгээ, тооцоололд өөрчлөлт гарсан тохиолдолд үнэ цэнийн алдагдлыг буцаадаг. Ингэхдээ хөрөнгийн байх байсан дансны үнэ буюу өмнөх үнэ цэнийн бууралтыг оруулахгүйгээр тооцвол байх байсан хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлэхгүй байхаар тооцоолж буцаана. Үнэ цэнийн алдагдлын буцаалтын бичилтийг иж бүрэн орлогын тайланд тусгадаг.

#### **Буцаан худалдан авалтын гэрээнүүд**

Групп нь хоорондоо ижил төстэй хөрөнгө оруулалтыг ирээдүйд тогтмол үнээр, тогтоосон хугацаанд дахин худалдах (худалдан авах) зорилгоор хөрөнгө оруулалтыг худалдан авах (борлуулах) гэрээ хийдэг. Ирээдүйд буцаан худалдах үүрэгтэй тул худалдан авсан хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд тусгахгүй. Харин тэдгээрийг худалдан авахад төлсөн дүнгээр банк болон харилцагчдад олгосон зээл гэж бүртгэдэг. Зээлийн авлагыг худалдан авсан үнэт цаасаар баталгаажсан гэж үзнэ. Репо гэрээний дагуу худалдсан хөрөнгө оруулалтыг балансас хасахгүй ба арилжааны эсвэл арилжаалах боломжтой хөрөнгийн аль тохирохоор бүртгэж, тайлагнана. Хөрөнгө оруулалтыг худалдсанаар хүлээн авсан мөнгийг бусад банк эсвэл харилцагчдад төлөх өр гэж бүртгэнэ. Хөрөнгө оруулалтыг худалдах, буцаан худалдан авсанаас үүсэх зөрүүг хүүгийн орлого эсвэл зардал гэж бүртгэх ба гэрээний хугацааны туршид бодит хүүгийн аргаар хуримтлуулан бүртгэдэг.

### **3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

#### **Хувьцаат капитал**

##### **(i) Энгийн хувьцаа**

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилна. Энгийн хувьцаа, энгийн хувьцааны опцион гаргахтай шууд холбоотой гарсан зардлуудыг татварыг нь суутгасан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг.

##### **(ii) Халаасны хувьцаа**

Өөрийн хөрөнгөөр бүртгэсэн энгийн хувьцааг эргүүлэн худалдан авахдаа төлсөн, ийнхүү худалдан авахтай холбоотой гарсан бүх зардлуудыг, татварыг нь хассан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг. Эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасны хувьцаагаар ангилах ба нийт өөрийн хөрөнгийн бууралт байдлаар харуулдаг. Харин халаасны хувьцааг дахин гаргасан, худалдсан бол хүлээн авсан мөнгөн дүнгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ба тухайн гүйлгээнээс бий болсон илүү ба дутуугийн зөрүүг хуримтлагдсан ашгаас нөхөх эсвэл ашгийг нэмэгдүүлэх байдлаар залруулдаг.

##### **(iii) Цөөнхийн хувь оролцоо**

Толгой компаний эзэмшилд шууд болон шууд бусаар үл ноогдох охин компани дах өмчийг төлөөлж буй цөөнхийн хувь оролцоо нь СТОУС 3 'Бизнесийн нэгдэл' стандартын дагуу тооцсон анхны нэгтгэлийн өдрөөрх цөөнхийн хувь оролцоо болон нэгтгэлийн өдрөөс хойших өмчийн өөрчлөлт дэх цөөнхийн хувь оролцооны эзлэх хувь хэмжээнээс бүрдэнэ.

#### **Нөөцийн сан**

Групп нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл засаж сайжруулахаар үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бол нөөцийн санг балансад тусгадаг. Мөнгөний цаг хугацааны нөлөөлөл өндөр бол ирээдүйн мөнгөн зарлагын дүнг татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан сангийн дүнг тодорхойлно. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн өр төлбөртэй холбоотой эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой.

#### **Сегментийн тайлагнал**

Үйл ажиллагааны сегмент нь бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй хийсэн ажил гүйлгээ болон бизнесийн үйл ажиллагаа эрхлэсэнээс орлого олж, зарлага гаргадаг Группын нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Бүх сегментүүдийн үйл ажиллагааны үр дүнг Компанийн гүйцэтгэх үйл ажиллагааны шийдвэр гаргагч ("ГҮАШГ") тогмол хянаж, сегментэд хуваарилагдах нөөцийг тодорхойлох, гүйцэтгэлийг болон санхүүгийн мэдээллийг салган харах боломж зэргийг үнэлдэг.



### **3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

#### **Орлого**

##### **(i) Хүүгийн орлого**

Хүүгийн орлого ба зардлыг аккруэль сууриар иж бүрэн орлогын тайланд тусгадаг ба хөрөнгийн бодит үр өгөөжийг харгалздаг. Хүүгийн орлого ба зардал нь хөнгөлөлт, урамшууллын хорогдол буюу хүүтэй зээлийн хэрэгслийн дансны үнэ ба бодит хүүгийн аргаар хорогдуулсаар төлөгдөх хугацааны эцэст гарах дүн хоорондын зөрүүгээс бүрдэнэ. Гэхдээ Групп нь зээл анх олгох өртөг зардал болон үйлчилгээний шимтгэлийг бодит хүүгийн аргаар хорогдуулахгүй, шууд тайлант жилийн үйл ажиллагааны орлого, зардлаар бүртгэдэг.

##### **(ii) Хураамж, шимтгэлийн орлого**

Хураамж, шимтгэлийн орлого нь харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр авч байгаа төлбөр юм. Хураамж, шимтгэлийн орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсэн үед орлогоор бүртгэнэ.

##### **(iii) Түрээсийн орлого**

Түрээсийн орлогыг түрээсийн гэрээний хугацааны туршид нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд шулуун шугамын аргаар бүртгэдэг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн орлогын бүрдэл хэсэг гэж үздэг.

#### **Үйл ажиллагааны түрээсийн төлбөр**

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн гэрээний хугацааны туршид нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд шулуун шугамын аргаар бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг нийт түрээсийн зардлын бүрдэл хэсэг гэж үзэх ба түрээсийн гэрээний хугацааны туршид хорогдуулан бүртгэнэ.

#### **Орлогын албан татвар**

Орлогын албан татвар нь зөвхөн тайлант жилд ноогдуулсан орлогын албан татвараас бүрдэнэ.

Тайлант жилийн татвар гэдэг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод балансын өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын хүлээгдэж буй өр эсвэл авлага болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

2010 оны 5 дугаар сард Сангийн яамнаас хойшлогдсон татварын зөрүүг зохицуулах тухай журам гарсан. Гэвч Монгол Улсын татварын алба уг журмыг хэрэгжүүлж эхлээгүй, Татварын хууль тогтоомжид оруулж, тусгаагүй ба энэ нь аж ахуйн нэгжүүд, арилжааны банкууд, болон татварын байгууллагууд хойшлогдсон татварын талаарх мэдлэг бага байгаатай холбоотой. Энэ журмыг хэрэглэж эхлэхийн тулд журам, аргачлал гаргах, татварын зөвлөхүүдтэй ярилцлага хийх, сургалт зохион байгуулах шаардлагатай байна. Монголбанк нь хойшлогдсон татварын өр, хөрөнгийг тооцоолох журам аргачлал боловсруулахаар төлөвлөж байгаа ба арилжааны банкуудын хойшлогдсон татварын хөрөнгө, өрийн бүртгэл СТОУС-д нийцэхгүй байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа болно.

#### **Ажилчдын тэтгэмж**

Групп нь улсын нийгмийн даатгалын системд ажил олгогчоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс өөр тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийг олгодоггүй. Группээс төлөх ажил олгогчийн шимтгэлийг төлөхөөр хуримтлуулсан жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

### 3 **Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

#### **Ногдол ашиг**

Ногдол ашгийг зарласан тайлант хугацааны санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэдэг.

#### **Мөрдөж эхлээгүй байгаа шинээр гарсан стандартууд ба тэдгээрийн тайлбарууд**

Доорх стандартын нэмэлт өөрчлөлт гарсан бөгөөд Групп нь эдгээр стандартыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх ёстой бөгөөд одоогоор урьдчилж мөрдөж эхлээгүй байна.

#### **(i) *НББОУС 32-н өөрчлөлт, 'Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга'***

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 'санхүүгийн хөрөнгө ба санхүүгйн өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах' шалгуурыг тодруулна. Энэ өөрчлөлтийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эсвэл түүнээс хойших хугацаанд үйлчлэх бөгөөд энэ хугацаанаас эрт мөрдөж болно. Энэхүү стандартын нэмэлт өөрчлөлт нь Группын санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж тооцож байна.

#### 4 Охин компанийн худалдан авалт

##### Бизнесийн нэгдэл

Ти Ди Би Медиа ХХК нь 2011 оноос Улаанбаатар хот дахь Bloomberg TV Mongolia телевизийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос авсан хэвлэл мэдээллийн компани юм. Групп нь 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр нэмэлт хувьцаа болон саналын эрх бүхий хувь оролцоог худалдан авах замаар Ти Ди Би Медиа ХХК-ийн хяналтын эрхийг авсан. Үүний үр дүнд, Ти Ди Би Медиа дахь Группын өөрийн хөрөнгө нь 49 хувиас ойролцоогоор 84.4 хувь болж өссөн байна.

Групп 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Ти Ди Би Медиа ХХК-ийн хяналтын эрхийг авсан боловч, худалдан авалтын өдөр болон тайлант хугацааны эцсийн өдрийн хооронд чухал ажил гүйлгээ байгаагүй учраас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг худалдан авалтын өдөр гэж үзсэн. Үүний үр дүнд, 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх болон тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Ти Ди Би Медиа ХХК-ийн нийт дэлгэрэнгүй орлого багтаагүй байна.

Шилжүүлсэн төлбөрийн гол ангилалууд болон худалдан авалтын өдрөөрх хүлээн зөвшөөрсөн худалдан авсан хөрөнгийн болон өр төлбөрийн дүн дараах байдалтай байна.

	<b>2013</b>
	<b>Мян.төг</b>
Мөнгө	5,240,000
Барилга	6,060,000
Нийт шилжүүлсэн төлбөр	<u>11,300,000</u>

Барилгын бодит үнэ цэнэ нь зах зээлийн хандлагад тулгуурласан.

##### Худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр

Худалдан авалтын өдрөөрх хүлээн зөвшөөрсөн худалдан авсан хөрөнгийн болон өр төлбөрийн дүн дараах байдалтай байна.

	<b>2013</b>
	<b>Мян.төг</b>
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс	448,786
Үндсэн хөрөнгө	8,567,435
Биет бус хөрөнгө	389,670
Бусад хөрөнгө	987,741
Бусад өр төлбөр	(321,068)
Нийт тодорхойлогдох цэвэр хөрөнгө	<u>10,072,564</u>

##### Гүүдвил

Худалдан авалтаас үүсэх гүүдвیلیйг дараах байдлаар хүлээн зөвшөөрсөн:

	<b>2013</b>
	<b>Мян.төг</b>
Шилжүүлсэн төлбөр	11,300,000
Цөөнхийн хувь оролцоо (Ти Ди Би Медиа ХХК-ийн хүлээн зөвшөөрсөн хөрөнгө болон өр төлбөрийн тодорхой хувь хэсэгт тулгуурласан )	1,575,769
Ти Ди Би Медиа ХХК-ийн өмнөх хувь оролцооны бодит үнэ цэнэ	-
Тодорхойлогдох цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэ	<u>10,072,564</u>
Гүүдвил	<u>2,803,205</u>

**4 Охин компанийн худалдан авалт (үргэлжлэл)****Гүүдвил (үргэлжлэл)**

Гүүдвил нь Монголын Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос нэвтрүүлэх тусгай зөвшөөрөлтэй хамааралтай. Хүлээн зөвшөөрсөн гүүдвил нь татвараас хасагдах тооцоололд орохгүй болно.

**Цөөнхийн хувь оролцоо**

Дараах хүснэгтэнд Ти Ди Би Медиа ХХК-ийн цөөнхийн хувь оролцоотой холбоотой мэдээллийг нэгтгэн харуулав.

**2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр****(Мянган төгрөгөөр)**

	<b>Ти Ди Би Медиа ХХК</b>
Цөөнхийн хувь оролцооны хувь	<u>15.64417%</u>
Мөнгө түүнтэй адилтгах зүйлс	448,786
Үндсэн хөрөнгө	8,567,435
Бусад хөрөнгө	1,377,411
Өр төлбөр	<u>(321,068)</u>
<b>Цэвэр хөрөнгө</b>	<u>10,072,564</u>
Дансны үнэ	<u>1,575,769</u>



**5 Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Касс дах бэлэн мөнгө	64,232,328	55,558,591
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	336,990,113	138,718,842
Монголбанк дахь харилцах (*)	689,022,571	250,535,821
	<b>1,090,245,012</b>	<b>444,813,254</b>

(\*) 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкны шаардлагын дагуу харилцагчаас татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн хоёр долоо хоногийн дундаж үлдэгдлийн 12 хувь (2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 12 хувь байсан)-иас багагүй нөөцийг Монголбанкинд байршуулах ёстой. Өдрийн дундаж үлдэгдлийн хувьд Групп нь өдөр бүрийн эцэст заавал байлгах нөөцийн 50 хувиас багагүй дүнг байлгах ёстой. 2013 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар заавал байх нөөцийн дүн 355,888,347 мянган төгрөг болон 255,054,560 мянган төгрөг байна.

**6 Хөрөнгө оруулалтын үнэт цээс**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
<b>Арилжаалах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас</b>		
Хаалттай компанийн өмчийн үнэт цаас, өртгөөр (*1)	443,430	1,527,104
Өмчийн үнэт цаас, зах зээлийн үнээр (*2)	3,980,015	47,462,745
Засгийн газрын бонд	611,714,016	-
Монголбанкны үнэт цаас	-	46,183,485
Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас (*3)	108,475,200	-
	<b>724,612,661</b>	<b>95,173,334</b>
<b>Арилжаалах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас</b>		
Засгийн газрын бонд	160,500,000	359,931,276
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (*4)	-	1,697,000
	<b>160,500,000</b>	<b>361,628,276</b>
	<b>885,112,661</b>	<b>456,801,610</b>

(\*1) Хаалттай компанид оруулсан хөрөнгө оруулалт нь хөрөнгийн биржид бүртгэлгүй компаниудад оруулсан хөрөнгө оруулалтууд бөгөөд өртгөөр нь бүртгэсэн. Тэдгээрийг нийтэд арилжаалдаггүй тул бодит үнэ цэнийг найдвартай тооцоолох боломжгүй.

(\*2) 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр энэхүү хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн 1,715,187 мянган төгрөгийн бодит бус олзыг өмчид бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнасан. Мөн Групп 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр өмчийн үнэт цаас болох MRC-ийн хувьцааг гуравдагч талд арилжаалсан. MRC-ийн хувьцааны дансны үнэ 45,197,917 мянган төгрөг байсан.

(\*3) Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас нь Монголын Ипотекийн Корпораци ХХК Актив Нэг ЭсПиСи ("МИК ЭсПиСи")-аас гаргасан Сениор болон Жүниор үнэт цаасыг илэрхийлнэ.

(\*4) Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Монголын Ипотекийн Корпораци ХХК-аас (МИК) гаргасан үнэт цаасыг илэрхийлнэ.

7 **Хараат болон хамтарсан компани дахь хөрөнгө оруулалт**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
МИК ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт (*1)	8,679,033	2,385,599
Эм Жи Лизинг ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт (*2)	1,736,968	-
	<b>10,416,001</b>	<b>2,385,599</b>

(\*1) Групп нь 2013 оны 6 дугаар сард 6,011,157 мянган төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт хийсэн. Энэ хөрөнгө оруулалтыг хийснээр 2013 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр Группын МИК дахь өмчлөлийн хувь нь өсч ойролцоогоор 35.57% болсон. МИК 2013 оны 8 дугаар сард нэмж төлөгдсөн капиталыг өсгөсөнөөр Группын МИК дахь өмчлөлийн хувь нь буурч ойролцоогоор 35.45% болсон. Үүний үр дүнд Групп МИК дахь хөрөнгө оруулалт худалдсаны олз 41,579 мянган төгрөгийг тайлагнасан. Групп өмчийн аргыг хэрэглэхдээ МИК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн мэдээллийг ашигласан. 2012 болон 2013 онуудад МИК-ийн хувьцааны ашгаар 109,644 мянган төгрөг болон 240,698 мянган төгрөгийг тус тус бүртгэсэн.

(\*2) Групп нь 2013 онд Эм Жи Эл Корпорацтай хамтран байгуулсан Эм Жи Лизинг ХХК (ЭмЖиЭлЭл)-ний өмчийн 55%-д 1,773,610 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Групп Эм Жи Эл Эл-ийн өмчийн 55%-ийг эзэмшдэг боловч аливаа шийдвэрийг гаргахад талуудын хувь оролцоо тэнцүү учраас Групп Эм Жи Эл Эл-ийг охин компани бус хамтарсан компани гэж үздэг. Групп өмчийн аргыг хэрэглэхдээ Эм Жи Эл Эл-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн мэдээллийг ашигласан. 2013 онд Эм Жи Эл Эл-ийн хувьцааны алдагдлаар 36,642 мянган төгрөгийг бүртгэсэн.

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хараат компаниудын хураангуй санхүүгийн үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

	<b>2013</b>		<b>2012</b>	
	<b>Мян.төг</b>		<b>Мян.төг</b>	
Санхүүжигч	Хөрөнгө	Өр төлбөр	Хөрөнгө	Өр төлбөр
МИК	33,579,334	9,482,964	18,344,787	10,809,499
Эм Жи Эл Эл	3,427,503	269,379	-	-

	<b>2013</b>		<b>2012</b>	
	<b>Мян.төг</b>		<b>Мян.төг</b>	
Санхүүжигч	Үйл ажиллагааны орлого	Цэвэр ашиг	Үйл ажиллагааны орлого	Цэвэр ашиг
МИК	2,594,106	738,552	2,362,788	427,121
Эм Жи Эл Эл	288,903	(66,621)	-	-

**8 Зээл ба урьдчилгаа**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	2,525,080,548	1,530,158,608
Гүйцэтгэх удирдлага, захирлууд болон ажилчдад олгосон зээл	23,518,635	16,605,055
	2,548,599,183	1,546,763,663
Зээлийн болзошгүй эрсдлийн сан	(18,042,005)	(13,491,840)
	<u>2,530,557,178</u>	<u>1,533,271,823</u>

2012 болон 2013 оны тайлант жилийн зээлийн болзошгүй эрсдлийн сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	13,491,840	17,919,809
Эрсдлийн зардлаар нэмж байгуулсан болон нөхөлтөөр буурсан	4,640,541	(4,305,104)
Эрсдлийн сангаас хаасан зээл	(90,376)	(122,865)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>18,042,005</u>	<u>13,491,840</u>

**Ипотекийн зээлийн багц шилжүүлэх тухай**

Групп 2008 онд 404,864,410 төгрөг буюу ам долларт хөрвүүлбэл 294,334 ам долларын дансны үнэ бүхий ипотекийн зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпораци ХХК (цаашид МИК гэх)-д бэлэн мөнгөөр солилцож шилжүүлсэн. Мөн 2009 онд нийт 4,700,819,887 төгрөгийн дансны үнэ бүхий ипотекийн зээлийн багцыг МИК-ээс гаргасан бондоор солилцож шилжүүлсэн.

Буцаан солих нөхцөлтэйгээр шилжүүлсэн зээлүүд нь тэдгээрээс үүсэх эрсдэл ба өгөөжийг МИК-д бүрэн шилжүүлээгүй тул бүртгэлээс хасах шалгуурыг хангаагүй. Буцаан солих нөхцөл нь холбогдох зээлийн худалдан авалтын гэрээнд зааснаар Групп өмнө шилжүүлсэн ипотекийн зээлийг хэвийн зээлээр солих юм. Иймээс эдгээр гүйлгээг барьцаатай зээллэг гэж бүртгэсэн.

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өглөгийн дансны үнэ болон бодит үнэ цэнэ дараах байдалтай байна:

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
<b>Дансны үнэ</b>		
Шилжүүлсэн хөрөнгө	-	1,531,618
Холбогдох өглөг	-	(1,531,618)
<b>Бодит үнэ цэнэ</b>		
Шилжүүлсэн хөрөнгө	-	1,693,222
Холбогдох өглөг	-	(1,693,222)
Цэвэр дүн	<u>-</u>	<u>-</u>

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд бүх ипотекийн зээлийг буцаан худалдан авсан.

Групп 107,993,483 мянган төгрөгийн дансны үнэ бүхий ипотекийн зээлийн багцыг МИК ЭсПиСи-д шилжүүлсэн ба энэ ажил гүйлгээ нь бүртгэлээс хасах шалгуурыг хангасан.

**9 Хоёрдогч зээл**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Улаанбаатар хотын банк	4,000,000	4,000,000
Капитрон банк	3,000,000	3,000,000
	<u>7,000,000</u>	<u>7,000,000</u>

Улаанбаатар хотын банкинд олгосон зээл нь жилийн 8 хувийн тогтмол хүүтэй, 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр бүрэн төлж дуусгах нөхцөлтэй ба Капитрон банкинд олгосон зээл нь жилийн 12 хувийн тогтмол хүүтэй, 2014 оны 8 дугаар сарын 14-ний өдөр бүрэн төлөх нөхцөлтэй байна.

**10 Үндсэн хөрөнгө**

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

**2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр**  
**(Мянган төгрөгөөр)**

	Барилга	Машин, тоног төхөөрөмж	Компьютер, дагалдах хэрэгсэл	Дуусаагүй барилга	Нийт
<b>Өртөг/дахин үнэлгээ</b>					
Өртөгөөр	31,801,511	5,378,533	8,692,670	74,660,287	120,533,001
Дахин үнэлгээгээр	18,555,196	-	-	-	18,555,196
2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	<u>50,356,707</u>	<u>5,378,533</u>	<u>8,692,670</u>	<u>74,660,287</u>	<u>139,088,197</u>
Нэмэгдсэн	6,060,000	1,285,939	3,221,711	38,580,464	49,148,114
Хасагдсан	-	(145,661)	-	-	(145,661)
Данснаас хассан	-	(91,934)	(413,294)	-	(505,228)
Шилжүүлсэн	(26,096,391)	-	-	(966,164)	(27,062,555)
Худалдан авсан салбар	-	2,492,130	15,305	-	2,507,435
2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	<u>30,320,316</u>	<u>8,919,007</u>	<u>11,516,392</u>	<u>112,274,587</u>	<u>163,030,302</u>
Үүнээс:					
Өртөг	11,765,120	8,919,007	11,516,392	112,274,587	144,475,106
Дахин үнэлгээ	18,555,196	-	-	-	18,555,196
	<u>30,320,316</u>	<u>8,919,007</u>	<u>11,516,392</u>	<u>112,274,587</u>	<u>163,030,302</u>



**Хуримтлагдсан элэгдэл**

2013 оны 01 дүгээр сарын

01-ний өдрөөр	974,265	2,195,995	4,326,938	-	7,497,198
Нэмэгдсэн	1,515,863	552,102	1,611,205	-	3,679,170
Хасагдсан	-	(111,232)	-	-	(111,232)
Данснаас хассан	-	(78,277)	(408,178)	-	(486,455)
Шилжүүлсэн	(845,705)	-	-	-	(845,705)

2013 оны 12 дугаар сарын

31-ний өдрөөр	1,644,423	2,558,588	5,529,965	-	9,732,976
---------------	-----------	-----------	-----------	---	-----------

**Үлдэгдэл өртөг**

2013 оны 12 дугаар сарын

31-ний өдрөөр	28,675,893	6,360,419	5,986,427	112,274,587	153,297,326
---------------	------------	-----------	-----------	-------------	-------------

10 **Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)****2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр  
(Мянган төгрөгөөр)**

	Барилга	Машин, тоног төхөөрөмж	Компьютер, дагалдах хэрэгсэл	Дуусаагүй барилга	Нийт
<b>Өртөг/дахин үнэлгээ</b>					
Өртөгөөр	5,157,931	4,858,084	5,507,828	52,329,613	67,853,456
Дахин үнэлгээгээр	18,555,196	-	146,870	-	18,702,066
2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	23,713,127	4,858,084	5,654,698	52,329,613	86,555,522
Нэмэгдсэн	28,395,617	1,039,864	3,357,649	22,550,692	55,343,822
Хасагдсан	-	(326,572)	(330)	(220,018)	(546,920)
Данснаас хассан	(1,752,037)	(192,843)	(319,347)	-	(2,264,227)
2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	50,356,707	5,378,533	8,692,670	74,660,287	139,088,197
Үүнээс:					
Өртөг	31,801,511	5,378,533	8,692,670	74,660,287	120,533,001
Дахин үнэлгээ	18,555,196	-	-	-	18,555,196
	50,356,707	5,378,533	8,692,670	74,660,287	139,088,197
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	1,752,037	2,027,008	3,631,485	-	7,410,530
Нэмэгдсэн	974,265	466,489	1,001,035	-	2,441,789
Хасагдсан	-	(119,463)	(147)	-	(119,610)
Данснаас хассан	(1,752,037)	(178,039)	(305,435)	-	(2,235,511)
2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	974,265	2,195,995	4,326,938	-	7,497,198
<b>Үлдэгдэл өртөг</b>					
2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	49,382,442	3,182,538	4,365,732	74,660,287	131,590,999

Данснаас хассан хөрөнгийн 146,870 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 2012 оны хуримтлагдсан ашигт хаасан.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь Улаанбаатар хотод баригдаж буй Группын оффисын барилгын өртгийг илэрхийлнэ. Группын оффисын барилгын ажил нь 2011 оны 2 дугаар улиралд эхэлсэн бөгөөд 2014 оны 4 дүгээр улиралд дуусахаар хүлээгдэж байна. 2012 болон 2013 онд үндсэн хөрөнгө худалдан авах зориулалтаар авсан зээлийн хүүг капиталжуулж бүртгээгүй болно.

**10 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)**

Хараат бус, мэргэжлийн үнэлгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн барилгын хамгийн сүүлийн үеийн үнэлгээний дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

<u>Үнэлгээний огноо</u>	<u>Хөрөнгийн нэр</u>	<u>Үнэлгээний дүн</u>	<u>Үнэлгээний арга</u>
31 October 2008	Барилга	17,076,514	Зах зээлийн үнэ
31 December 2011	Барилга	21,961,090	Зах зээлийн үнэ

Хэрэв үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдлийг хассан түүхэн өртгөөр нь бүртгэсэн гэж үзвэл дахин үнэлсэн хөрөнгийн дансны үнэ нь 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдалтай байна. Үүнд:

	<u>2013</u> <u>Мян.төг</u>	<u>2012</u> <u>Мян.төг</u>
Барилга	13,133,580	33,456,513

**11 Биет бус хөрөнгө болон гүүдвил**

	<u>2013</u> <u>Мян.төг</u>	<u>2012</u> <u>Мян.төг</u>
<b>Өртөг</b>		
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	3,271,779	2,781,462
Нэмэгдсэн		
Программ хангамж	964,803	490,317
Гүүдвил	2,803,205	-
Данснаас хассан	(153,069)	-
Салбар худалдан авсан	389,669	-
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	7,276,387	3,271,779
<b>Хорогдуулалт</b>		
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	2,669,948	2,348,064
Тайлант жилд байгуулсан (*)	488,894	321,884
Данснаас хассан	(153,070)	-
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,005,772	2,669,948
<b>Үлдэгдэл өртөг</b>		
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,270,615	601,831

(\*) Зөвхөн программ хангамжинд хорогдуулалт тооцсон.

**12 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	-	-
Үндсэн хөрөнгөөс дахин ангилсан	26,216,850	-
Зах зээлийн үнийн өөрчлөлт	7,171,395	-
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>33,388,245</u>	<u>-</u>

Групп Эн Си Пи Тауэрийн ирээдүйд ашиглах төлөвлөгөөг өөрчилсөнтэй холбоотойгоор уг хөрөнгийг үндсэн хөрөнгийн ангилалаас хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгөд дахин ангилсан.

Хараат бус, мэргэжлийн үнэлгээний байгууллагаар хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийг тодорхойлуулсан. Хараат бус үнэлгээчин нь группын хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг жил бүр тогтоодог.

33,388,245 мянган төгрөгийн үнэлгээтэй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хэмжүүр нь үнэлгээ хийхэд ашиглагдсан мэдээллээс хамаарч гурав дугаар шатлалд ангилагдсан.

Гурав дугаар шатлалаарх зах зээлийн үнэлгээний эцсийн үлдэгдлийн тооцооллыг дараах хүснэгтээр харуулав.

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Эхний үлдэгдэл	-	-
Үндсэн хөрөнгөөс дахин ангилсан	26,216,850	-
Зах зээлийн үнийн өөрчлөлт (Бодит бус)	7,171,395	-
Эцсийн үлдэгдэл	<u>33,388,245</u>	<u>-</u>

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн зах зээлийн үнийг тооцоолсон үнэлгээний арга болон тооцоолол хийхэд ашиглагдсан ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав.

<b>Үнэлгээний арга</b>	<b>Ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлт</b>	<b>Ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлт болон зах зээлийн үнийн тооцооллын хоорондын хамаарал</b>
Зах зээлийн үнийн арга	Жишиг барилгын борлуулалтын дундаж үнэ 6,394,500 төгрөг	Тооцоолсон зах зээлийн үнэ өснө (буурна) хэрэв: Жишиг барилгуудын зах зээлийн үнэ өндөр (бага);
	Дискаунтчлах хувь 16%	Дискаунтчлах хувь бага (өндөр);
Орлогын арга	Түрээсийн дундаж орлого 65,000 төгрөг	Тооцоолсон зах зээлийн үнэ өснө (буурна) хэрэв: Хэрэв түрээсийн орлогын зах зээлийн үнэ өндөр (бага);
	Капиталжуулах хувь 11.29%	Капиталжуулах хувь бага (өндөр);



**13 Өмчлөх бусад хөрөнгө**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга	9,678,810	26,500
Орон сууцны зориулалттай барилга	-	136,426
Хасах нь: Үнэлгээний хасагдуулга	(3,621,655)	(5,778)
	<b>6,057,155</b>	<b>157,148</b>

Зээл ба урьдчилгааны төлбөрт авсан хөрөнгийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэж, арилжаалах боломжтой хөрөнгийн ангилалд оруулдаг. Уг хөрөнгөд Сангийн Яам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулах зарцуулах журмын дагуу үнэ цэнийн бууралтын нөөц байгуулдаг. Энэхүү журмын дагуу Группын өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгүүдийг хугацааны үзүүлэлтүүдэд үндэслэн зээлийн хэвийн, хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу гэх ангилалуудын эрсдлийн санг тооцдог 0%, 5%, 25%, 50%, 100% - аар тус тус үнэ цэнийн бууралтын нөөц байгуулдаг. 2012 болон 2013 оны тайлант жилд барьцаанд хураагдсан хөрөнгөнөөс зарж борлуулсантай холбогдуулан 247,463 мянган төгрөг ба 473,649 мянган төгрөгийн нөөцийг тус тус буцаасан ба өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал үүсээгүй.

**14 Бусад хөрөнгө**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Үнэт металл	3,601,016	25,033,389
Хуримтлагдсан хүүгийн авлага	47,376,786	24,165,543
Урьдчилж төлсөн зардал	7,425,555	805,450
Хангамжийн материал	1,030,271	829,933
Спот арилжааны авлага	276,359,629	65,414,600
Дриватив хөрөнгө	64,719,231	283,676
Бусад авлага, цэвэр	2,293,214	7,324,361
Бусад	925,083	-
	<b>403,730,785</b>	<b>123,856,952</b>

Бусад авлага нь 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх 153,689 мянган төгрөг болон 2,830 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралтын цэвэр алдагдалтай холбоотой үүссэн.

**15 Харилцагчдын харилцах, хадгаламж**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Харилцах данс	824,435,400	599,471,005
Хугацаагүй хадгаламж	260,411,572	200,121,416
Хугацаатай хадгаламж	1,024,854,327	579,734,505
Бусад хадгаламж	29,990,850	22,999,837
	<b>2,139,692,149</b>	<b>1,402,326,763</b>

Банк харилцах данс болон зарим хадгаламжид хүү тооцдоггүй боловч тогтоосон хязгаараас дээш хэмжээнд дансныхаа үлдэгдлийг барих шаардлагыг хангасан хадгаламж эзэмшигчдийн гадаад валют болон төгрөгийн хадгаламжид дунджаар жилийн 1.35% ба 3.84% (2012 онд 1.2% ба 3.35%) хүүг тус тус тооцож, олгодог.

Гадаад валютын болон төгрөгийн хугацаагүй хадгаламжийн жилийн хүү ойролцоогоор 1.91% ба 6.65% (2012 онд 2.0% ба 6.5%) байна.

Гадаад валютын болон төгрөгийн хугацаатай хадгаламжийн жилийн хүү ойролцоогоор 5.95% ба 11.88% (2012 онд 6.7% ба 12.5%) байна.

**16 Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Харилцах данс:		
Гадаад валютын харилцах	8,099,760	13,641,083
Төгрөгийн харилцах	6,252,719	88,608
Борлуулах гадаад валютын чек	316,883	223,737
Банкны хадгаламж	157,440,337	22,565,055
	<b>172,109,699</b>	<b>36,518,483</b>

**17 Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас**

<b>Харилцагч</b>	<b>Худалдсан огноо</b>	<b>Дуусах огноо</b>	<b>Хүүгийн түвшин</b>	<b>2013 Мян.төг</b>	<b>2012 Мян.төг</b>
Кредит банк	26 Dec 2012	2 Jan 2013	15.00%	-	1,495,638
Монголбанк	31 Dec 2013	2 Jan 2014	12.50%	372,650,503	-
				<b>372,650,503</b>	<b>1,495,638</b>

Групп нь Кредит банк болон Монголбанкттай байгуулсан “Буцаан худалдах гэрээ”-ны дагуу 560,145,000 мянган төгрөг болон 1,500,000 мянган төгрөгийн Монголбанкны үнэт цаас болон Засгийн газрын бондыг өөр өөр хугацаанд буцаан худалдаж авах нөхцөлтэйгөөр худалдсан. Энэхүү үнэт цаас нь тухайн гэрээгээр үүсэх өр төлбөрийн барьцаа байна.

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл**

	2013	2012
	Мян.төг	Мян.төг
КФВ банк	8,903,933	5,396,917
Дэлхийн банк	3,153,755	4,841,873
Азийн хөгжлийн банк	1,533,152	1,518,287
ОУ-ын хөгжлийн ассоциаци	849,772	731,879
БНСУ-ын экспорт, импортын банк	17,911,647	22,154,841
ВТБ банк	-	10,440,750
БНХАУ-ын экспорт, импортын банк	15,242	694,809
Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг	17,719,975	17,044,943
Атлантик форфэйтинг компани	500,353	4,518,726
ЖДҮХС-ын төсөл (Сангийн яам)	63,813,541	71,457,399
Коммерц банк	27,142,828	1,850,613
БНХАУ-ын үйлдвэр, худалдааны банк	-	6,120,880
Ай эн жи банк	8,767,578	5,995,455
Баошанг банк	1,939,686	1,912,513
Монголын ипотекийн корпораци ("МИК")	-	1,531,618
Сумитомо Мицуй банк корпораци	41,342,373	951,390
Нидерландын хөгжлийн банк	16,541,000	13,921,000
Бэнк оф чайна (Хонг Конг)	-	550,381
Монголын хөрөнгийн бирж	1,953,003	1,643,658
Чайна трейд солушнс	188,784	78,310
Монголбанкны дэд хөтөлбөр	381,870,711	52,730,928
Монголбанк ипотекийн зээлийг санхүүжүүлэх хөтөлбөр	362,000,000	-
Стандарт чартеред банк	-	6,876,914
Эм жи лизинг корпораци	46,906	-
ОХУ-ын хөдөө аж ахуйн банк	14,886,900	-
Юникредит С.П.А	75,405	-
Групп хамтын санхүүжилтийн зээл	131,349,084	-
Каргил ТСФ Ази	54,585,300	-
	<b>1,157,090,928</b>	<b>232,964,084</b>

**КФВ банкны төслийн зээл**

Групп нь жижиг, дунд үйлдвэрийн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготойгоор ХБНГУ-ын хөгжлийн банк болох КфВ банктай зээл болон санхүүжилтийн гэрээг 2002 онд байгуулсан бөгөөд 4,345,981 евро хүртлэх эх үүсвэрийн хэмжээтэй зээлийн хүрээнд, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч буюу Монголбанкаар дамжуулан жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдад хөнгөлөлттэй нөхцөл, хүүтэйгээр уг төслийн зээлийг олгодог. КфВ банк зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2,939,770 евро, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,912,733 евро байна. Уг зээлийн эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацаа 2042 оны 6 дугаар сард дуусгавар болох ба эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 1,25% бөгөөд үүний 0.75%-ийг КфВ банк болон 0.50% -ийг Монголбанкинд тус тус төлдөг болно. Үндсэн зээлийн эргэн төлөлт хагас жил тутам байх бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)****Дэлхийн банкны зээл**

	2013	2012
	Мян.төг	Мян.төг
Зээл I	-	24,568
Зээл II	3,153,755	4,817,305
	<u>3,153,755</u>	<u>4,841,873</u>

**Зээл I**

Групп нь Сангийн ямаар дамжуулан дэлхийн банк сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй зээлийн удирдлагын системийн шинэчлэлт, хүний нөөцийн сургалт, тоног төхөөрөмж болон зөвлөх үйлчилгээний хангамж зэргийг багтаасан Групп байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжүүлэх зорилготойгоор дэлхийн банктай төслийн гэрээг 2006 онд байгуулсан. Дэлхийн банк зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 17,648 ам.доллар, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 0 ам.доллар байна. Зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 2% бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлт хагас жил тутам төлөгдөж, 2024 оны 12 дугаар сард дуусгавар болно.

**Зээл II**

Зээл II нь дараах зээлүүдээс бүрдэнэ. Үүнд:

- (a) Групп нь Сангийн ямаар дамжуулан хувийн хэвшлийг хөгжүүлэх хоёр дахь төслийн хүрээнд харилцагчдын дэд зээлийг эргэлтийн сангийн хөрөнгөөс 4,000,000 ам.доллар хүртлэх хэмжээгээр санхүүжүүлэх зорилгоор дэлхийн банктай дамжуулан зээлдэх гэрээг 2006 онд байгуулсан. Дэлхийн банкны ам.долларын зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,867,192 ам.доллар, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 804,800 ам.доллар байна. Тус зээлийн хүү Лондонгийн банк хоорондын захын 6 сарын хугацаатай ам.долларын (LIBOR) зээлийн хүү дээр жилийн 1 хувийг нэмсэнтэй тэнцүү байх ба үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.
- (b) Групп нь (a) дээр дурьдсан дамжуулан зээлдэх гэрээний дагуу Сангийн ямаар дамжуулан тодорхой хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор төгрөг болон гадаад валютаар нийт 6,250,000 зээлжих тусгай эрхээс хэтрэхгүй дүнгээр буюу нэмж хуваарилагдах эх үүсвэрээс зээлэх эрхтэй. Дэлхийн банк төгрөгийн зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,877 сая төгрөг, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,450 сая төгрөг байна. Энэхүү зээлийн хүү нь Монголбанкнаас зарласан төгрөгийн хугацаагүй хадгаламжийн өмнөх 12 сарын хугацааны дундаж хүүгээр тодорхойлогдох ба үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.
- (c) Групп нь Сангийн ямаар дамжуулан дэлхийн банк сургалтын хөтөлбөрийн зээлийн хүрээнд банк байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжүүлэх үүн дотор зээлийн шинжилгээ, судалгаа, эрсдлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан дотоод аудитийн чиглэлээр хүний нөөцийг бэлтгэн сургах зорилготойгоор дэлхийн банкнаас 300,000 ам.долларын зээлийг авсан. Тус хөтөлбөрийн хүрээндэх дэлхийн банк зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 245,151 ам.доллар, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 225,091 ам.доллар байна. Зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 2% бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлт хагас жил тутам төлөгдөж, 2025 оны 5 дугаар сард дуусгавар болно.

## **18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

### **Азийн хөгжлийн банк**

Азийн хөгжлийн банкны зээлүүд нь дараах зээлээс бүрдэж байна. Үүнд:

- (a) Групп нь банк нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийг шинэчлэх зорилгоор Монголбанкаар дамжуулан Азийн хөгжлийн банкнаас 134,164 ам.долларын зээлийг авсан. Зээлийн эх үүсвэрийн үлдэгдэлх үүсвэрийн зээл Азийн хөгжлийн банкнаас 84,970 ам.доллар, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 80,498 ам.доллар байна. Тус зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 1% ба үндсэн зээлийн эргэн төлөлт 2002 онд эхэлж, 30 жилийн туршид жилд нэг удаа төлөгдсөнөөр 2031онд дуусгавар болно.
- (b) Групп нь хөдөө аж ахуй, хөдөөг хөгжүүлэх зорилготой оролцогч аж ахуйн нэгжүүдийн нэмүү өртөгийн сүлжээг хөгжүүлэх, дэд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа, ажил, зөвлөх үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх зорилгоор олгох зээлийг Сангийн ямаар дамжуулан Азийн хөгжлийн банк 11,000,000 сая ам.доллархүртлэх дүнтэй эх үүсвэрээс санхүүжүүлхээр Азийн хөгжлийн банктай 2011 онд санхүүжилтийн гэрээг байгуулсан. Тус зээлийн хүрээнд олгогдсон дэд зээлүүд 2018 оны 6 дугаар сард эргэн төлөгдөж дуусах ба жилийн хүү нь 12% хүртэл байна. үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.
- (c) Дээр дурьдсан, санхүүжилтийн гэрээний хүрээнд ХХБ нь төгрөгийн зээл авч болох ба зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,400 сая төгрөг байна.

### **Олон улсын хөгжлийн ассоциаци**

Групп нь Норвегийн Банк Ресурс Лимитед (НБР)-тэй байгуулсан Твининг гэрээг санхүүжүүлэхээр олон улсын хөгжлийн ассоциациаас 600,000 ам.долларын зээлийг 1998 онд авсан. ОУХА-ийн зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 525,737 ам.доллар, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 513,737 ам.доллар байна. Зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 1% бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлт 2007 оны 8 дугаар сард эхлэж, 2037 оны 2 дугаар сард дуусгавар болно.

### **БНСУ-ын экспорт-импортын банк (КЭКСИМ)**

Групп нь 2004 онд БНСУ-ын экспорт-импортын банктай экспортын зээлийн гэрээг байгуулсан ба уг гэрээний хүрээнд 2,000,000 ам.долларыг БНСУ-ын экспортлогчдоос бараа, үйлчилгээ худалдан авагчдыг санхүүжүүлэх зорилгоор тэдэнд дамжуулан зээлдүүлнэ. Зээлийн дээд хэмжээ 2012 оны 7 дугаар сараас 30,000,000 ам.доллар болж өссөн. Шугамын зээлийн үлдэгдэл 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 15,914,691 ам.доллар болон 10,828,636 ам.доллар байна. Зээлийн шугамын хугацаа 2015 оны 12 дугаар сард дуусах ба зээлийн хүүгийн хэмжээг зээл авах бүрт экспорт-импортын банк харилцан адилгүй тогтоодог. Зээлийн үндсэн төлбөрийг санхүүгийн жилийн эцэст төлдөг.



## 18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)

### **ВТБ банк**

Групп харилцагчдын зээлийг санхүүжүүлэх зорилгоор ВТБ банкт хамтын санхүүжилтийн гэрээг тухай бүрт байгуулсан ба гэрээний дагуу ВТБ банк нь эрсдэлийг хүлээх ба зээлдэгчийн гаргасан зөрчилийн улмаас үүссэн хохиролыг Групп барагдуулахгүй болно. ВТБ банкны зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 7,500,000 ам.доллар, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар уг зээл бүрэн төлөгдсөн байна.

### **БНХАУ-ын экспорт-импортын банкны зээл (ТЭКСИМ)**

Групп 2004 онд БНХАУ-ын ТЭКСИМ банкт зээлийн гэрээ байгуулж, уг гэрээний хүрээнд Тайван улсын экспортлогчдоос тоног төхөөрөмж болон бусад бараа материал худалдан авагчдын зээлийг санхүүжүүлэх зорилгоор 6,000,000 ам.долларын зээл авах боломжтой болсон. 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 499,108 ам.доллар болон 9,215 ам.доллар зээлийн үлдэгдэл байна. Тус зээлийн хүү нь Лондонгийн банк хоорондын захын 6 сарын хугацаатай ам.долларын (LIBOR) зээлийн хүү дээр жилийн 1.25 хувийг нэмсэнтэй тэнцүү байна. Зээлийн ерөнхий гэрээ 2015 оны 1 дүгээр сар хүртэл сунгагдсан.

### **Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагийн (ЯОУХАА) зээл**

ЯОУХАА-ны зээл дараах зээлээс бүрдэж байна:

- (a) Групп нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, байгаль орчныг хамгаалах зээлийн төслийг санхүүжүүлэх зорилгоор Сангийн ямаар дамжуулан 2,981,000,000 иентэй тэнцэх хэмжээний төгрөгийн болон ам.долларын зээлийн авах эрхтэйгээр дамжуулан зээлдүүлэх гэрээг 2006 онд ЯОУХАА-тай байгуулсан. ЯОУХАА-ын ам.долларын зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 352,500 ам.доллар, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 290,500 ам.доллар байна. Тус зээлийн хүү лондонгийн банк хоорондын захын 6 сарын хугацаатай ам.долларын (LIBOR) зээлийн хүү дээр жилийн 1 хувийг нэмсэнтэй тэнцүү байх ба үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.
- (b) Дээрх зээлийн гэрээний дагуу авсан төгрөгийн зээлийн үлдэгдэл нь 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 878 сая төгрөг болон 1,930 сая төгрөг байна. Төгрөгийн зээлийн хүү нь Монгол банкнаас зарласан төгрөгийн хугацаатай хадгаламжийн өмнөх 12 сарын хүүгийн дундаж хүүтэй тэнцүү байна
- (c) Групп нь (a) дээр дурьдсан дамжуулан зээлдүүлэх гэрээний хүрээнд ЯОУХАА-ын төгрөгийн зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 878 сая төгрөг, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,930 сая төгрөг байна. Төгрөгийн зээлийн хүү нь Монгол банкнаас зарласан төгрөгийн хугацаатай хадгаламжийн өмнөх 12 сарын хүүгийн дундаж хүүтэй тэнцүү байна. Групп нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, байгаль орчныг хамгаалах зээлийн төслийг санхүүжүүлэх зорилгоор Сангийн ямаар дамжуулан 5,000,000,000 иентэй тэнцэх хэмжээний төгрөгийн болон ам.долларын зээлийн авах эрхтэйгээр дамжуулан зээлдүүлэх гэрээг 2011 онд ЯОУХАА-тай байгуулсан. ЯОУХАА-ын ам.долларын зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 930,000 ам.доллар, 14,382 сая төгрөг, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 930,000 ам.доллар, 13,772 сая төгрөг байна. Зээлийн хүү нь Монгол банкнаас зарласан төгрөгийн хугацаатай хадгаламжийн өмнөх 12 сарын хүүгийн дундаж хүүтэй тэнцүү байх ба үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

## **18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

### **Атлантик форфейтинг**

Групп нь 2009 онд тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хэрэглэгчдийн зээлийг санхүүжүүлэх зорилгоор Атлантик форфейтингтэй зээлийн гэрээг байгуулсан. Үлдэгдэл 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3,245,978 ам.доллар болон 302,493 ам.доллар байна. Зээлийн хугацаа 2014 оны 2 дугаар сард дуусна. Зээлийн хүүг хагас жил тутам төлөх ба үндсэн төлбөрийг хугацааны эцэст төлнө.

### **Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээл**

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээл дараах зээлээс бүрдэж байна:

- (а) Групп 2009 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамтай (ХХААХҮЯ) шугамын зээлийн гэрээ байгуулсан. ХХААХҮЯ нь энэхүү зээлд зориулж 30 тэрбум төгрөгийг төсөвлөсөн ба нийт Монголын арилжааны банкуудад олгох ба зээлийн хэмжээг банк тус бүрээр тогтоогоогүй байна. 2010 болон 2011 онд групп уг зээлийн гэрээг шинэчилсэн бөгөөд нийт төсвийг 2010 онд 60 тэрбум төгрөг, 2011 онд 150 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн. Энэхүү зээлийн хугацаа 2016 оны 6 сард дуусах ба жилийн 1.2 хувийн тогтмол хүүтэй. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл нь 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 19,318 сая төгрөг болон 15,697 сая төгрөг байна. Энэхүү зээлийн хөтөлбөрийн хүрээнд банк хөдөлмөрийн яамтай шинэ зээлийн гэрээ 2013 онд байгуулсан. Монгол Улсын Хөгжлийн Банк энэхүү зээлийн хөтөлбөрт оролцож байгаа ба 2013 онд 3,173 сая төгрөгийн дэд зээлийг банк санхүүжүүлсэн. Зээлийн хугацаа 2017 оны 12 дугаар сард дуусах ба Монгол Улсын Хөгжлийн Банк санхүүжилтээс хамааран жилийн 1.8 хувийн тогтмол хүүтэй. 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр зээлийн үлдэгдэл 3,122 сая төгрөг байна.
- (б) 2011 оны 10 дугаар сард групп нь ХХААХҮЯ-тай 2 дахь гэрээг ноос, ноолуурын салбарыг хөгжүүлэх зорилгоор зээлийн шугамын гэрээг байгуулсан. ХХААХҮЯ нь энэхүү зээлд зориулж 150 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Зээлийн хугацаа 2017 оны 8 дугаар сард дуусах ба жилийн 0.6 хувийн тогтмол хүүтэй. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 52,139 сая төгрөг болон 44,995 сая төгрөг байна.

### **Коммерц банк**

Групп нь 2011 онд Коммерц банктэй худалдааны санхүүжилтийн мастер гэрээг байгуулсан ба тус гэрээгээр бараа үйлчилгээ, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг харилцагчид дамжуулан олгож байна.

Зээлийн хэмжээ, зээл авах валют, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөгдөх огноо болон бусад нөхцөлүүдийг групп тухайн зээлдэгчийн нөхцөлийг харгалзан тохиролцоно. Зээлийн үлдэгдэл 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 13,299,538 ам.доллар болон 2,260,500 евро байна. Зээлийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 1,329,368 ам.доллар байсан. Зээлийн хугацаа 2014 оны 11 дүгээр сард дуусна.

### **БНХАУ-ын үйлдвэр, худалдааны банк**

Групп нь 2013 онд БНХАУ-ын үйлдвэр, худалдааны банкнаас 271,943 ам.долларын зээлийг БНХАУ-аас хийх импортыг дэмжих зорилгоор авсан. Зээлийн хүүг тухайн нөхцөлөөс хамааран БНХАУ-ын ардын банкнаас тодорхойлдог. Группын зээлийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,396,868 ам.доллар байсан ба 2013 оны 10 дугаар сард уг зээлийг эргүүлэн төлсөн.

## **18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

### **Ай Эн Жи Банк**

Групп 2011 оноос Ай Эн Жи Банкнаас 15,000,000 еврогийн худалдааны санхүүжилтийн шугамын хүрээнд дамжуулан зээлдүүлэх боломжтой болсон. Зээлийн хэмжээ, зээл авах валют, хүүгийн төвшин, олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон бусад нөхцөлүүдийг групп нь тухайн зээлдэгчийн нөхцөлийг харгалзан тохиролцоно. Энэхүү гэрээний дагуу 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 4,306,770 ам.доллар болон 2,469,929 ам.долларын зээлийн үлдэгдэлтэй байна. Мөн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 2,057,482 еврогийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн хугацаа 2014 оны 10 дугаар сард дуусна.

### **Баошанг банк**

Групп нь Баошанг банктэй олон төрлийн санхүүгийн зээлийн гэрээг байгуулсан ба Баошанг банк зээлийг харилцагчдадаа дамжуулан зээлдүүлдэг. Үүнд 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах зээлүүд байна:

- (a) Харилцагчдад олгосон ам.долларын зээлийн үлдэгдэл 720,036 ам.доллар байсан ба 2013 оны 11 дүгээр сард эргэн төлөгдсөн.
- (b) Харилцагчдад олгосон юанийн зээлийн үлдэгдэл 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ий байдлаар 4,074,272 юань болон 7,108,203 юань байгаа бөгөөд уг зээлүүд 2014 оны 12 дугаар сард хугацаа дуусгавар болж төлөгдөнө.

### **Монголын ипотекийн корпорацийн зээл**

Групп нь 2009 онд тодорхой ипотекийн зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпораци ХХК (цаашид МИК гэх) -д буцаан солих нөхцөлтэйгөөр шилжүүлсэн ба шилжүүлсэн зээлээс үүсэх эрсдэл ба өгөөжийг МИК-д шилжүүлээгүй тул уг шилжүүлсэн зээл нь бүртгэлээс хасах шалгуурыг хангаагүй гэж үзсэн. Иймээс групп нь эдгээр гүйлгээг барьцаатай зээллэг гэж бүртгэсэн. Эдгээр ажил гүйлгээний дэлгэрэнгүйг тодруулга 8-с үзнэ үү. Групп 2013 оны 7 дугаар сард ипотекийн зээл багцаа МИК-ээс буцаан худалдан авсан.

### **Сумитомо мицуй банк корпорацийн зээл (СМБК)**

Групп нь СМБК-тэй 45,000,000 ам.доллар хүртэлх зээлийн санхүүжилтийн гэрээг 2012 оны 3 дугаар сард байгуулсан. Эргэн төлөлтийн хугацаа болон хүүгийн түвшин нь 12-оос 18 хүртэлх сарын зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна. СМБК-аас санхүүжсэн зээлийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ийн өдөр 683,421 ам.доллар байсан ба 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 14,675,112 ам.доллар болон 1,087 сая иений зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн эргэн төлөлтийн эцсийн хугацаа 2014 оны 11 дүгээр сард дуусна.

### **Нидерландын хөгжлийн банк (ФМО)**

Групп нь 2012 оны 6 дугаар сард ФМО-тэй жижиг болон дунд үйлдвэрлэл байгууллагуудыг санхүүжүүлэх зорилготойгоор 10,000,000 ам.доллар хүртэлх сениор нөхцөлтэй зээлийн гэрээг байгуулсан. Америк долларын зээлийн үлдэгдэл нь 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 10,000,000 ам.доллар байна. Групп нь тогтмол болон хувьсах хүүгийн түвшинг сонгох боломжтой. Эргэн төлөлтийг хагас жил тутам төлөх боломжтой ба эргэн төлөлтийн сүүлийн хугацаа нь 2018 оны 6 дугаар сар байна.

### **Бэнк оф чайна(Хонг Конг)**

Групп нь БНХАУ-ын төв банк, (Хонг Конг)-тай богино хугацааны арилжааг санхүүжүүлэх нөхцөлтэй гэрээг 2012 оны 3 дугаар сард байгуулсан. Эргэн төлөлтийн хугацаа болон хүүгийн түвшин нь зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 395,360 ам.доллар байсан ба 2013 онд эргэн төлөгдсөн.

## **18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

### **Монголын хөрөнгийн бирж**

Групп нь Монголын арилжааны банкуудын оролцоотойгоор Монголын хөрөнгийн биржид хамтарсан санхүүжилтийн зээллэгийг зохион байгуулсан. 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар групп нь уг нөхцөлийн дагуу дараах зээлүүдийг зохион байгуулсан байна:

- (a) Нийт арилжааны банкуудийн зээлийн дүн нь 1,180,704 ам.доллар байна.
- (b) Энэ зээлийн дуусах хугацаа нь 2014 оны 5 дугаар сар ба жилийн 6.5 хувийн тогтмол хүүтэй байна

### **Чайна трэйд солюшнс**

Групп нь Чайна Трэйд Солюшнс-тэй богино хугацааны арилжааг санхүүжүүлэх нөхцөлтэй гэрээг байгуулсан. Зээлийн хэмжээ, зээл олгох валютын төрөл, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон бусад нөхцөлүүдийг групп нь тухайн зээлдэгчийн нөхцөлийг харгалзан тохиролцоно. Зээлийн үлдэгдэл 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 56,253 ам.доллар болон 114,131 ам доллар байна. Зээлийн хугацаа 2014 оны 4 дүгээр сард дуусна.

### **Монголбанкны дэд хөтөлбөр**

Групп нь Монголбанктай байгуулсан дунд хугацааны дэд хөтөлбөр болох “Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” зээлийн гэрээний хүрээнд 2013 онд хөтөлбөрт үргэлжлүүлэн оролцсон. Уг дэд хөтөлбөр нь дөрвөн дэд хөтөлбөртэй: i) хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах; ii) шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах; iii) импортын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний өртгийг бууруулах; болон iv) барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 40 гаруй зээлдэгчид хөтөлбөрийн уян хатан нөхцөлийн дагуу амжилттайгаар зээлийн санхүүжилтийг аваад байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн багцын үлдэгдэл 2013 оны 12 сарын 31-ний байдлаар 381,9 тэрбум төгрөг байна.

### **Монголбанк ипотекийн зээлийг санхүүжүүлэх хөтөлбөр**

Групп 2013 онд Монгол банктай “Монгол банкнаас арилжааны банкуудад олгох ипотекийн зээлийн санхүүжилт”-ийн гэрээ байгуулсан. Энэ хөтөлбөрийн зорилго нь амьжиргааны дундаж төвшний амьдралтай иргэдийг дэмжих болон эдгээр иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлснээр эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд хүрэх юм. Монголбанк зээлийн үлдэгдэл 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 362 тэрбум төгрөг байна. Энэхүү 235 тэрбум болон 127 тэрбум төгрөгийн зээлийн хугацаа 2014 оны 3 болон 6 дугаар саруудад тус тус дуусна. Зээлийн хүү нь жилийн тогтмол 4.00 хувь байна.

### **Стандарт чартеред банк**

Групп нь Монголын алт үйлдвэрлэгчдэд зээлдүүлэх зорилготойгоор Стандарт чартеред банк-тай 5,000,000 ам.долларын зээлийн гэрээг 2012 оны 5 дугаар сард байгуулсан. Зээлийг 2013 онд бүрэн төлсөн.

### **ЭмЖиЛизинг корпораци**

Шима сэйки ЭмЭфЖи компаниас машин механизм худалдан авдаг нэхмэлийн компаниудыг санхүүжүүлэх зорилгоор ЭмЖи Лизинг Корпорацитай 1,000,000 ам.долларын зээлийн гэрээг 2013 оны 9 дүгээр сард байгуулсан. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа 2015 оны 9 дүгээр сар юм. Зээлийн үлдэгдэл 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 28,357 ам.доллар байна.

## 18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)

### **ОХУ-ын хөдөө аж ахуйн банк (АрЭйчБи)**

АрЭйчБи банк 2009 онд дамжуулан зээлдүүлэх зорилготой худалдааны зээлийн санхүүжилтийн шугамыг баталсан. Групп дамжуулан зээлдүүлэх зорилготой 10 сая ам.доллар болон 9 сая ам.долларын зээлийн гэрээг 2013 оны 3 болон 8 дугаар саруудад байгуулсан. Эдгээр зээлүүдийн эргэн төлөгдөх хугацаа нь 2013 оны 9 дүгээр сар болон 2014 оны 8 дугаар саруудад дуусна. Зээлийн үлдэгдэл 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 9,000,000 ам.доллар байна.

Юникредит С.П.А.

Групп нь 2012 онд Итали дах Юникредит С.П.А.-аас худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын зөвшөөрөл авсан. Энэхүү зээлийн шугамаас гадна, групп нь Юникредит С.П.А.-аас Италиас бараа материал нийлүүлэх импортын гүйлгээг санхүүжүүлэх зээлийн эрхийн зөвшөөрөл авсан. Энэ зээл нь бараа материалын нийлүүлэлтийн үнийн дүнгийн 100 хүртэлх хувийг санхүүжүүлэх боломжтой. 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл нь 33,136 евро байна. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа 2014 оны 7 дугаар сар юм.

### **Худалдаа хөгжлийн банк хамтын санхүүжилтийн зээл**

Групп нь 2013 оны 9 дүгээр сард Нидерландын хөгжлийн санхүүгийн компани (ФМО)-тай А/Б хамтын санхүүжилтийн нөхцөлтэй зээлийн гэрээ байгуулсан. Нийт 82,000,000 ам.долларын хамтын санхүүжилтийн нөхцөлтэй зээл нь 2 хэсгээс бүрдэнэ: ФМО-ийн зохион байгуулж, Олон улсын Хөрөнгө Оруулалтын банк хамтарсан 35,000,000 ам.долларын хөгжлийн зээлийн хэсэг ("А" зээл); Ай Эн Жи Банк Эн Ви болон Ти Ди Би Капитал ХХК-ний зохион байгуулсан 47,000,000 ам.долларын арилжааны зээлийн хэсэг ("Б" зээл). 'Б' зээлийн оролцогчид нь АКА Ausfuhrkredit, Bank of Tokyo-Mitsubishi UFJ, Ltd., ВиТиБи Москва, Коммерз банк, Atlantic Forfaitierungs, ЭмЖи Лизинг корпораци болон Chailease групп байсан. Энэхүү зээлийг ХХБ-ны үйлчлүүлэгчдэд олгодог зээлийг оролцуулан ерөнхий санхүүжилтийн хэрэгцээг санхүүжүүлэхэд ашиглана. Зээлийн үндсэн төлбөр нь гэрээний дагуу төлөгдөх ба зээлийн хүүг 2018 оны 9 дүгээр сар хүртэл хагас жил тутам төлөгдөнө. Зээл бүрийн хүүгийн төвшин нь нэг жилд ногдох хувиар илэрхийлэгдэх ба LIBOR болон ахиу хүүгээс бүрдэнэ. Зээлийн үлдэгдэл 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 82,000,000 ам.доллар байна.

### **Каргил ТСФ Ази**

Групп 2013 оны 10 дугаар сард импортын бараа материалын худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор 33,000,000 ам.долларын худалдааны зээлийн санхүүжилтийн гэрээг байгуулсан. Зээлийн хугацаа 2014 оны 10 дугаар сард дуусна.



**19 Гаргасан өрийн бичиг**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Гаргасан өрийн бичиг, хорогдуулсан өртгөөр	460,563,148	600,525,865

Групп нь 2010 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хэрэгжиж эхлэсэн 300,000,000 ам.долларын Евро Дунд Хугацааны Өрийн бичиг (ЕДХӨБ) хөтөлбөрийн хүрээнд 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 150,000,000 ам.долларын сениор бондыг нэрлэсэн үнийн 99.353 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байна. Эдгээр бонд нь жилийн 8.5 хувийн хүүтэй ба хүүг хагас жил тутамд төлнө. Татварыг давхардуулж ногдуулахгүй байх тухай Монгол Улс, Сингапур Улс хоорондын хэлэлцээрийн дагуу Групп нь хөрөнгө оруулагчдад төлсөн бондын хүүд 5 хувийн татвар ноогдуулж, суутган төлөх үүрэгтэй ба ийнхүү төлж буй татварын төлбөр нь бодит хүүний хувийг нэмэгдүүлж байна.

Групп нь 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хэрэгжиж эхлэсэн 700,000,000 ам.долларын Евро Дунд Хугацааны Өрийн бичиг (ЕДХӨБ) хөтөлбөрийн хүрээнд 2012 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр 300,000,000 ам.долларын сениор бондыг нэрлэсэн үнийн 99.676 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2015 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр байна. Эдгээр бонд нь жилийн 8.5 хувийн хүүтэй ба хүүг хагас жил тутамд төлнө.

2012 болон 2013 оны тайлант жилүүдэд өрийн үнэт цаасны дансны үнэ нь бодит хүүгийн аргаар тооцоход 1,575,241 мянган төгрөг ба 3,330,660 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн болно.

**20 Хоёрдогч өглөг**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Хоёрдогч өглөг, хорогдуулсан өртөгөөр	66,036,156	55,528,846

2010 оны 10 дугаар сарын 09-ний өдөр эхэлсэн 300,000,000 ам.долларын Евро Дунд Хугацааны Өрийн бичиг (ЕДХӨБ) хөтөлбөрийн хүрээнд Групп нь 2010 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 25,000,000 ам.долларын хоёрдогч өглөгийг нэрлэсэн үнийн 99.999 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байна. 2011 оны 5 дугаар сарын 24-ний өдөр болон 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Групп нь нэмэлт 5,000,000 ам.доллар болон 10,000,000 ам.долларын хоёрдогч өглөгийг нэрлэсэн үнээр нь гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2016 оны 5 дугаар сарын 25-ны өдөр болон 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдөр ба хагас жилээр төлнө. Татварыг давхардуулж ногдуулахгүй байх тухай Монгол Улс, Сингапур Улс хоорондын хэлэлцээрийн дагуу Групп нь хөрөнгө оруулагчдад төлсөн хүүд 5 хувийн татвар ноогдуулж, суутган төлөх үүрэгтэй ба ийнхүү төлж буй татварын төлбөр нь бодит хүүний хувийг нэмэгдүүлж байна. Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа зогсоовол үнэт цаас гаргагчийн хадгаламж эзэмшигчид болон бусад өрийг барагдуулсны дараа хоёрдогч өглөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хангана.

2012 болон 2013 оны тайлант жилүүдэд хоёрдогч өглөгийн дансны үнэ нь бодит хүүгийн аргаар тооцоход 40,596 мянган төгрөг болон 52,176 мянган төгрөгөөр нэмэгдсэн болно.

**21 Бусад өр төлбөр**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Хуримтлагдсан хүүгийн өглөг	46,808,093	37,219,386
Клирингийн саатал	7,111,587	16,023,299
Спот арилжааны өглөг	276,314,010	65,414,600
Дривативийн өглөг	39,744,994	901,408
Ногдол ашгийн өглөг	-	365,945
Бусад	9,246,013	8,837,249
	<b>379,224,697</b>	<b>128,761,887</b>

**22 Хувьцаат капитал**

	Энгийн хувьцааны тоо		2013	2012
	2013	2012	Мян.төг	Мян.төг
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	3,305,056	3,305,056	16,525,280	16,525,280
Нэмж гаргасан	-	-	-	-
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>3,305,056</u>	<u>3,305,056</u>	<u>16,525,280</u>	<u>16,525,280</u>

Группийн 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт зөвшөөрөгдсөн 4,000,000 ширхэг хувьцаанаас 3,305,056 ширхэг хувьцаа эргэлтэнд байна. Групп 2012 онд нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 2,000 төгрөгөөс 5,000 төгрөг болгож өсгөсөн. Гаргасан бүх хувьцааны төлбөр бүрэн төлөгдсөн ба 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэгжийн нэрлэсэн үнэ 5,000 төгрөг байна.

**23 Халаасны хувьцаа**

	2013	2012
	Мян.төг	Мян.төг
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	2,620,626	6,001,872
Худалдсан	-	(3,381,246)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>2,620,626</u>	<u>2,620,626</u>

Грууд нь 2012 оны 2 дугаар сард халаасны хувьцааг (энгийн хувьцааны 4.78 хувь) Goldman Sachs-д худалдсан байна. 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар халаасны хувьцааны үлдэгдэл нь 126,015 ширхэг хувьцаа буюу нийт эргэлтэнд байгаа энгийн хувьцааны 3.81 хувийг эзэлж байна.

**24 Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй орлого**

	2013		
	Мян.төг		
Борлуулахаар эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгийн зах зээлийн үнийн цэвэр өөрчлөлт	Дахин үнэлгээний нөөц	Дүн	
	Эхний үлдэгдэл	25,807,646	18,555,196
Зах зээлийн үнэлгээ	12,433,069	-	12,433,069
Худалдсан	(24,087,109)	-	(24,087,109)
Эцсийн үлдэгдэл	<u>14,153,606</u>	<u>18,555,196</u>	<u>32,708,802</u>
	2012		
	Мян.төг		
Борлуулахаар эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгийн зах зээлийн үнийн цэвэр өөрчлөлт	Дахин үнэлгээний нөөц	Дүн	
	Эхний үлдэгдэл	3,736,050	18,702,066
Зах зээлийн үнэлгээ	22,071,596	-	22,071,596
Худалдсан	-	(146,870)	(146,870)
Эцсийн үлдэгдэл	<u>25,807,646</u>	<u>18,555,196</u>	<u>44,362,842</u>

**25 Хүүний орлого**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Зээл, урьдчилгаа	245,951,452	189,057,696
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	67,687,193	19,612,388
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	7,100,330	3,633,885
Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас	15,174	345,715
Хоёрдогч зээл	684,444	685,431
	<b>321,438,593</b>	<b>213,335,115</b>

**26 Хүүний зардал**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Хадгаламж	112,716,592	84,561,895
Авсан зээл, эх үүсвэр	23,632,501	8,354,075
Буцаан худалдан авах гэрээгээр худалдсан үнэт цаас	367,689	8,480,522
Гаргасан өрийн бичиг	56,922,469	30,177,065
Хоёрдогч өглөг	7,052,930	5,858,641
	<b>200,692,181</b>	<b>137,432,198</b>

**27 Шимтгэл хураамжийн цэвэр орлого**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
<b>Шимтгэл, хураамжийн орлого</b>		
Банкны шилжүүлэг	5,186,029	4,737,795
Картын үйлчилгээ	8,132,016	5,561,809
Зээлийн үйлчилгээ	8,582,285	6,708,523
Бусад	2,319,933	1,459,222
Шимтгэл, хураамжийн орлогын дүн	<b>24,220,263</b>	<b>18,467,349</b>
<b>Шимтгэл, хураамжийн зардал</b>		
Картын үйлчилгээний зардал	1,826,902	1,446,489
Бусад	867,555	621,337
Шимтгэл, хураамжийн зардлын дүн	<b>2,694,457</b>	<b>2,067,826</b>
<b>Шимтгэл, хураамжийн цэвэр орлого</b>	<b>21,525,806</b>	<b>16,399,523</b>

**28 Үйл ажиллагааны бусад орлого, цэвэр**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Ханшийн тэгшитгэлийн олз, цэвэр	32,411,745	12,845,020
Үнэт металлын арилжааны олз, цэвэр	1,217,060	649,390
Үнэт цаас худалдсаны олз	27,696,971	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний олз	7,171,395	-
Бусад	187,595	808,700
	<b>68,684,766</b>	<b>14,303,110</b>

**29 Үйл ажиллагааны зардал**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Боловсон хүчний зардал	18,558,043	16,475,250
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 10)	3,679,170	2,443,164
Биет бус хөрөнгийн хорогдуулга (Тодруулга 11)	488,894	321,883
Зар сурталчилгааны зардал	3,639,704	2,686,396
Түрээсийн зардал	2,790,943	2,390,011
Мэргэжлийн үйлчилгээний хөлс	1,299,978	1,327,080
Техникийн туслалцаа болон гадаадын банкны гуйвуулгын шимтгэл	870,112	988,842
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	18,772	34,435
Даатгалын зардал	4,075,927	74,795
Албан томилот	797,023	553,586
Бэлэн мөнгө цуглуулах зардал	949,888	805,856
Бичиг хэргийн зардал	611,870	552,100
Харилцаа холбооны зардал	2,998,039	790,369
Сургалтын зардал	296,530	329,383
Ашиглалтын зардал	429,921	351,166
Засвар үйлчилгээний зардал	305,747	314,438
Харуул, хамгаалалтын зардал	140,361	119,301
Зочин төлөөлөгчийн зардал	678,216	483,433
Тээврийн зардал	339,884	278,900
Мэдээлэл технологийн засвар үйлчилгээ	940,518	800,035
Бусад (*)	567,811	755,145
	<b>44,477,351</b>	<b>32,875,568</b>

(\*) Бусад үйл ажиллагааны зардалд зээл барагдуулахтай холбоотой зардал, цэвэрлэгээ болон удирдлагын бусад нэмэгдэл зардал орно.

**30 Үнэ цэнийн бууралтын (алдагдал) ба нөхөлт**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Зээлийн болзошгүй эрсдлийн (зардал), нөхөлт	(4,640,541)	4,305,103
Бусад хөрөнгө болон өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын (алдагдал), нөхөлт	(3,615,142)	2,249,333
	<b>(8,255,683)</b>	<b>6,554,436</b>

**31 Түрээс**

Групп нь зарим салбар, нэгжийн оффисын байрыг төрөл бүрийн түрээсийн гэрээгээр түрээсэлдэг. 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэг жилээс дээш хугацаатай, гэрээг цуцлах боломжгүй үйл ажиллагааны түрээсийн гэрээгээр түрээсэлсэн түрээсийн батлан даалт дараах байдалтай байна:

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Нэг жилийн доторхи	2,330,442	1,911,179
1 – 5 жил	2,558,621	2,944,352
Түүнээс дээш	-	-
	<b>4,889,063</b>	<b>4,855,531</b>

**32 Орлогын татварын зардал**

**Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын  
тайланд хүлээн зөвшөөрсөн:**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Орлогын татварын зардал – тайлант жил	19,164,321	14,817,338

**Орлогын албан татварын зардлын тохируулга:**

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Татварын өмнөх ашиг	158,428,006	77,944,062
Нийтлэг хувь хэмжээгээр ноогдуулсан орлогын албан татвар	39,157,002	19,036,016
ТНО-с хасагдахгүй зардалд ногдох татвар	486,895	259,692
Татвар ногдохгүй орлогод ногдох татвар	(20,304,258)	(4,419,312)
Охин компани дахь татварын түвшний нөлөөлөл	(172,906)	(58,617)
Бусад	(2,412)	(441)
	<b>19,164,321</b>	<b>14,817,338</b>

Групп нь Монгол Улсын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн дагуу 3 тэрбум хүртэлх төгрөгийн татвар ногдуулах орлогод 10%-ийн татвар, 3 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300 сая төгрөг дээр 3 тэрбумаас давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж татвар ногдуулж, төлөх үүрэгтэй.



**33 Ноогдол ашиг**

Групп 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлангийн жилд ноогдол ашиг зарлаагүй болно.

**34 Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс**

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан дах мөнгө түүнтэй адилтгах зүйлс нь касс дах бэлэн мөнгө болон ямар нэгэн хязгаарлалт хийгдээгүй төлбөр гүйцэтгэхэд бэлэн, бусад банк санхүүгийн байгууллага дах харилцах дансанд байршуулсан 3 сар хүртлэх хугацаатай мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ. 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан мөнгө, түүнтэй адилтгах зүйлс дараах байдалтай байна:

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
Бэлэн мөнгө, банкинд байршуулсан мөнгө (тодруулга 5)	1,090,245,012	444,813,254
Заавал байлгах нөөц	(689,022,571)	(250,535,821)
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс	<u>401,222,441</u>	<u>194,277,433</u>

### 35 Сегментийн тайлагнал

Сегментийн мэдээллийг Группын бизнесийн сегментэд үндэслэн тайлагнасан. Групп нь тайлангийн загвар болон бизнесийн сегментийг Группын удирдлагын ба дотоод тайлангийн бүтэц зохион байгуулалтад үндэслэн тодорхойлдог.

Хөрөнгө зохицуулалтын газар нь зах зээлийн шударга нөхцлийн дагуу бизнесийн сегментүүдэд капиталын хуваарилалт болон санхүүжилтийн өртгийг тусгахын тулд тэднээс хүү авч, хүү төлдөг.

Сегментийн капитал зардал гэж тайлант жилд, гүдвэллээс бусад биет бус хөрөнгө ба үндсэн хөрөнгө худалдан авахтай холбоотой гарсан нийт зардлыг хэлнэ.

#### Үйл ажиллагааны сегмент

Группын үйл ажиллагааны сегмент нь дараах үндсэн сегментүүдээс бүрдэж байна:

- *Байгууллагын банк* Байгууллагын харилцагчдын харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ.
- *Жижиг, Дунд Байгууллагын банк* Жижиг, Дунд байгууллагын харилцагчдын харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ. Групп нь тухайн харилцагчийн бизнесийн хэмжээнээс үл хамааран 300,000-1,000,000 ам.долларын санхүүжилт олгосон харилцагчдаа энэхүү ангилалд оруулдаг.
- *Иргэдийн банк* Карт эзэмшигчдийн карт, иргэдийн харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ.
- *Олон улсын, байгууллагын банк* Группын санхүүгийн үйл ажиллагаа болон арилжааны ажил гүйлгээнээс бүрдэнэ.
- *Хөрөнгө зохицуулалт* Зээл авах, өрийн бичиг гаргах, эрсдлийн удирдлагын зорилгоор дерватив хэрэгсэл хэрэглэх, богино хугацаат хадгаламж хийх, засгийн газрын болон компанийн өрийн бичиг зэрэг түргэн хөрвөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх зэргээр Группын санхүүжилт, эрсдлийн төвлөрсөн удирдлагаар хангах үүрэгтэй.
- *Бусад* Төв оффисын үйл ажиллагаа болон арын албаны үйлчилгээний хэсгийн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Энэ нь Группын үл хөдлөх хөрөнгө болон холбогдох тогтмол гардаг нэгдсэн зардлуудыг хянаж, зохицуулдаг.

2013 онд Банк нь Жижиг, Дунд байгууллагын харилцагчдын түвшингийн доод хязгаарыг 100,000 ам.доллараас 300,000 ам.доллар болгон өөрчилсөн. Үүний үр дүнд 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилд 100,000 ам.доллараас 300,000 ам.долларын хоорондох жижиг дунд байгууллагын харилцагчид нь жижиг буюу иргэдийн банкны сегментэд шилжсэн. Өмнөх сегментийн тайланг дахин тайлагнахад шаардлагатай мэдээлэл бэлэн байхгүй ба мэдээлэлийг боловсруулах зардал өндөр гарах шалтгааны улмаас Групп харьцуулах боломжтой сегментийн тайланг дахин тайлагнаагүй болно.

**35 Сегментийн тайлагнал (үргэлжлэл)**

(Мянган төгрөгөөр)

2013 оны 12 дугаар сарын 31-ний  
байдлаар

Сегментийн үр дүн  
Гадаад орлого

	Байгууллагын банк	Жижиг, дунд байгууллагын банк	Иргэдийн банк	Олон улсын, байгууллагын банк	Хөрөнгө зохицуулалт	Бусад	Нийт
Цэвэр хүүгийн орлого (зардал)	150,746,050	14,166,628	2,684,776	(60,291,014)	32,502,253	(19,062,281)	120,746,412
Хураамж, шимтгэлийн цэвэр орлого	5,809,919	126,820	14,262,019	11,803	138,082	1,177,163	21,525,806
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	1,075	286	9,293,237	98,168	24,279,396	35,012,604	68,684,766
Сегмент хоорондын орлого (зардал)	(81,709,447)	(4,556,591)	39,484,792	57,080,726	(41,064,059)	30,764,579	-
Нийт сегментийн орлого (зардал)	74,847,597	9,737,143	65,724,824	(3,100,317)	15,855,672	47,892,065	210,956,984
Үйл ажиллагааны зардал	(537,341)	(292,759)	(17,188,443)	(1,102,219)	(2,959,797)	(22,396,792)	(44,477,351)
Хараат компанийн ашгаас ногдох хувь	-	-	-	-	-	204,056	204,056
Үнэ цэнийн бууралтын (алдагдал), нөхөлт	(5,021,024)	(521,969)	(3,468,590)	-	-	755,900	(8,255,683)
Татварын өмнөх цэвэр ашиг (алдагдал)	69,289,232	8,922,415	45,067,791	(4,202,536)	12,895,875	26,455,229	158,428,006
Орлогын албан татварын зардал	-	-	-	-	-	-	(19,164,321)
Тайлант жилийн цэвэр ашиг	1,903,006,763	94,070,623	599,082,113	-	1,455,038,895	1,072,876,584	5,124,074,978
Сегментийн өр төлбөр	4,602,069	-	1,657,426,742	660,273,560	1,738,707,746	686,357,164	4,747,367,281
Хуваарилаагүй өр төлбөр	-	-	-	-	-	7,646,233	7,646,233
Нийт өр төлбөр	4,602,069	-	1,657,426,742	660,273,560	1,738,707,746	694,003,397	4,755,013,514
Элэгдэл, хорогдол	(16,500)	-	(1,914,829)	(4,816)	(9,216)	(2,222,702)	(4,168,063)
Капиталын зардал	26,241	-	3,430,696	7,912	18,162	49,527,010	53,010,021

**35 Сегментийн тайлагнал (ургэлжлэл)***(Мянган төгрөгөөр)***2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

	Байгууллагын банк	Жижиг, дунд байгууллагын банк	Иргэдийн банк	Олон улсын, байгууллагын банк	Хөрөнгө зохицуулалт	Бусад	Нийт
Сегментийн үр дүн							
Гадаад орлого							
Цэвэр хүүгийн орлого (зардал)	112,750,763	11,908,490	(9,451,651)	(30,178,128)	713,000	(9,839,557)	75,902,917
Хураамж, шимтгэлийн цэвэр орлого	5,263,310	86,916	10,216,153	14,366	169,889	648,889	16,399,523
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	212,682	272	19,628,506	106,117	(6,004,513)	360,046	14,303,110
Сегмент хоорондын орлого (зардал)	(63,009,077)	(4,036,226)	40,630,900	29,144,007	(14,853,775)	12,124,171	-
Нийт сегментийн орлого (зардал)	55,217,678	7,959,452	61,023,908	(913,638)	(19,975,399)	3,293,549	106,605,550
Үйл ажиллагааны зардал	(513,697)	(279,878)	(14,649,337)	(599,460)	(794,857)	(16,038,339)	(32,875,568)
Хараат компанийн ашгаас ногдох хувь	-	-	-	-	-	(2,340,356)	(2,340,356)
Үнэ цэнийн бууралтын (алдагдал), нөхөлт	5,014,736	185,592	(648,787)	-	-	2,002,895	6,554,436
Татварын өмнөх цэвэр ашиг (алдагдал)	59,718,717	7,865,166	45,725,784	(1,513,098)	(20,770,256)	(13,082,251)	77,944,062
Орлогын албан татварын зардал							(14,817,338)
Тайлант жилийн цэвэр ашиг							63,126,724
Сегментийн хөрөнгө	1,038,448,213	85,380,012	466,391,234	1,083,675	585,501,733	523,674,349	2,700,479,216
Сегментийн өр төлбөр	16,459,563	-	1,269,838,756	613,517,068	274,187,213	284,118,966	2,458,121,566
Хуваарилаагүй өр төлбөр						2,481,600	2,481,600
Нийт өртөлбөр	16,459,563	-	1,269,838,756	613,517,068	274,187,213	286,600,566	2,460,603,166
Элэгдэл, хорогдол	(4,666)	-	(1,341,242)	(1,325)	(10,661)	(1,405,779)	(2,763,673)
Капиталын зардал	8,864	-	5,134,240	3,826	2,591	50,684,618	55,834,139

**36 Холбоотой талуудтай хийсэн ажил, гүйлгээ**

Дараах байгууллагууд нь Группын холбоотой этгээдүүд юм. Үүнд:

- *Улаанбаатар хотын банк болон түүний охин компани* Группын ТУЗ-ын дарга нь Улаанбаатар хотын банкны ТУЗ-ын гишүүн юм.
- *Ти Ди Би Секуритис* Группын ТУЗ-ын дарга нь Ти Ди Би Секуритисыг эзэмшдэг.
- *Капитрон банк* Группын гол удирдлагууд нь Капитрон банкны хувьцаа эзэмшигч юм.
- *Монголын Ипотекийн Корпораци ХХК (“МИК”)* Групп нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ойролцоогоор Монголын Ипотекийн Корпорацийн энгийн хувьцааны 35.6 хувийг эзэмшдэг. (тодруулга 7)
- *Монгол Женерал Лизинг ХХК болон түүний охин компани* Групп нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монгол Женерал Лизинг ХХК-ийн энгийн хувьцааны 55 хувийг эзэмшдэг.

Группын гүйцэтгэх удирдлагууд болон тэдгээрийн хамаатан садангууд нь мөн группын холбоотой этгээдүүд юм.

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ нь дараах байдалтай байна:

	<b>2013</b> <b>Мян.төг</b>	<b>2012</b> <b>Мян.төг</b>
<b>Улаанбаатар хотын банк болон охин компани:</b>		
<b>12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил</b>		
Хүүгийн орлого	7,840,065	4,038,709
Хүүгийн зардал	(747,770)	(539,625)
Цэвэр шимтгэл, хураамжийн орлого	(33)	(62)
<b>12 дугаар сарын 31-ний өдрөөр</b>		
Банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	174,640,914	59,207,086
Банк болон бусад санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	108,270,500	6,960,500
Зээл болон урьдчилгаа	9,924,600	7,934,497
Хоёрдогч өглөг (тодруулга 9)	4,000,000	4,000,000
Хуримтлагдсан хүүгийн орлого	47,255	38,451
Хуримтлагдсан хүүгийн зардал	33,208	381
<b>Капитрон банк:</b>		
<b>12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил</b>		
Хүүгийн орлого	383,960	384,641
Хүүгийн зардал	(41,559)	(11,605)
<b>12 дугаар сарын 31-ний өдрөөр</b>		
Банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	6,000,000	458,958
Банк болон бусад санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	2,100,707	-
Хоёрдогч өглөг (тодруулга 9)	3,000,000	3,000,000
Хуримтлагдсан хүүгийн орлого	126,260	125,923
Хуримтлагдсан хүүгийн зардал	38,221	-



36 Холбоотой талуудтай хийсэн ажил, гүйлгээ (үргэлжлэл)

	2013 Мян.төг	2012 Мян.төг
<b>Монголын Ипотекийн Корпораци:</b>		
<b>12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил</b>		
Хүүгийн орлого	136,411	330,845
Хүүгийн зардал	(107,952)	(281,996)
<b>12 дугаар сарын 31-ний өдрөөр</b>		
Хөрөнгө оруулалтын үнэт цаас (тодруулга 7)	108,475,200	1,697,000
Зээлийн эх үүсвэр (тодруулга 18)	-	1,531,618
Хуримтлагдсан хүүгийн орлого	136,411	14,328
Хуримтлагдсан хүүгийн зардал	-	13,237
<b>Ти Ди Би Сектрутис:</b>		
<b>12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил</b>		
Хүүгийн орлого	777,345	-
<b>12 дугаар сарын 31-нээр</b>		
Зээл болон урьдчилгаа	8,270,500	-
Хуримтлагдсан хүүгийн орлого	85,002	-
<b>Ти Ди Би Лизинг</b>		
<b>12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил</b>		
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	203,527	-
Хүүгийн зардал	(96,560)	-
<b>12 дугаар сарын 31-ний өдрөөр</b>		
Бусад хөрөнгө	153,445	-
Банк болон бусад санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	3,256,655	-
<b>Монгол Женерал Лизинг ХХК</b>		
<b>12 дугаар сарын 31-ний өдрөөр</b>		
Хараат компани дах хөрөнгө оруулалт болон хамтарсан хөрөнгө оруулалт	1,773,610	-
<b>Гүйцэтгэх удирдлага:</b>		
<b>12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил</b>		
Хүүгийн орлого	493,546	376,725
<b>12 дугаар сарын 31-ний өдрөөр</b>		
Зээл болон урьдчилгаа	6,508,359	5,117,586
Хуримтлагдсан хүүгийн орлого	24,647	22,827

Гүйцэтгэх удирдлагад олгосон зээл нь Группын зээл ба урьдчилгааны дүнд багтсан ба гүйцэтгэх удирдлагад олгосон ипотекийн зээлийн хүү нь зах зээлийн хүүгээс доогуур байна. Ипотекийн зээлд зээлдэгчдийн худалдан авч буй үл хөдлөх хөрөнгүүдийг барьцаалсан.

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдэд гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ын гишүүдэд төлсөн нийт цалин хөлс урамшуулал, тэтгэмж нь 4,011,647 мянган төгрөг болон 3,735,260 мянган төгрөг ) байна.

**37 Санхүүгийн хэрэгслүүд**

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)

**2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

	Хэлцэл	Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт	Зээл болон авлага	Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	Санхүүгийн өр төлбөр (хорогдуулсан өртгөөр)	Нийт
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
Бэлэн мөнгө, бусад банкинд байршуулсан хөрөнгө	-	-	1,090,245,012	-	-	1,090,245,012
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	-	160,500,000	-	724,612,661	-	885,112,661
Зээл ба урьдчилгаа	-	-	2,530,557,178	-	-	2,530,557,178
Хоёрдогч зээл	-	-	7,000,000	-	-	7,000,000
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	64,719,231	-	-	-	-	64,719,231
Спот хэлцлийн авлага	-	-	276,359,629	-	-	276,359,629
Бусад хөрөнгө (*)	-	-	50,595,083	-	-	50,595,083
	<b>64,719,231</b>	<b>160,500,000</b>	<b>3,954,756,902</b>	<b>724,612,661</b>	<b>-</b>	<b>4,904,588,794</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
Хадгаламж	-	-	-	-	2,139,692,149	2,139,692,149
Банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	-	-	-	-	172,109,699	172,109,699
Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас	-	-	-	-	372,650,503	372,650,503
Авсан зээл	-	-	-	-	1,157,090,928	1,157,090,928
Гаргасан өрийн бичиг	-	-	-	-	460,563,148	460,563,148
Хоёрдогч өглөг	-	-	-	-	66,036,156	66,036,156
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	39,744,994	-	-	-	-	39,744,994
Спот хэлцлийн өр төлбөр	-	-	-	-	276,314,010	276,314,010
Бусад өр төлбөр (**)	-	-	-	-	62,729,518	62,729,518
	<b>39,744,994</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4,707,186,111</b>	<b>4,746,931,105</b>

(\*) Урьдчилж төлсөн зардал, үнэт металл болон бараа материал ороогүй болно.

(\*\*) Урьчилж төлөгдсөн орлого ороогүй болно..

## 37 Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

(Мянган төгрөгөөр)

2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

	Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт					Нийт
	Хэлцэл	Зээл болон авлага	Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	Санхүүгийн өр төлбөр (хорогдуулсан өртгөөр)		
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
Бэлэн мөнгө, бусад банкинд байршуулсан хөрөнгө	-	444,813,254	-	-	444,813,254	
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	-	-	361,628,276	-	456,801,610	
Зээл ба урьдчилгаа	-	1,533,271,823	-	-	1,533,271,823	
Хоёрдогч зээл	-	7,000,000	-	-	7,000,000	
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	283,676	-	-	-	283,676	
Спот хэлцлийн авлага	-	65,414,600	-	-	65,414,600	
Бусад хөрөнгө (*)	-	31,489,904	-	-	31,489,904	
	283,676	2,081,989,581	361,628,276	95,173,334	2,539,074,867	
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
Хадгаламж	-	-	-	1,402,326,763	1,402,326,763	
Банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	-	-	-	36,518,483	36,518,483	
Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас	-	-	-	1,495,638	1,495,638	
Зээлийн эх үүсвэр	-	-	-	232,964,084	232,964,084	
Гаргасан өрийн бичиг	-	-	-	600,525,865	600,525,865	
Хоёрдогч өглөг	-	-	-	55,528,846	55,528,846	
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	901,408	-	-	-	901,408	
Спот хэлцлийн өр төлбөр	-	-	-	65,414,600	65,414,600	
Бусад өр төлбөр (**)	-	-	-	62,314,408	62,314,408	
	901,408	-	-	2,457,088,687	2,457,990,095	

(\*) Урьчилж төлсөн зардал, үнэт металл болон бараа материал ороогүй болно.

(\*\*) Урьчилж төлөгдсөн орлого ороогүй болно.

**37 Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)**

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн хөрөнгийн цэвэр олз (гарз) дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)

**2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

	Хүүний орлого	Хүүний зардал	Шимтгэл, хураамжийн орлого	Үйл ажиллагааны бусад орлого	Үнэ цэнийн бууралтын (алдагдал), нөхөлт	Цэвэр олз (гарз)	Бусад дэлгэрэнгү й орлого
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт	34,142,479	-	-	-	-	34,142,479	-
Зээл ба авлага	253,751,400	-	8,582,285	-	(4,639,927)	257,693,758	-
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	33,544,714	-	-	27,735,140	-	61,279,854	(11,654,040)
Үүсмэл санхүүгийн хөрөнгө болон спот хэлцэл	-	-	-	32,274,066	-	32,274,066	-
